



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙН
ҮЕД БОЛОВСРОЛЫН ЧАНАР,
ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ



Төслийн дугаар: L3594-MON

2020 оны 11 сар

МОНГОЛ УЛС: ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙН ҮЕД БОЛОВСРОЛЫН ЧАНАР,
ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

**СӨБ ба БДБ-ын багш, удирдах ажилтны хөгжлийн бодлого, урт
ба дунд хугацааны төлөвлөгөө болон зарим судалгааны
зөвлөмжид хийсэн кластер анализын тайлан**

Тайланг хүлээн авсан: (Т.Ням-Очир, БШУЯ-ны БДБГ-ын дарга)

Тайланг хүлээлгэн өгсөн: (Н.Нэргүй, Зөвлөх багийн гишүүн)

..... (Ч.Нямгэрэл, Зөвлөх багийн гишүүн)

УЛААНБААТАР

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГ	3
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	4
ХҮСНЭГТИЙН ХАГСААЛТ	5
УДИРТГАЛ	6
Судалгааны үндэслэл.....	6
Судалгааны зорилго, зорилт	6
Судалгааны тайлангийн бүтэц.....	6
НЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	7
Судалгааны объект, хамрах хүрээ, хязгаарлалт	7
Судалгааны өгөгдөл цуглуулалт	7
Судалгааны дизайн, арга хэрэгсэл боловсруулалт	8
ХОЁР. БАГШЛАХУЙН КЛАСТЕР	12
2.1. Боловсролын кластер.....	12
2.2. Багшлахуйн кластерийн тогтолцоо	13
ГУРАВ. КЛАСТЕР ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН (ТООН ШИНЖИЛГЭЭ).....	18
3.1. Урт ба дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөгөөний кластер шинжилгээний дүн.....	18
3.1.1. Багшлахуйн кластерийн ерөнхий бүтцийн гол шалгуураар илрүүлсэн үр дүн ...	19
3.1.2. Багшлахуйн кластерийн үндсэн бүтцийн дэд шалгуураар илрүүлсэн үр дүн.....	20
3.1.3. Багшлахуйн кластерийн дэлгэрэнгүй бүтцийн индикаторуудаар илрүүлсэн үр дүн.....	26
3.2. Боловсролын салбарт хийгдсэн судалгааны зөвлөмжүүдийн кластер шинжилгээний үр дүнгүүд	29
3.2.1. Багшлахуйн кластерийн ерөнхий бүтцийн гол шалгуураар илрүүлсэн үр дүн ...	30
3.2.2. Багшлахуйн кластерийн үндсэн бүтцийн дэд шалгуураар илрүүлсэн үр дүн.....	32
3.2.3. Багшлахуйн кластерийн дэлгэрэнгүй бүтцийн индикаторуудаар илрүүлсэн үр дүн.....	36
ДӨРӨВ. МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН (ЧАНАРЫН ШИНЖИЛГЭЭ).....	40
4.1. “Алсын хараа 2020-2050: Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого”-д хийгдсэн магадлан шинжилгээний үр дүн	40
4.1.1. Монгол Улсын хөгжлийн загвар.....	41
4.1.2. Боловсролын салбарын урт хугацааны хөгжлийн бодлого.....	45
4.2. “Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-т суурилсан магадлан шинжилгээний үр дүн	46
4.2.1. ЗГҮАХ- “Чадварлаг багш” арга хэмжээ	47
4.2.2. Боловсролын хүрээлэнгийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчилж, чадавхийг дээшлүүлнэ (ЗГҮАХ: 2.3.13).....	48
4.2.3. СӨБ, БДБ, багш бэлтгэх боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрүүд (ЗГҮАХ: 2.3.4, 4.2.9, 2.3.16, 2.3.11, 2.5.4)	50
4.2.4. Багшлахуйн хөгжил-Боловсролын салбарын цахим шилжилт.....	61

4.2.5. Чанарын гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ	65
4.2.6. Багшийн ажлын норм норматив-Цалин хөлс, нийгмийн халамж, хамгаалал	68
4.2.7. Багш ба ажиллах орчин нөхцөлийн өөрчлөлт	71
4.2.8. Түншлэл-Багшийн хөгжил	73
4.3.Боловсролын салбарт хийгдсэн судалгааны магадлан шинжилгээний үр дүн.....	74
ДҮГНЭЛТ, ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ	77
Дүгнэлт.....	77
Ерөнхий зөвлөмж.....	80
ХАВСРАЛТ	82
НОМ ЗҮЙ	88

ТОВЧИЛСОН ҮГ

БДБ	Бага, дунд боловсрол
БК	Багшлахуйн кластер
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГ	Засгийн Газар
ЗГҮАХ	Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөр
ЗГАХТ	Засгийн газрын арга хэмжээний төлөвлөгөө
ИДС	Их дээд сургууль
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
МТ	Мастер төлөвлөгөө (Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө: 2021-2030)
МУХҮЧ	Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Багшлахуйн хөгжлийн кластерийн ерөнхий бүтэц.....	14
Зураг 2. Багшлахуйн дэд кластеруудад харгалзах 3 дахь эрэмбийн агуулга (индикатор)-ын тоо	15
Зураг 3. Багшлахуйн кластерийн ерөнхий бүтцийн шалгуураар үнэлэгдсэн үр дүн (илэрцийн тоогоор).....	20
Зураг 4. "БК0. Мэргэжлийн чиг баримжаа өгөх" үе шатны агуулгын илэрц	22
Зураг 5. "БК1. Багш бэлтгэх сургуульд элсүүлэх" төлөв байдлын агуулгын илэрц	22
Зураг 6. "БК2. Багш бэлтгэх" үе шатны агуулгын илэрц.....	23
Зураг 7. "БК3. Багшийг ажилд авах" төлөв байдлын агуулгын илэрц	24
Зураг 8. "БК4. Багшаар ажиллах" үе шатны агуулгын илэрц.....	24
Зураг 9. "БК5. Тэтгэвэр тогтоож, ажлаас чөлөөлөх" төлөв байдлын агуулгын илэрц.....	25
Зураг 10. "БК6. Зөвлөгөө, туслалцаа авах" үе шатны агуулгын илэрц	26
Зураг 11. Дэд шалгууруудад хамаарах индикаторын болон агуулгын илэрцийн тоо	28
Зураг 12. Багшлахуйн кластерийн ерөнхий бүтцийн шалгуураар үнэлэгдсэн үр дүн.....	31
Зураг 13. "БК0. Мэргэжлийн чиг баримжаа өгөх" үе шатны агуулгын илэрц	32
Зураг 14. "БК1. Багш бэлтгэх сургуульд элсүүлэх" төлөв байдлын агуулгын илэрц	32
Зураг 15. "БК2. Багш бэлтгэх" үе шатны агуулгын илэрц.....	33
Зураг 16. "БК3. Багшийг ажилд авах" төлөв байдлын агуулгын илэрц	33
Зураг 17. "БК4. Багшаар ажиллах" үе шатны агуулгын илэрц.....	34
Зураг 18. "БК5. Тэтгэвэр тогтоож, ажлаас чөлөөлөх" төлөв байдлын агуулгын илэрц.....	35
Зураг 19. "БК6. Зөвлөгөө, туслалцаа авах" үе шатны агуулгын илэрц	36
Зураг 20. Дэд шалгууруудад хамаарах индикаторын болон агуулгын илэрцийн тоо	38

ХҮСНЭГТИЙН ХАГСААЛТ

Хүснэгт 1. Судалгааны нэгж объектын тоо ба багшлахуйн кластерт холбогдох байдал (баримт бичиг бүрээр).....	7
Хүснэгт 2. Судалгааны “нэгж объект”-ын тоо (хамаарлын төрлөөр).....	9
Хүснэгт 3. Багшлахуйн кластер дахь шулуун ба эргэх холбоо.....	15
Хүснэгт 4. Багшлахуйн кластерийн тогтолцооны үндсэн бүтэц (1 ба 2 дахь эрэмбийн агуулгаар)	17
Хүснэгт 5. Тоон анализ хийгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөнүүд ба харгалзах Sheet-ийн нэр..	18
Хүснэгт 6. Багшлахуйн кластерийн ерөнхий бүтцийн шалгуураар үнэлэгдсэн үр дүн (илэрцийн тоогоор).....	19
Хүснэгт 7. Багшлахуйн кластерийн гол ба дэд шалгуур болон индикаторын тоо ба тэдгээрт харгалзах илэрцийн тоо	26
Хүснэгт 8. Давтамж олонтой илэрц бүхий 21 индикатор.....	28
Хүснэгт 9. Тоон анализ хийгдсэн судалгааны тайлан ба харгалзах Sheet-ийн нэр (илэрцийн тоогоор)	29
Хүснэгт 10. Багшлахуйн кластерийн ерөнхий бүтцийн шалгуураар үнэлэгдсэн үр дүн (илэрцийн тоогоор).....	30
Хүснэгт 11. Багшлахуйн кластерийн гол ба дэд шалгуур болон индикаторын тоо ба тэдгээрт харгалзах илэрцийн тоо	37
Хүснэгт 12. Давтамж олонтой илэрц бүхий 32 индикатор.....	39
Хүснэгт 13. Боловсролд хамаарах Монгол Улсын суурь үнэт зүйл.....	41
Хүснэгт 14. “Алсын хараа-2050: 2021-2030 онд үндэсний түвшинд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тусгагдсан багшлахуйтай холбоотой үйл ажиллагаанууд	44
Хүснэгт 15. “БК4.4. Ялгаатай зорилтод бүлгүүдэд багшлах мэдлэг, ур чадварт тавигдах шалгуур, индикаторууд”-ийн хувьд магадлан шинжилгээний дүнгийн харьцуулалт.....	75
Хүснэгт 16. Тоон шинжилгээний хэмжигдэхүүнүүд ба тэдгээрийн үзүүлэлтүүд	77
Хүснэгт 17. Магадлан шинжилгээний дүнгийн харьцуулалт	77

УДИРТГАЛ

Судалгааны үндэслэл

Энэхүү судалгааг “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл” L3594-MON”-ийн санхүүжилтээр БШУЯ болон Нэрэндоогийн Нэргүй, Чойжилсүрэнгийн Нямгэрэл нарын бүрэлдэхүүнтэй судлаачдын багийн хооронд байгуулсан хөлсөөр ажиллах тухай БШУ/29 ба БШУ/27 тоот гэрээ, түүнд хавсрагдсан БШУ-ны Сайдын 2020 оны А/145 тоот тушаалын хоёр ба гуравдугаар хавсралтыг тус тус үндэслэн гүйцэтгэв.

Сайдын тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан ажлын төлөвлөгөөний *нэг дэх хэсэгт* тусгагдсан эхний бүтэгдэхүүн болох **“СӨБ ба БДБ-ын багш, удирдах ажилтны хөгжлийн бодлого, урт ба дунд хугацааны төлөвлөгөө болон зарим судалгааны зөвлөмжид хийсэн кластер анализын тайлан”**-г дараах хэлбэрээр холбогдох Excel файлуудын хамт гэрээнд заасан хугацаанд багтаан захиалагч талд хүлээлгэж өгөв. Үүнд:

1. Тайлангийн Word файл: "Report-03-07-17 Nov, 2020.docx"
2. Алсын хараа-2050 баримт бичгийн шинжилгээний Excel файл: "Алсын хараа 2050, Б-1,2 Хүрэх үр дүн, Үйл ажил., Шалгуур-10-Oct.xlsx"
3. ЗГҮАХ болон Боловсролын дунд хугацааны (Мастер) төлөвлөгөөний шинжилгээний Excel файл: "ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр-2020-2024-Анализ-Nov-08-final.xlsx"
4. 2018-2020 онд хийгдсэн боловсролын салбарын зарим судалгааны тайлангийн шинжилгээний Excel файл: "Судалгааны-тайлангууд-Зөвлөмж-Стратеги-Асуудал.xlsx"

Судалгааны зорилго, зорилт

Тус судалгааны **зорилго нь** багшийн асуудлаар төрөөс баримтлах хөгжлийн бодлого, урт, дунд хугацааны төлөвлөгөө, 2018 оноос хойш хийгдсэн томоохон судалгааны зөвлөмжүүдэд дүн шинжилгээ хийж, зөвлөмж боловсруулахад оршино.

Үндэсний хэмжээнд “Багш боловсролын хөгжлийн бодлого, стратеги, төлөвлөлтийн”-ийн түвшин дэх ерөнхий дүр зургийг гаргах агуулга бүхий энэхүү судалгааны зорилгын хүрээнд дараах **зорилтуудыг** хэрэгжүүлсэн. Үүнд:

- a) Сүүлийн жилүүдэд хийгдсэн салбарын томоохон судалгааны тайлангууд болон эрх зүйн актууд, баталгаажихаар бэлэн болсон төслүүдэд дурьдагдсан багшийн хөгжлийн талаар баримтлах бодлого, стратегийн зорилтууд, үйл ажиллагааны чиглэлүүд болон тэдгээрийг хэрэгжүүлэх талаар гаргасан санал зөвлөмжийг нэгтгэсэн өгөгдлийн сан бүрдүүлэх, багшлахуйтай холбоотой зорилт, хүрэх үр дүнг зэрэглэн ангилах
- b) Багшлахуй (багшлах үйл явц)-н кластерийн тогтолцоо боловсруулах
- c) Судалгааны дизайн, автоматчилагдсан арга хэрэгслийг боловсруулах
- d) Багшлахуйн кластерт суурилан судалгааны ялгасан объектүүдэд магадлан шинжилгээ хийж, шинжээчийн зөвлөмж бичиж, хавсралтууд бэлтгэх
- e) Кластер шинжилгээний үр дүнг боловсруулах
- f) Дүгнэлт, ерөнхий зөвлөмж боловсруулах

Судалгааны тайлангийн бүтэц

Судалгааны тайлан нь Зургийн жагсаалт, Хүснэгтийн жагсаалт, Удиртгал болон 11 дэд бүлэг, 14 хэсэг бүхий “Судалгааны арга зүй”, “Багшлахуйн кластер”, “Кластер шинжилгээний үр дүн (тоон шинжилгээ)”, “Магадлан шинжилгээний үр дүн (чанарын

шинжилгээ)” гэсэн үндсэн 4 бүлэг, Дүгнэлт, зөвлөмж, Хавсралт, Ном зүй гэсэн агуулгын бүтэцтэй.

НЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэхүү судалгаа нь баримт бичгийн судалгааны төрөлд хамаарна. Уг судалгааг гүйцэтгэхдээ Кластер анализ (Cluster analysis), Магадлан шинжлэх арга (Expertise)-уудыг хэрэглэсэн бөгөөд судалгааны ажлын үр дүнг нэгтгэх, боловсруулахад VBA код ашиглан автоматжуулалт хийсэн Microsoft Excel-ийн файл-хэрэгслийг бэлтгэсэн. Тэдгээрийн нарийвчилсан аргачлалын талаар Тайлангийн 1.3 “Судалгааны дизайн, арга хэрэгсэл боловсруулалт” дэд бүлгээс тодруулан танилцана уу.

Судалгааны объект, хамрах хүрээ, хязгаарлалт

Багшлахуйн хөгжлийн асуудалтай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас баталсан урт ба дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн 5 баримт бичиг болон боловсролын салбарт 2018 оноос хийгдсэн томоохон 6 судалгааны тайланг тус тус баримт бичгийн судалгаанд хамруулсан.

Судалгааг сургуулийн өмнөх боловсрол (СӨБ) ба бага дунд боловсролын түвшнээр хязгаарлаж (БДБ), сургалтын байгууллагын багш, удирдах ажилтанд асуудлыг хамарч хийсэн.

Судалгааны өгөгдөл цуглуулалт

Баримт бичгийн судалгаанд сонгогдсон нийт 11 баримт бичгийг судалж, тэдгээрээс тоон ба чанарын анализ хийх зориулалттай 21+7=28, судалгааны автоматчилагдсан үр дүнгийн 3+3=6, нийт 34 Sheet бүхий 3 Excel файлын мэдээлэл, өгөгдлийн сан бүрдүүлсэн. Уг өгөгдлийн сангаас нийт 1420 судалгааны нэгж объект (Excel файлын нүд)-ыг үнэлж, багшлахуйн кластертийн агуулгатай холбогдох байдлаар нь “шууд хамааралтай”, “дам хамааралтай”, “хамааралгүй” гэж 3 төрөлд ангилсан. Эдгээр ангиллын дагуу авч үзэхэд нийт нэгж объектийн 17.3 хувь (245) нь “шууд хамааралтай”, 15.6 хувь (222) нь “дам хамааралтай”, 67.1 хувь (953) нь “хамааралгүй” хэмээн тодорхойлогдсон (Хүснэгт 1.).

Түүнчлэн тухайн Sheet бүр дэх мэдээллийн үнэн бодит байдлыг хянан магадлахад зориулж, уг мэдээллийг авсан эх сурвалжийг холбогдох сайтын линкээр, боломжгүй тохиолдолд хэвлэмэл материалын холбогдох хэсгийг “Object” байдлаар хавсаргаж өгсөн болно. “Object”-ийн товч буюу зураг дээр очоод хулганы баруун товчийг 2 удаа ойрхон товшиход pdf файл нээгдэх болно.

Хүснэгт 1. Судалгааны нэгж объектын тоо ба багшлахуйн кластерт холбогдох байдал (баримт бичиг бүрээр)

№	Баримт бичиг	Судалгааны нэгж объектын тоо			
		Шууд холбоотой	Дам холбоотой	Холбоогүй	Нийт
1	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого (УИХ-ын 2020 оны 05 сарын 13-ны 52-р тогтоол)	26	58	139	223
2	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл (УИХ, 2020 оны 8-р сарын 28-ны өдрийн 23-р тогтоол)	2	6	22	30
3	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	9	16	11	36

	(УИХ-ын 2020 оны 08 сарын 28-ны өдрийн 24-р тогтоол)				
4	Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө: ЗГХЭГ-т хүргүүлсэн төсөл: 2020.09.28-ний төсөл (УИХ-ын 2020 оны ??? сарын ??? өдрийн ???-р тогтоол)	46	40	315	401
5	Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө: 2021-2030. (БСШУ-ны сайдын 2020 оны 10-р сарын 09-ны өдрийн 96 тоот тушаал)	37	52	178	267
6	Боловсролын суурь мэдээллийн тайлан 2018	36	25	47	108
7	Монгол Улсын боловсролын бодлогын тойм шинжилгээ, 2019	15	12	48	75
8	Сургуулийн өмнөх боловсролын дэд салбарын дүн шинжилгээ /Боловсролын салбарын мастер төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэх техник туслалцааны төсөл, Дугаар 51103-001/, 2019	5	0	20	25
9	Бага, дунд боловсролын дэд салбарын судалгааны тайлан /Боловсролын салбарын мастер төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэх техник туслалцааны төсөл, Дугаар 51103-001/, 2019	65	5	139	209
10	Дээд боловсролын дэд салбарын судалгааны тайлан /Боловсролын салбарын мастер төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэх техник туслалцааны төсөл, Дугаар 51103-001/, 2019	0	8	21	29
11	Монгол улсын Засгийн газрын 2021-2030 он хүртэлх Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөний үнэлгээ (Роберт Си Уолс), 2020 оны 4 сар	4	0	13	17
	Нийт	245	222	953	1420

Судалгааны дизайн, арга хэрэгсэл боловсруулалт

Судалгааны зорилго болон хамрах хүрээг харгалзан үзэж дараах төрлийн судалгааны аргуудыг ашигласан. Үүнд:

- Баримтын судалгаа (Disk review)
- Кластер анализ (Cluster analysis)
- Магадлан шинжлэх арга (Expertise)

Судалгааны ажлын үр дүнг нэгтгэх, боловсруулахад Microsoft Excel-ийн VBA код ашиглан автоматжуулалт хийсэн. Энэ талаар тайлангийн холбогдох хэсэгт дэлгэрэнгүй тайлбарласан.

Судлах агуулгын багц бүр (судалгааны зорилтууд)-ээр шинжилгээний тусгайлсан аргачлал боловсруулан хэрэглэсэн бөгөөд энэ талаар тайлангийн холбогдох бүлгүүдэд тодорхой дурьдсан болно.

Судалгааны зорилтын хүрээнд дээрх аргуудыг дараах үндсэн алхмуудаар хэрэгжүүлж, алхам тус бүрийг гүйцэтгэх тусгайлсан арга, аргачлалыг боловсруулж хэрэглэсэн. Үүнд:

1. Судалгааны “нэгж объектууд” бэлтгэх

Судалгааны объектуудыг бэлтгэх хүрээнд эхлээд линкээр авч болох баримт бичгүүд (Хүснэгт 1)-ийн эх материалаас багшлахуйн хөгжлийн асуудалтай холбогдох бүлэг, сэдэв, хэсгийг сонгон Excel-д татах, мөн хэвлэмэл материалуудаас Excel-ийн Insert-Text-Object-оор шинэ Sheet-д хавсарган татаж, холбогдох мэдээллийг шивж бэлтгэсэн. Ингэж судалгааны мэдээллийг бэлтгэх нь өгөгдлийн бүрэн бүтэн болон баталгаат чанарыг хангах, баримт бичгүүд хоорондын агуулгыг нэг файлын хүрээнд харьцуулж харах, шаардлагатай үндэслэл, шалтгааныг холбож үзэх боломжийг хэрэглэгчдэд олгох ач холбогдолтой гэж үзсэн болно. Дараа нь цуглуулж бэлтгэсэн мэдээллийн багшлахуйн хөгжлийн асуудалтай холбогдох байдлыг “шууд холбогдох”, “дам холбогдох”, “хамааралгүй” гэсэн 3 төрөлд ангилан ялгах, тоолж, зөвлөмж бичихэд тус тус зориулж “VBA”-ээр коджуулсан. Дээрх алхмуудын дүнд багшлахуйн хөгжлийн кластерийг ашиглан зөвлөмж гаргах боломжтой нийт 245 шууд, 222 дам хамаарал бүхий нийт 467 судалгааны “нэгж объект”-ийг тус тус ялган тодорхойлсон (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Судалгааны “нэгж объект”-ын тоо (хамаарлын төрлөөр)


	0. "Алсын хараа -2050"	ЗГ-ын болон боловсролын салбарын хөтөлбөр, төлөвлөгөө							Боловсролын салбарт хийгдсэн зарим судалгаа							Нийлбэр	
		1. ЗГ-2020-2024	2. Боловсрол-2021-2024	3. 21-25-Зорилт-Хүрэх үр дүн	7. 21-25-Санхүүжилтгүй төсөл	11. МТ-21-30-Үр дүнгийн харгалз	12. МТ-21-25-Хөтөлбөр, ҮА	Нийт	1. БСМТайлан-дэд салбар	2. БСМТайлан-дэд салбар дамнах	3. Бодлогын шинжилгээ-2019	4. МТ-өмнө-СӨБ	5. МТ-өмнө-БДБ	6. МТ-өмнө-Дээд	7. МТ-үнэлгээ-Роберт		Нийт
Нийт	223	36	401	16	14	29	238	734	27	81	75	25	209	29	17	463	1420
Шууд хамааралтай заалт	26	9	46	2	0	1	36	94	3	33	15	5	65	0	4	125	245
Дам хамааралтай заалт	58	16	40	1	5	8	44	114	10	15	12	0	5	8	0	50	222
Хамааралгүй заалт	139	11	315	13	9	20	158	526	14	33	48	20	139	21	13	288	953

2. Шинжилгээний үр дүнг ялгах, тоолох автоматчилах арга (автоматчилагдсан Excel файл) бэлтгэх

Судалгааны ажлын үр дүнг нэгтгэх, боловсруулах эксэл файлыг автоматжуулахад Microsoft Excel-ийн гурван VBA код сонгон ашигласан. Үүнд:

- Судалгааны нэгж объект (Excel файлын нүд)-ыг үнэлж, багшлахуйн кластерийн агуулгатай холбогдох байдлаар нь “шууд хамааралтай”, “дам хамааралтай” болохыг тодорхойлж нүдийг ногоон, цэнхэрээр ялгаж будах бөгөөд үр дүнг “=GetFontColorIndex()”, “=CountFontColor(range, colorindex)” гэсэн хоёр VBA кодын тусламжтайгаар тоолсон.
- “Шууд хамааралтай” болон “Дам хамааралтай” судалгааны нэгж объектод магадлан шинжилгээ хийж тодорхойлсон багшлахуйн кластерийн индикаторууд, санал, зөвлөмжүүдийг тухайн нүдэнд “comment” хэсэгт бичсэн. Иймээс Excel файлыг

хэрэглэх үед хэрэглэгч судлаачийн өгсөн дэлгэрэнгүй санал зөвлөмжийг шууд харах боломжийг олгосон. Тухайн файл дахь бүх шийтийн коментуудыг **“ShowCommentAllSheets”** VBA кодын тусламжтай экстракт хийж аваад дараагийн боловсруулалт хийж боломжтой болгосон. Ингэснээр хэрэглэгч дэлгэрэнгүй санал зөвлөмжийг цаашид өөрийн хэрэгцээнд нийцүүлэн боловсруулж ашиглах боломжтой.

- Бодлого, төлөвлөлтийн барим бичгийн шинжилгээ бүхий *“Засгийн Газрын хөтөлбөр, төлөвлөгөө (Excel файл 2)”* файлд нэлээд олон “нэгж объект”-д өгсөн зөвлөмжүүд хоорондоо уялдаа холбоотой бөгөөд холбоо бүхий бусад нэгж объект руу тухайн нүдэнд оруулсан  дүрсийг дарснаар шилжиж болно.

Автоматчилагдсан Excel файл тус бүрт “тайлбар” sheet-д дээр дурьдсан гурван VBA кодыг хэрхэн хэрэглэх талаар тайлбар оруулж өгсөн тул цаашид өөрийн хэрэгцээнд зориулан өөрчлөн ашиглаж болно.

3. Шинжилгээний шалгуур, индикатор (багшлах үйлийн кластерийн тогтолцоо)-ыг боловсруулах

Багшлах үйлийн хөгжлийн үе шатуудыг тус бүрд нь салангид байдлаар бус үе шат бүрийг холбосон зангилаануудыг хамруулан бүхэлд нь дотоод харилцан хамааралд нь авч үзэхийн зэрэгцээ энэ үйлийн хөгжлийг боловсролын хөгжлийн бусад үндсэн хүчин зүйлсийн нөлөөллийн гадаад холбоонд нь авч үзсэнээр асуудлыг оновчтой, үр ашигтай, үр өгөөжтэй, тогтвортой байх боломжийг олгоно. Өөрөөр хэлбэл, багшлах үйлийн хөгжлийг түүний гадаад, дотоод холбооных нь нэгдэлд авч үзэж шийдвэрлэх шаардлагатай. Энэ боломжийг олгодог арга техникийн нэг нь кластер анализ, түүнд суурилсан хөгжүүлэлтийн арга юм.

Иймээс бид ерөнхий бүтэц, (1 дэх эрэмбийн агуулгаар) үндсэн бүтэц (1 ба 2 дахь эрэмбийн агуулгаар), дэлгэрэнгүй бүтэц (1, 2, 3 дахь эрэмбийн агуулгаар) гэсэн бие биедээ эрэмбэлэгдсэн 3 түвшинт бүтэцтэй, түвшин тус бүрд харгалзах эхний түвшний 7 гол шалгуур, хоёр дахь түвшний 33 дэд шалгуур, гурав дахь түвшний 103 индикатораар тус тус тодорхойлогдох агуулга бүхий багшлах үйлийн хөгжлийн кластер (цаашид багшлахуйн кластер гэнэ)-ийн загварын нэгэн хувилбарыг боловсруулсан (Хавсралт 1).

Энд дурьдсан 3 түвшний шалгуур индикатораар бүртгэгдэн үнэлэгдэх санал, зөвлөмж, холбоосыг бүхэлд нь *“илэрц”* гэж нэрлэн шинжилгээний үр дүнг боловсруулах, тайлбарлахдаа энэ үгийг голдуу ашигласан болно.

Бидний боловсруулсан багшлахуй кластерийн энэ загвар нь боловсролын салбарын судалгаанд хэрэглэж буй анхны загварууд нэг болохыг тэмдэглэхийн зэрэгцээ уг захиалгат ажлыг гүйцэтгэх цаг хугацааны хязгаарлалтаас шалтгаалан нарийн эргэцүүлэл, туршилт, сайжруулалт хийж амжаагүй болохыг тэмдэглэж байна.

4. Шинжилгээний үр дүнг магадлан шинжлэх аргачлал боловсруулах.

Судалгаанд хамруулан авч үзсэн боловсролын салбарын урт ба дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийг багшлахуйн кластерийн индикаторуудыг ашиглан судлах явцад хийгдэх магадлан шинжилгээний бүх санал, зөвлөмжүүдийг дараах 3 түвшинд эрэмбэлэн гаргасан болно. Тухайлбал,

- А. Судалгаанд бэлтгэсэн нийт өгөгдлөөс сонгосон 208+175 нэгж объект (Алсын хараа 2050-ороогүй) бүрээр гаргасан дэлгэрэнгүй санал, зөвлөмжүүд (Файл 2 ба 3-ын Файл 2 ба 3-ын “Коммент” sheet-үүд)
- В. “Алсын хараа 2020-2050: Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого”, “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” төвтэй баримт бичгүүд,

Боловсролын салбарт хийгдсэн судалгааны хүрээнд тус тус ангилан гаргасан санал, зөвлөмжүүд (Судалгааны тайлангийн 4.1, 4.2, 4.3 дэд бүлгүүд)

С. Судалгааны ерөнхий санал, зөвлөмжүүд (Судалгааны тайлангийн Дүгнэлт, зөвлөмж хэсэг)

Магадлан шинжилгээний санал, зөвлөмжийг ингэж 3 түвшинд ялгаж боловсруулах нь тухайн нэг баримт бичгийн хувьд зорилт, хүрэх үр дүн бүрийг бусад зорилт, хүрэх үр дүнтэй холбоо хамааралд нь харж, томъёоллыг хянан сайжруулах замаар баримт бичгээ товч, тодорхой, утга төгөлдөр болгох; урт, дунд хугацаанд хэрэгжүүлэхээр батлагдсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнд товлосон хугацаанд тогтмол хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлагнах; улмаар батлан хэрэгжүүлж байгаа баримт бичгүүдээ үнэлж, өөрчлөлт оруулах, шинээр боловсруулахад тус тус ашиглах практик ач холбогдолтой гэж үзсэн.

ХОЁР. БАГШЛАХУЙН КЛАСТЕР

Монгол Улсын засгийн газраас 2020 онд батлагдсан урт, дунд хугацааны бодлого, төлөвлөгөөнүүд болон сүүлийн жилүүдэд боловсролын салбарт хийгдсэн томоохон судалгаануудад өгөгдсөн зөвлөмжид боловсролын чанарыг сайжруулах салбарын үндсэн зорилтыг хангах хамгийн гол хүчин зүйлсийн нэг болох багшийн хөгжлийн асуудлыг ямар түвшинд тусгаж, энэ асуудлыг цогцоор нь шийдвэрлэх боломж ямар түвшинд тусгагдсаныг тус тус илрүүлэх зорилготой судалгааны ажил болохынхоо хувьд энэ илрүүлэгийн хамрах хүрээг бүрэн бүтэн байлгах, чанарыг хангах зорилгоор судлаачдын багаас боловсролын салбарт анх удаа “Багшлахуйн хөгжлийн кластерийн тогтолцоо”-ны нэгэн хувилбарыг боловсруулах зорилт тавьж ажиллалаа. Ийм арга хэрэгсэл бүтээж, үнэлгээ, зөвлөмж өгөх нь судалгаа болон стратегийн бодлого, төлөвлөлтийг илүү үр ашигтай, үр өгөөжтэй, тогтвортой болгоход ач тусаа өгнө гэдгийг үндэслэл болгосон. Учир нь 2019 онд ЮНЕСКО-оос хэвлэн гаргасан “Монгол Улсын боловсролын тойм үнэлгээ”-нд асуудлыг шийдвэрлэхдээ түүнтэй холбоотой бүх хүчин зүйлсийн харилцан нөлөөлөл, уялдаа холбоог бүхэлд нь авч үзсэнээр түүнийг үр ашигтай, үр өгөөжтэй шийдвэрлэх боломж олгодог кластерчиллын аргын чухлыг онцлон тэмдэглэсэн байна.

2.1. Боловсролын кластер

Кластер анализ буюу кластерчилах гэдэг нь бүлэг объектуудаас (кластерууд) тодорхой нэг утгаараа бие биетэйгээ илүү төсөөтэй, холбоотой байж болох объектуудыг кластер гэж нэрлэн нэг багцад бүлэглэх авч үзэх зорилттой шинжилгээ юм. Энэ нь өгөгдлийн эрэл хайгуулыг оюуны задлан шинжилгээгээр олборлох ажил бөгөөд олон салбарт хэрэглэгддэг статистик өгөгдлийн шинжилгээний арга техникүүд; загварыг танин мэдэх; дүрслэл, зураглалын анализ, мэдээллийг нягтлах, сэргээх; биоинформатик, өгөгдөл шахах, компьютер график зэрэг олон салбарт хэрэглэгддэг нийтлэг арга техник юм. Боловсрол, сэтгэл судлалын судалгаа, шинжилгээнд кластер анализын аргыг өргөн хэрэглэх болсон байна (Blashfield & Aldenderfer, 1988; Distefano & Mindrila, 2013).

Мөн эдийн засаг, аж үйлдвэрлэлийн салбарт “кластераар хөгжүүлэх бодлого”-ын асуудал өргөн нэвтэрсэн байдаг. Эдийн засгийн аж үйлдвэрийн сектор дахь кластерууд сүүлийн арав гаруй жилийн турш өрнөдийн боловсролд нэвтэрсэн бөгөөд дэлхий даяар өрнөж буй даяаршлын үйл явц нь бусад салбартай адил боловсролын кластерчлалыг шаардаж байгааг боловсролыг салбарын олон судалгаанд дурьдсан байна (Abdurashidovna, 2020; Gryshova, Zamlynskyi, & Shestakovska, 2017; Aitbayeva, Zhubanova, Kulgildinova, Tusupbekova, & Uaisova, 2016).

Боловсролын кластерууд нь үйлдвэрлэлийн кластеруудын аналог биш боловч олон ижил төстэй шинж чанартай байдаг. М.Портерын кластерын онол нь сүүлийн арав гаруй жилийн хугацаанд олон салбарт, түүнчлэн боловсролын салбарт нэвтэрсэн. Ялангуяа мэргэжлийн боловсролын салбарт “Боловсрол-шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн систем дэх инновацийг дэмжих арга хэрэгсэл”, “Үйлдвэрлэлийн болон сургалтын хөтөлбөрийн хэрэгцээг хослуулан нэгтгэх” арга хандлагад суурилсан кластерчлалыг хэрэгжүүлсэн туршлага их байна (Gaag, et al., 2019). Энэ мэтчилэн Боловсрол дахь кластерын хэд хэдэн үзэл, хандлагыг судлаачид тодорхойлсон байгаа (Mukhamedov, Khodjamkulov, Shofkorov, & Makhmudov, 2020)-аас Бид Багшлахуйн кластерт “Боловсролын тогтолцоог боловсролын янз бүрийн байгууллагуудыг интеграцийн үр дүнг харгалзан үе шаттайгаар шилжүүлэх зарчимд тулгуурлан өөрчлөн байгуулах” хандлага баримтлах нь оновчтой гэж үзсэн.

Зарим судлаачид кластерийн долоон үндсэн төрлийг тоймлон тодорхойлсон байна. Үүнд:

- Газарзүйн кластер: тухайн орон нутгаас дэлхий нийтийн хэмжээнд тархсан кластерын төрөл;
- Хэвтээ кластер: олон кластеруудаас бүрдсэн кластерын өргөтгөсөн хэлбэр;

- Босоо кластер: энэ нь хэд хэдэн кластеруудыг хэд хэдэн түвшинд нэгтгэн эрэмбэлсэн хувилбар;
- Хажуугийн кластер: янз бүрийн бүтцэд дэх субъектүүдийг нэгтгэн цар хүрээг хумьж, шинэ хослолууд руу хөтөлж чадах кластерууд;
- Технологийн кластер: ижил технологийг ашигладаг бүтцийн багцад харагдахуйц кластерууд;
- Төвлөсөн кластер: Нэг төвийн эргэн тойронд байрлах кластерууд;
- Чанарын кластер: Байгууллага нь хамтын ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэхэд төвлөсөн кластерууд

Манай боловсролын бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тодорхойлсон “бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурласан сургуулийн зураглал (school mapping)” гаргаж сургуулийн хөгжлийг хангах нь “Газарзүйн кластер” төрөл давамгайлсан төрөл байх боломжтой.

Боловсролын кластерийг үр дүнтэй хөгжүүлэх нь дараах нөхцөл, хүчин зүйлээс шууд хамаардаг болохыг судлаачид тэмдэглэж байна. Үүнд:

- Технологи, шинжлэх ухааны дэд бүтцийн бэлэн байдал;
- Оролцогчдын хамтран ажиллах сэтгэл зүйн бэлэн байдал;
- Кластер хөгжүүлэхэд чиглэсэн хүчтэй бүс нутгийн стратегитэй байх;
- Төслийн менежментийн арга техникийг амжилттай хэрэгжүүлэх чадвар;
- Кластерийн байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох ажлыг хөнгөвчлөх мэдээллийн өндөр технологи;

2.2. Багшлахуйн кластерийн тогтолцоо

ЮНЕСКО-оос 2019 онд хийж хэвлүүлсэн “Монголын боловсролын бодлогын тойм шинжилгээ”-ний тайланд “Кластерчлах нь боловсон хүчний, цаг хугацааны болон санхүүгийн нөөцийг оновчтой болгох арга хэрэгсэл юм. Боловсролын тогтолцооны гол асуудлуудыг дан ганц, салангид байдлаар нь бус, харин бусад кластеруудын харилцан хамаарал, уялдаа холбоонд нь холистик байдлаар авч үзэн оновчтой байдлаар шийдвэрлэх боломж олгодог. Кластерийн нэгэн хэлбэрийг жишээ болгон боловсролын гол бодлогуудыг авч үзвэл ямар нэгэн байдлаар хоорондоо зөрчилдөх, бусад зохицуулалттай уялдаа холбоогүйгээр өөрчлөгдөх зэргээс сэргийлэх үүднээс харилцан уялдаа холбоотой, нийцтэй байдлыг нь хангана гэсэн үг” (ЮНЕСКО, 2019) хэмээн зөвлөсөн байна.


Кластер анализ хийхийн тулд эхлээд харилцан хамааралтай асуудлуудыг бүлэглэн кластер үүсгээд дараа нь түүний бүрэлдэхүүн хэсгүүд хоорондын харилцааг задлан шинжилдэг. Жишээлбэл, боловсролын бүх түвшин, хэлбэрийн хувьд сургалтын хөтөлбөрийн тогтолцоог тойрсон кластеруудыг авч үзье гэвэл боловсролын хэрэгцээ, суралцахуйн зорилт/үр дүн, агуулга, арга зүй, үнэлгээ, гэрчилгээжүүлэлтийн хэлбэр болон шатлал, сургалтын хөтөлбөрийн зарчим, стандартын хөгжүүлэлт, хэрэгжүүлэлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ гэсэн тус бүрдээ дотоод бүрэлдэхүүн хэсгүүд, тэдгээрийн хоорондох хамаарлыг илэрхийлэх эргэх холбооны цикл бүхий бие даасан дэд кластерүүд байх бөгөөд харин эдгээр дэд кластерүүдээс бүрдэх дараагийн түвшний кластер нь боловсролын чанарыг баталгааг хангахад зориулагдсан байж болох юм. Тэгээд ч энэ утгаараа кластерчилал нь өрсөлдөөнд ялах магадлалыг эрс нэмэгдүүлэх боломж олгодог тул эдийн засаг, аж үйлдвэрийн салбарт эрт үеэс, хурдацтай хөгжиж ирсэн түүхтэй. Бид боловсролын салбарт “өрсөлдөх чадвартай иргэн төлөвшүүлэх” талаар хэдэнтээ зорилго дэвшүүлсэн ч түүнийг дэмжсэн хөгжлийн бодлого, урт, дунд хугацааны төлөвлөлт, хэрэгжилтийн менежмент, хяналт-шинжилгээгээ өөрсдөө кластерчилахгүйгээр энэ зорилго “хоосон лозунг” байсаар л байх болно гэдгийг бид маш сайн ойлгох хэрэгтэй.

Үүнтэй адилаар хүний нөөцийг чадавхжуулахтай (багш, удирдлага) холбоотой кластерийг ч авч үзэж болно.

Бид энэ удаа “Багшлахуйн хөгжлийн кластер”-ийн нэгэн хувилбарыг боловсруулж, түүнийгээ 2020 онд баталгаажсан боловсролын салбарын хөгжлийн урт ба дунд хугацааны багц бодлого, төлөвлөгөө болон 2018 оноос хийгдсэн зарим томоохон судалгааны зөвлөмжүүдэд багшлахуйн асуудлууд хэрхэн тусгагдсан байдлыг илрүүлэхэд ашиглалаа.

“Багшлахуйн хөгжлийн кластер”-т багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн үйл явцыг төрийн үйлчилгээ талаас нь харж, Багшийн мэргэжлийн чиг баримжаа өгөх (БК0); Багш бэлтгэх (БК2); Багшаар ажиллах (БК4); Ахмадаас зөвлөгөө, дэмжлэг авах (БК6) гэсэн 4 үе шатууд болон Багш бэлтгэх сургуульд элсүүлэх (БК1), Багшийг ажилд авах (БК3); Тэтгэвэр тогтоож, ажлаас чөлөөлөх (БК5) гэсэн багшлахуйн хөгжлийн шилжилтийн 3 үндсэн төлөв байдлыг тус тус агуулсан 7 бүлэг асуудлаар тодорхойлогдох тасралтгүй үргэлжлэх үйл явц хэмээн авч үзсэн (**Error! Reference source not found.**).

Зураг 1. Багшлахуйн хөгжлийн кластерийн ерөнхий бүтэц



Энэ үйл явцыг шинжлэх болон шаардлагатай санал, зөвлөмж гаргахад зориулж, тайлангийн арга зүйн хэсэгт танилцуулсан 3 түвшний нийт 143 индикатор бүхий энэхүү багшлахуйн кластерийг боловсруулсан. Тайлангийн энэ хэсэгт тус кластерийн 3 түвшинт бүтэц, агуулгыг Хүснэгт 4 болон **Error! Reference source not found.**, **Error! Reference source not found.**-д тус тус хураангуйлан үзүүлж, Хавсралт 1-д түүнийг бүрэн бүтэц, агуулгаар нь харгалзах кодын хамт өгсөн болно.

Аливаа үйл явц, үйлийг кластер болгон авч үзэж судлах, судалгааны үр дүнд тулгуурлан уг үйлийг төлөвлөж, хэрэгжүүлж, үнэлж, сайжруулах нь тогтолцоон сэтгэлгээ, түүний арга барилуудыг шаарддаг онцлогтой. Өөрөөр хэлбэл, кластерчилал нь тогтолцоон сэтгэлгээнд суурилсан хүчирхэг арга хэрэгсэлийн нэг юм. Тухайлбал, багшлахуйтай холбоотой бүх асуудлыг нэг хавтгай дээр тавьж бөөгнүүлснээр кластер үүсэхгүй. Харин бүх асуудлаа агуулгаар нь бие биед нь эрэмбэлэх замаар хэд хэдэн түвшинд ангилсан бүтцийг гаргах, түвшин хоорондын болон түвшин доторх холбоо хамаарлыг илрүүлж, улмаар багшлах үйл явцын чанар, үр ашиг, үр өгөөж, тогтвортой байдлыг бүрэн хангатай тэдгээрийн хоорондох шулуун ба эргэх холбоонууд (шийдлүүдийн шалтгаан үр дагавар) олон дахин үнэлэн тохируулах замаар кластерийг үүсгэх явдал боловсролын чанарын нэг чухал баталгаа болох болно.

Иймд дэд багшлахуйн кластерийн тогтолцоог бүрдүүлэхийн тулд дээр өгүүлсэн кластерийн бүтцийн ерөнхий, үндсэн, дэлгэрэнгүй хэлбэрүүдийг тодорхойлохын зэрэгцээ бид кластерууд хоорондын болон тус бүрийнх нь дотоод холбоо хамаарал, тэдгээрийн шинж чанаруудыг шинжлэх хэрэгцээ шаардлагын үүднээс бүх холбоосыг шинжлэхэд хэрэгтэй тусгай код агуулга (шалгуур, индикатор)-ыг ялгасан (**Error! Reference source not found.**).

Гэвч энэхүү гэрээгээр гүйцэтгэх ажлын багтаамж, цаг хугацааны нөөцөөс шалгаалж энэ төрлийн шинжилгээг хийгээгүй болно.


Хүснэгт 3. Багшлахуйн кластер дахь шулуун ба эргэх холбоо

X1. Шулуун холбоос		X1
X1.1.	Багшлахуйн үйл явцын эхлэл ба төгсгөл хоорондын шулуун холбоос	X1.1
X1.2.	Үе шатуудыг дараалан холбогдох шулуун холбоос	X1.2
X1.3.	Үе шатуудыг алгасан холбогдох шулуун холбоос	X1.3
X1.4.	Шилжилтийн төлвүүдийг дараалан холбогдох шулуун холбоос	X1.4
X1.5.	Шилжилтийн төлвүүдийг алгасан холбогдох шулуун холбоос	X1.5
X2. Эргэх холбоос		X2
X2.1.	Багшлахуйн үйл явцын эхлэл ба төгсгөл хоорондын эргэх холбоос	X2.1
X2.2.	Үе шатуудыг дараалан холбогдох эргэх холбоос	X2.2
X2.3.	Үе шатуудыг алгасан холбогдох эргэх холбоос	X2.3
X2.4.	Шилжилтийн төлвүүдийг дараалан холбогдох эргэх холбоос	X2.4
X2.5.	Шилжилтийн төлвүүдийг алгасан холбогдох эргэх холбоос	X2.5

“Багшийн мэргэжлийн чиг баримжаа өгөх”-өөс “Ахмадаас зөвлөгөө, дэмжлэг авах” хүртэл багшлахуйтай холбоотой бүх тогтолцоог хамарч байгаа учраас бидний боловсруулсан Багшлахуйн кластер нь “Хэвтээ кластер”, Багшлахуйн тасралтгүй хөгжлийг хангахад төвлөсөн учраас “Чанарын кластер” төрөлд хамаарах боломжтой.

Кластер шинжилгээ нь өөрөө ямар нэгэн бие даасан тодорхой алгоритм биш бөгөөд харин асуудлыг шийдвэрлэх шаардлагатай ерөнхий ажил даалгавар юм. Энэ анализыг хийхдээ кластерийг хэрхэн бүрдүүлж бүтээх, тэдгээрийг хэрхэн үр өгөөжтэй ажиллуулахын тухайд агуулгын эрс ялгаатай янз бүрийн алгоритмуудыг ашиглан гүйцэтгэж болно.

Зураг 2. Багшлахуйн дэд кластеруудад харгалзах 3 дахь эрэмбийн агуулга (индикатор)-ын тоо



Кластер анализ нь автоматаар нэг удаагийн гүйцэтгэлээр хийчихдэг шинжилгээ биш бөгөөд шинэ мэдлэгийг олж илрүүлэхийн төлөө, эсвэл туршилт, бүтэлгүйтлийг багтаасан олон-зорилтод оновчлолын төлөө дахин давтан хийгддэг үйл ажиллагаа байдаг. Ихэнхи тохиолдолд хүссэн үр дүндээ хүрэхийн тулд өгөгдлийн урьдчилсан боловсруулалт болон загварын хэмжигдэхүүнүүдээ өөрчлөх шаардлагууд үүсдэг.

Монгол Улсад багшлах үйл явцыг кластержуулах энэхүү оролдлогыг бид анх удаа эхлэж, үндэсний түвшний бодлого, төлөвлөлтийн болон судалгааны зарим баримт бичгүүдийг үнэлж, зөвлөмж боловсруулахад хэрэглэхийг хичээлээ. Цаашид түүнийг улам боловсронгуй болгон хэрэглэх үйл явцыг үргэлжлүүлэх, боловсролын чанарын баталгааг хангах үндсэн арга хэрэгслийн нэг болгон хөгжүүлэх шаардлагатай.

Кластерийг тодорхойлж, кластераар хөгжүүлэх нь тодорхой хугацаанд онилсон үйл ажиллагааг шаарддаг өргөн цар хүрээтэй зохион байгуулалтын үйл явц юм. Тухайн кластерын зорилго, зорилтыг тодорхой тодорхойлж, үйл ажиллагааныхаа хэтийн төлөвийг урьдчилан харахын тулд ямар зарчмуудыг баримтлах ёстойг тодорхойлох (Mukhamedov, Khodjamkulov, Shofkorov, & Makhmudov, 2020) шаардлагатай байдаг. Мөн зарим судлаачид боловсролын кластерын хөгжлийн бодит үр нөлөө 5-7 жилийн дараа илэрхий болно гэж үзсэн байна.

Бидний санал болгосон Багшлахуйн кластерийн 3 түвшинт бүтэц, агуулгыг бүхэлд нь, эсвэл дэд кластерээр боловсролын салбарын мэдээллийн санд үндэслэн статистик шинжилгээ хийж, нягтлан сайжруулж хэрэгжүүлэхэд кластер анализын статистик арга зүй, кластерийг нарийвчлах алгоритм (Li & Wang, 2015)-ыг хэрэглэх олон улсын туршлагыг сайтар судлах шаардлагатай болно.

Хүснэгт 4. Багилахуйн кластерийн тогтолцооны үндсэн бүтэц (1 ба 2 дахь эрэмбийн агуулгаар)

БК0. Мэргэжлийн чиг баримжаа өгөх	БК0.1. Багш болох хүсэл, эрмэлзэл	БК0.2. Өөрийгөө таньж, олох боломж	БК0.3. Авъяас, чадамж (ability)-аа нээх боломж	БК0.4. Багшийн мэргэжлээр элсэхэд тавигдах шаардлагууд	БК0.5. "Багш" мэргэжлийн ухуулга, сурталчилгаа		
БК1. Багш бэлтгэх сургуульд элсүүлэх	БК1.1. Элсэлтийн шалгалт	БК1.2. Мэргэжлийн ИДС-ийн элсэлт	БК1.3. Хүйс, жендерийн асуудлууд	БК1.4. Суралцах арга хэлбэрийн сонголт	БК1.5. Тэтгэлэг, дэмжлэг		
БК2. Багш бэлтгэх	БК2.1. Сургалтын хөтөлбөр, түүний магадлан итгэмжлэл	БК2.2. Багшлах дадлага	БК2.3. ИДС-ийн профессор багш нарын хангалт, хөгжил	БК2.4. ИДС-ийн магадан итгэмжлэл, хөгжил	БК2.5. "Багш" мэргэжилтний хангамж		
БК3. Багшийг ажилд авах	БК3.1. Ажилд ороход тавигдах шаардлагуудыг судлах	БК3.2. Багшаар ажиллах хөдөлмөрийн харилцааны эрх зүйн орчинг судлах	БК3.3. Хөдөлмөрийн зах зээлээс ажлын байр олох	БК3.4. Ажилд орох			
БК4. Багшаар ажиллах	БК4.1. Мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах тогтолцоо	БК4.2. Насан туршийн суралцахуйг дэмжих арга механизм	БК4.3. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх мэдлэг, ур чадварын хангалт (Багшийн стандарт)	БК4.4. Ялгаатай зорилгод бүлгүүдэд багшлах мэдлэг, ур чадварт тавигдах шалгуур, индикаторууд	БК4.5. Багш бэлтгэх, БМТХ-ийг хангах үйл явцын төлөвлөлт, үнэлгээ ба баталгаажилт	БК4.6. Багшийг тогтоон барих, багшийн хангалт	БК4.7. Цалин хөлс, нийгмийн халамж, хамгаалал, амьжиргааны түвшин
БК5. Тэтгэвэр тогтоож, ажлаас чөлөөлөх	БК5.1. Хууль, тогтоомжийн дагуу төрөөс олгох тэтгэвэр, тэтгэмж авах	БК5.2. Хуул, тогтоожийн дагуу төрөөс үзүүлэх дэмжлэгийг судлах, эдлэх					
БК6. Зөвлөгөө, туслалцаа авах	БК6.1. Шаардлагатай тохиолдолд цагийн багшаар ажиллах	БК6.2. Ажиллаж буй багш нарт зөвлөн туслах (mentor)	БК6.3. Сургалт, судалгаанд оролцох	БК6.4. Бүтээл тууривах, ном, гарын авлага бичих, редакторлах	БК6.5. Боловсролын чиглэлээр эвсэл холбоонд нэгдэн бусадтай хамтран ажиллах г.м.		

ГУРАВ. КЛАСТЕР ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН (ТООН ШИНЖИЛГЭЭ)

Энэ бүлэгт судалгаанд хамрагдсан баримт бичгүүдийн кластер шинжилгээний үр дүнгийн тоон үзүүлэлтүүд, тэдгээрийн тархалт, давтамжийг дүрслэн үзүүлэхийн зэрэгцээ багшлах үйлийн хөгжлийн асуудлуудыг кластер шинжилгээгээр авч үзэхэд нөхцөл байдал ямар байгааг танилцуулж, анхаарал хандуулах шаардлагатай зарим асуудлыг хөндөж гаргана.

Тодруулбал, судалгаанд хамрагдсан 11 баримт бичгээс үүсгэсэн өгөгдлийн сангаас боловсролын хөгжлийн зорилт ба хүрэх үр дүнгийн асуудалд хамаарах нийт 734+463 судалгааны нэгж объектыг сонгож, тэдгээрээс багшлах үйлийн хөгжилд шууд хамааралтай 94+125, дам хамааралтай 114+50 буюу нийт $(94+125)+(114+50)=383$ нэгж объектод хийсэн кластер шинжилгээний үр дүнг танилцуулна (**Error! Reference source not found.**).

3.1. Урт ба дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөгөөний кластер шинжилгээний дүн

Энэ дэд бүлэгт судалгаанд хамрагдсан 11 баримт бичиг (Хүснэгт 1.)-ээс “Алсын хараа 2020-2050. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого” баримт бичгээс бусад дунд хугацааны бодлогын 4 баримт бичиг (2-4 дүгээрт байгаа)-г хийсэн багшлахуйн кластер шинжилгээний тоон үзүүлэлтийн тархалт, давтамжийг танилцуулна. Учир нь “Алсын хараа 2020-2050” нь урт хугацааны хөгжлийн баримт бичиг учраас түүнд боловсролын тодорхой нэг асуудал тухайлбал, багшлахуйн асуудлаар тоон анализ хийх нь тохиромжгүй гэж үзсэн.

Засгийн Газрын хөтөлбөр, төлөвлөгөө (Excel файл 2)

Энэ судалгаанд зориулж судлах объектын 12, судалгааны автоматчилагдсан үр дүнгийн 3, нийт 15 Sheet бүхий тусгай Excel файлыг бэлтгэсэн. Тэдгээрээс тоон ба чанарын анализад 6 Sheet-ийг ашиглаж, үлдсэн 6 Sheet-ийг энэхүү судалгааны үр дүнг хэрэглэгч тухайн баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийн хяналт-шинжилгээ хийх, багшлахуйтай холбоотой бодлого, төлөвлөлтийг зарим салбарын зорилтуудтай уялдуулахад тус тус мэдээллийн эх үүсвэр болгон ашиглахад нь зориулж бэлтгэсэн (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Тоон анализ хийгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөнүүд ба харгалзах Sheet-ийн нэр

№	Баримт бичгийн нэр	Sheet-ийн нэр
1	Засгийн Газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр	1.ЗГҮАХ-2020-2024
2	Засгийн Газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	2.ЗГАХХ-2020-2024
3	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	3.ҮЧ-21-25-Зорилт-Хүрэх үр дүн
		7. ҮЧ-21-25-Санхүүжилтгүй төсөл
4	Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө: 2021-2030.	11. МТ-21-30-Зорилт-Үр дүн
		12. МТ-20-25-Хөтөлбөр-Үлй ажиллагаа

Эдгээр баримт бичгээс боловсролын хөгжлийн зорилт ба хүрэх үр дүнгийн асуудалд хамаарах нийт 734 судалгааны нэгж объектыг сонгож, тэдгээрээс багшлах үйлийн хөгжилд шууд хамааралтай 94, дам хамааралтай 114 буюу нийт 208 нэгж объект (**Error! Reference source not found.**)-г кластер шинжилгээ хийж үр дүнг дараах 3 үе шаттайгаар боловсруулав. Үүнд:

- А.Багшлахуйн кластерийн ерөнхий бүтцийн гол шалгуураар илрүүлсэн үр дүн

- Б.Багшлахуйн кластерийн үндсэн бүтцийн дэд шалгуураар илрүүлсэн үр дүн
- В.Багшлахуйн кластерийн дэлгэрэнгүй бүтцийн индикаторуудаар илрүүлсэн үр дүн

3.1.1. Багшлахуйн кластерийн ерөнхий бүтцийн гол шалгуураар илрүүлсэн үр дүн

Эхлээд “Багшлахуйн хөгжлийн кластерийн ерөнхий бүтцэд харгалзах 4 үе шат, 3 төлөв байдал **Error! Reference source not found.**) бүхий 7 гол шалгуур бүрээр дээрх объектуудыг шинжилсэн.

Засгийн Газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр болон энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийт илэрцийн 815 буюу 71.1 хувь; “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө: 2021-2030 (цаашид Мастер төлөвлөгөө гэнэ)”-нд 298 буюу 26 хувь; харин Үндсэн чиглэл (2021-2025)-д 34 буюу 3 хувь нь тус тус ногдож байна (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Багшлахуйн кластерийн ерөнхий бүтцийн шалгуураар үнэлэгдсэн үр дүн (илэрцийн тоогоор)
(Засгийн газрын хөтөлбөр, төлөвлөгөөний баримт бичиг тус бүрээр)

“Sheet”-ийн дугаар нэр	1. ЗГҮАХ-2020-2024	2. ЗГАХХ-2020-2024	3. ҮЧ-21-25-Зорилт-Хүрэх үр дүн	7. ҮЧ-21-25-Санхүүжилтгүй төсөл	11. МТ-21-30-Зорилт-Үр дүн	12. МТ-21-25-Хөтөлбөр-ҮА	Нийлбэр
БК0. Мэргэжлийн чиг баримжаа өгөх	1	3	0	0	5	0	9
БК1. Багш бэлтгэх сургуульд элсүүлэх	1	16	0	0	12	0	29
БК2. Багш бэлтгэх	17	57	0	3	21	0	98
БК3. Багшийг ажилд авах	7	21	0	0	19	0	47
БК4. Багшаар ажиллах	205	464	13	18	121	107	928
БК5. Тэтгэвэр тогтоож, ажлаас чөлөөлөх	3	11	0	0	8	0	22
БК6. Зөвлөгөө, туслалцаа авах	1	8	0	0	5	0	14
Бүгд	235	580	13	21	191	107	1147

Судалгааны үр дүнгээс харахад судалгаанд хамруулсан баримт бичгүүдийг боловсролын салбарыг хөгжүүлэхэд зориулагдсан бараг ижил цаг хугацаанд хэрэгжих Засгийн Газрын ижил түвшний төлөвлөгөөнүүд гэж үзэх тохиолдолд Мастер төлөвлөгөөнд илэрсэн илэрц харьцангуй цөөн байгаа нь уг судалгааг зөвхөн СӨБ, БДБ-ын түвшнөөр хязгаарлаж, МБС болон дээд боловсролын түвшний сургалтын байгууллагад ажиллах багш, профессор зориулсан 2 хөтөлбөр 10 үйл ажиллагааг судалгаанд хамруулан авч үзээгүйтэй холбоотой байж болно. Гэвч СӨБ, БДБ-ын багш бэлтгэх гэсэн илэрцийг тэндээс илрүүлэх боломж хязгаарлагдмал байсан болно.


Эхний түвшний энэ ерөнхий шинжилгээний үр дүнгээс харахад судалгаанд хамрагдсан аль ч баримт бичгийн хувьд “БК4. Багшаар ажиллах” үе шатны үзүүлэлтүүд харьцангуй жигд тархалттайгаар боловсрогдсон байгаа нь тэдгээрийн боловсруулахдаа кластерийн энэ үе шатанд илүү ач холбогдол өгсөнийг харуулж байна. Тодруулбал, нийт 1147 илэрцийн 928 буюу 80.9 хувь нь зөвхөн энэ үе шатанд хамаарч байна.

Энэ нөхцөл байдал нь багшлах үйлийн хөгжлийн энэ үе шат бусдаасаа харьцангуй олон жилийг хамарч, олон субъект оролцож, багшийн тасралтгүй хөгжлийг хангах гол үйл ажиллагаанд төвлөрсөн олон зохицуулалт шаарддагтай холбоотой байж болно.

Судалгаанд хамрагдсан бүх баримт бичгийн хувьд “БК1. Багш бэлтгэх сургуульд элсүүлэх”, “БК3. Багшийг ажилд авах”, “БК5. Тэтгэвэр тогтоож, ажлаас чөлөөлөх” гэсэн дээрх 4 үе шатуудын 3 холбоос-зангилаа дээр нийт илэрцийн 1.9-4.1 хувь ногдож байгаа нь цаашид хөдөлмөрийн зах зээлд “Багш” мэргэжлийн чанарын төлөөх өрсөлдөөнд анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна (**Error! Reference source not found.**). Өөрөөр хэлбэл, багшлах үйлд хэрхэн чадварлаг элсэгчдийн татах, тэднийг бэлтгэсний дараа өөр салбарт алдахгүйгээр хэрхэн шударгаар сонгон шалгаруулж, ажилд томилох, тэтгэвэр тогтоолгосных дараа олон жил хуримтлуулсан ямар туршлагыг хэрхэн ашиглах талаар алсын хараатай бодлого баримталж, оновчтой хөшүүргүүд бүхий далайцтай арга хэмжээ авах шаардлагатайг харуулж байна.

Зураг 3. Багшлахуйн кластерийн ерөнхий бүтцийн шалгуураар үнэлэгдсэн үр дүн (илэрцийн тоогоор)

(Засгийн газрын хөтөлбөр, төлөвлөгөөний бүх баримт бичгийн хувьд)



Цаашид багшлахуйн кластерийн эдгээр зангилаа асуудалд ач холбогдол өгч, багшлах үйлийн үе шатуудыг хоорондох холбоог зүй тогтлынх дагуу хангаж өгөхгүй бол хичнээн цаг хугацаа, хөрөнгө хүч, хүчин чармайлт гаргасан ч бид асуудлаа бүрэн шийдвэрлэж чадахгүйд хүрнэ. Ийм байдал нь чанар муутай материал нь боловсруулалтын технологи даахгүй, улмаар эдэлгээ муутай байдагтай агаар нэгэн юм.


3.1.2. Багшлахуйн кластерийн үндсэн бүтцийн дэд шалгуураар илрүүлсэн үр дүн

Одоо “Багшлахуйн хөгжлийн кластерийн ерөнхий бүтцэд харгалзах дээрх 7 ерөнхий шалгуураар илэрсэн нийт 1147 илэрцийг ерөнхий шалгуур тус бүрээр нь кластерийн үндсэн бүтцэд харгалзах 33 дэд шалгуур (Хүснэгт 4)-т задлан дараагийн түвшний шинжилгээгээр тодорхойлсон үр дүнтэй танилцъя.

“БК0. Мэргэжлийн чиг баримжаа өгөх” үе шат нь БК01-БК05 гэсэн кодтой, нийт 5 дэд шалгуур (

)-аар тодорхойлогдоно.


Зураг 4. "БК0. Мэргэжлийн чиг баримжаа өгөх" үе шатны агуулгын илэрц



Багшлахуйн кластерийн энэ үе шатанд түүний ерөнхий бүтцийн шалгуураар илэрсэн нийт 9 илэрцийг үндсэн бүтцийн дэд шалгуур бүрээр задлаж үзэхэд Мастер төлөвлөгөөний зорилт, хүрэх үр дүнгийн хэсэгт тус бүрээр 1 илэрц бүхий жигд тархалттай, харин “БК0.4. Багш мэргэжлээр элсэхэд тавигдах шаардлагууд”-тай холбоотой агуулга ЗГҮАХ-т 1, ЗГАХТ-т 3 удаагийн давтамжтайгаар тус тус илэрчээ. Бусад баримт бичигт бүх дэд шалгуурт харгалзах нэг ч агуулга илрээгүй байна. Энэ үр дүнгээс харахад суралцагчдад “Багш” мэргэжлийн чиг баримжаа олгохын тулд БК0.1-БК0.5-ын агуулгын хүрээнд цогц арга хэмжээ авах шаардлагатай.

"БК1. Багш бэлтгэх сургуульд элсүүлэх" төлөв байдал нь БК1.1-БК1.5 гэсэн кодтой, нийт 5 дэд шалгуур (**Error! Reference source not found.**)-аар тодорхойлогдоно.


Зураг 5. "БК1. Багш бэлтгэх сургуульд элсүүлэх" төлөв байдлын агуулгын илэрц



Багшлахуйн кластерийн энэ үе шатанд түүний ерөнхий бүтцийн шалгуураар илэрсэн нийт нийт 29 илэрцийг үндсэн бүтцийн дэд шалгуур бүрээр задлаж үзэхэд ЗГАХХ болон Мастер төлөвлөгөөний салбарын түвшний зорилт, хүрэх үр дүнгийн хэсэгт бүх дэд шалгуураар илрэх агуулга харьцангуй ойролцоо давтамж бүхий жигд тархалттай байна. Харин “БК1.3. Хүйс, жендэрийн асуудлууд” гэсэн дэд шалгуураар ЗГҮАХ, ЗГАХХ, Мастер төлөвлөгөөний салбарын түвшний зорилт, хүрэх үр дүнгийн хэсэгт тус бүр 1 агуулга илэрчээ. Үлдсэн бусад баримт бичигт бүх дэд шалгуурт харгалзах нэг ч агуулга илрээгүй байна.

"БК2. Багш бэлтгэх" үе шат нь БК2.1-БК2.5 гэсэн кодтой нийт 5 дэд шалгуур (**Error! Reference source not found.**)-аар тодорхойлогдоно.


Зураг 6. "БК2. Багш бэлтгэх" үе шатны агуулгын илэрц



Багшлахуйн кластерийн энэ үе шатанд түүний ерөнхий бүтцийн шалгуураар илэрсэн нийт 98 илэрцийг үндсэн бүтцийн дэд шалгуур бүрээр задлаж үзэхэд ЗГАХХ болон Мастер төлөвлөгөөний салбарын түвшний зорилт, үр дүнгийн хэсэгт бүх дэд шалгуураар илрэх агуулга нь 2-26 гэсэн давтамж бүхий жигд тархалттай байна. Мөн “БК2.1. Сургалтын хөтөлбөр, түүний магадлан итгэмжлэл” дэд шалгуурт харгалзах илэрц нь бүх баримт бичгийн хувьд бусад дэд шалгуураасаа 2.5-аас олон дахин их давтамжтай байгаа нь багш бэлтгэхэд сургалтын хөтөлбөр, түүний чанарт бусдаас илүү ач холбогдол өгсөн болох нь харагдаж байна.

"БК3. Багшийг ажилд авах" төлөв байдал нь БК3.1-БК3.4 гэсэн кодтой нийт 4 дэд шалгуур (**Error! Reference source not found.**)-аар тодорхойлогдоно.


Зураг 7. "БК3. Багшийг ажилд авах" төлөв байдлын агуулгын илэрц



Багшлахуйн кластерийн энэ үе шатанд түүний ерөнхий бүтцийн шалгуураар илэрсэн нийт 47 илэрцийг үндсэн бүтцийн дэд шалгуур бүрээр задлаж үзэхэд багш бэлтгэхтэй нэгэн адил ЗГАХХ болон Мастер төлөвлөгөөний салбарын түвшний зорилт, үр дүнгийн хэсэгт бүх дэд шалгуураар илрэх агуулга нь 1-12 хүртэлх давтамжтайгаар жигд тархсан байна. Мөн "БК3.2. Багшаар ажиллах хөдөлмөрийн харилцааны эрх зүйн орчныг судлах" дэд шалгуурт харгалзах илэрц нь бүх баримт бичгийн хувьд бусад дэд шалгуураасаа харьцангуй олон давтамжтай байгаа нь багшийг ажилд авах зохицуулалтад илүү их ач холбогдол өгсөн байна.

"БК4. Багшаар ажиллах" үе шат нь БК4.1-БК4.5 гэсэн кодтой нийт 7 дэд шалгуур (**Error! Reference source not found.**)-аар тодорхойлогдоно.


Зураг 8. "БК4. Багшаар ажиллах" үе шатны агуулгын илэрц



Багшлахуйн кластерийн энэ үе шатанд түүний ерөнхий бүтцийн шалгуураар нийт 928 буюу нийт илэрцийн 80.9 хувийг эзлэх маш олон илэрц бүртгэгдсэн байна. Түүнийг үндсэн бүтцийн дэд шалгуур бүрээр задлаж үзэхэд ЗГҮАХ, ЗГАХХ-г бүх дэд шалгуураар илрэх агуулга нь 96 хүртэлх давтамж бүхий жигд тархалттай байгаа бөгөөд “БК4.3. сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх мэдлэг чадвар” болон “БК4.6.Багшийг тогтоон барих, багшийн хангамж” дэд шалгуурт харгалзах илэрц нь эдгээр баримт бичигт бусад дэд шалгуураасаа харьцангуй олон тоо (43-96) давтамжтай байна. Мөн Мастер төлөвлөгөөний салбарын түвшний зорилт, үр дүн болон хөтөлбөр, үйл ажиллагааны хэсэгт Багшаар ажиллах үе шатны дэд шалгуураар илрэх агуулга нь 27 хүртэлх давтамж бүхий жигд тархалттай, харьцангуй жигд давтамжтай байна.

"БК5. Тэтгэвэр тогтоож, ажлаас чөлөөлөх" төлөв байдал нь БК5.1-БК5.2 гэсэн кодтой нийт 2 дэд шалгуур (**Error! Reference source not found.**)-аар тодорхойлогдоно.


Зураг 9. "БК5. Тэтгэвэр тогтоож, ажлаас чөлөөлөх" төлөв байдлын агуулгын илэрц



Багшлахуйн кластерийн энэ үе шатанд түүний ерөнхий бүтцийн шалгуураар нийт 22 илэрц бүртгэгдсэн байна. Түүнийг үндсэн бүтцийн дэд шалгуур бүрээр задлаж үзэхэд ЗГҮАХ, ЗГАХХ, Мастер төлөвлөгөөний зорилт, хүрэх үр дүнгийн хэсэгт “БК5.1. Хууль тогтоомжийн дагуу төрөөс олгох тэтгэвэр тэтгэмж авах” дэд шалгуураар илрэх агуулга нь нийт илэрцийн 18 буюу 82 хувийг эзэлж байна. Тэтгэвэр тогтоож, ажлаас чөлөөлөх асуудлаар ЗГ-ын хөтөлбөр, төлөвлөгөө, Мастер төлөвлөгөөнд тоон талаасаа цөөн зорилт, үр дүн тусгагдсан байгаа ч тайлангийн 4 дүгээр бүлэгт авч үзэх чанарын анализаар энэ асуудалд төрөөс нэлээд ач холбогдол өгсөн нь харагдана.

"БК6. Зөвлөгөө, туслалцаа авах" үе шат нь БК6.1-БК6.5 гэсэн кодтой нийт 5 дэд шалгуур (**Error! Reference source not found.**)-аар тодорхойлогдоно.

Зураг 10. "БК6. Зөвлөгөө, туслалцаа авах" үе шатны агуулгын илэрц



Багшлахуйн кластерийн энэ үе шатанд түүний ерөнхий бүтцийн шалгуураар нийт 14 илэрц бүртгэгдсэн байна. Түүнийг үндсэн бүтцийн дэд шалгуур бүрээр задлаж үзэхэд ЗГАХХ болон Мастер төлөвлөгөөний салбарын түвшний зорилт, үр дүнгийн хэсэгт бүх дэд шалгуурт хамааралтай агуулга харьцангуй давтамж багатай ч жигд тархалттайгаар илэрсэн байна. Харин “Ажиллаж буй багш нарт зөвлөн туслах” дэд шалгуурт хамаарах агуулга ЗГҮАХ-т 1 удаа бүртгэгдсэн бөгөөд ЗГАХХ-т 2 удаа бүртгэгдэхийн зэрэгцээ “БК6.1. Шаардлагатай тохиолдолд цагийн багшаар ажиллах” дэд шалгуурт хамаарах агуулга 3 удаа тус тус бүртгэгджээ.

3.1.3. Багшлахуйн кластерийн дэлгэрэнгүй бүтцийн индикаторуудаар илрүүлсэн үр дүн

Судалгаанд хамрагдсан баримт бичгүүдээс ялгаж сонгосон, багшлах үйлийн хөгжилд шууд ба дам хамааралтай нийт 208 нэгж обьектод гол 7, дэд 33 шалгуурыг эрэмбэлэн тодорхойлоход зориулагдсан нийт 103 индикаторыг ашиглан энэ түвшний үр дүнг боловсруулав.

Багшлахуйн кластерийн энэ түвшин дэх индикаторуудын агуулгыг бүхэл бүтнээр нь тайлангийн үндсэн хэсэгт хүснэгт ба зургаар үзүүлэхэд тохиромж муутай тул эдгээр 103 индикаторын агуулгын томъёоллыг Хавсралт 1-ээс үзнэ үү. Иймд энэ түвшний судалгааны үр дүнг хэсэг хэсгээр нь багцлан танилцууллаа. Тухайлбал, кластерийн үндсэн бүтцийн 33 дэд шалгуур бүрд харгалзах индикаторуудын тоо ба тэдгээрийн тусламжтайгаар бүртгэгдсэн илэрцийн тоог Хүснэгт 7-д харууллаа.


Хүснэгт 7. Багшлахуйн кластерийн гол ба дэд шалгуур болон индикаторын тоо ба тэдгээрт харгалзах илэрцийн тоо

Үндсэн шалгуур	Дэд шалгуур		Индикатор	
	Агуулга	Тоо	Тоо	Илэрцийн тоо
БК0. Мэргэжлийн чиг	БК0.1. Багш болох хүсэл, эрмэлзэл	5	0	1
	БК0.2. Өөрийгөө таньж, олох боломж		0	1
	БК0.3. Авъяас, чадамж (ability)-аа нээх боломж		0	1
	БК0.4. Багшийн мэргэжлээр элсэхэд тавигдах шаардлагууд		0	5

баримжаа өгөх	БК0.5. "Багш" мэргэжлийн ухуулга, сурталчилгаа		0	1
	Бүгд		0	9
БК1. Багш бэлтгэх сургуульд элсүүлэх	БК1.1. Элсэлтийн шалгалт	5	4	7
	БК1.2. Мэргэжлийн ИДС-ийн элсэлт		2	6
	БК1.3. Хүйс, жендерийн асуудлууд		0	3
	БК1.4. Суралцах арга хэлбэрийн сонголт		2	6
	БК1.5. Тэтгэлэг, дэмжлэг		4	7
	Бүгд		12	29
БК2. Багш бэлтгэх	БК2.1. Сургалтын хөтөлбөр, түүний магадлан итгэмжлэл	5	4	42
	БК2.2. Багшлах дадлага		2	16
	БК2.3. ИДС-ийн профессор багш нарын хангалт, хөгжил		3	7
	БК2.4. ИДС-ийн магадан итгэмжлэл, хөгжил		4	16
	БК2.5. "Багш" мэргэжилтний хангамж		3	17
	Бүгд		16	98
БК3. Багшийг ажилд авах	БК3.1. Ажилд ороход тавигдах шаардлагуудыг судлах	4	3	4
	БК3.2. Багшаар ажиллах хөдөлмөрийн харилцааны эрх зүйн орчинг судлах		8	27
	БК3.3. Хөдөлмөрийн зах зээлээс ажлын байр олох		4	10
	БК3.4. Ажилд орох		4	6
	Бүгд		19	47
БК4. Багшаар ажиллах	БК4.1. Мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах тогтолцоо	7	7	145
	БК4.2. Насан туршийн суралцахуйг дэмжих арга механизм		6	113
	БК4.3. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх мэдлэг, ур чадвар (багшийн стандарт)		7	197
	БК4.4. Ялгаатай зорилтод бүлгүүдэд багшлах мэдлэг, ур чадвар		8	125
	БК4.5. Багш бэлтгэх, БМТХ-ийг хангах үйлийн төлөвлөлт, үнэлгээ, баталгаажилт		4	69
	БК4.6. Багшийг тогтоон барих, багшийн хангамж		10	181
	БК4.7. Цалин хөлс, нийгмийн халамж хамгаалал, амьжиргааны түвшин		6	98
	Бүгд		48	928
БК5. Тэтгэвэр тогтоож, ажлаас чөлөөлөх	БК5.1. Хууль, тогтоомжийн дагуу төрөөс олгох тэтгэвэр, тэтгэмж авах	2	4	18
	БК5.2. Хууль, тогтоомжийн дагуу төрөөс үзүүлэх дэмжлэгийг судлах, эдлэх		4	4
	Бүгд		8	22
БК6. Зөвлөгөө, туслалцаа авах	БК6.1. Шаардлагатай тохиолдолд цагийн багшаар ажиллах	5	0	3
	БК6.2. Ажиллаж буй багш нарт зөвлөн туслах (mentor)		0	5
	БК6.3. Сургалт, судалгаанд оролцох		0	2
	БК6.4. Бүтээл тууривах, ном, гарын авлага бичих, редакторлах		0	2
	БК6.5. Боловсролын чиглэлээр эвсэл холбоонд нэгдэн бусадтай хамтран ажиллах г.м.		0	2
	Бүгд		0	14
Нийт		33	103	1147

Мөн дээрх хүснэгтээр байгуулсан **Error! Reference source not found.**-ээс нийт индикаторын тоо болон нийт агуулгын илэрцийн тоо кластерийн дэд шалгууруудад ямар давтамж, тархалттайгаар бүртгэгдсэн байдлын ерөнхий дүр зургийг харж болно. Тухайлбал, "БК4.1.Мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах тогтолцоо" дэд шалгуураас эхлээд "БК4.7. Цалин хөлс, нийгмийн халамж хамгаалал, амьжиргааны түвшин" дэд шалгууруудад агуулгын 69-197 илэрц бүртгэгдсэн бол бусад дэд шалгууруудад 1-42 агуулга илэрсэн байна.

Зураг 11. Дэд шалгууруудад хамаарах индикаторын болон агуулгын илэрцийн тоо



Нийт 103 индикатораас 35 индикатор 1-3 удаагийн, 18 индикатор 4-9 удаагийн, 29 индикатор 10-19 удаагийн, 21 индикатораар 20-31 удаагийн агуулга тус тус илэрсэн байна. Тухайлбал, эдгээрээс “БК4.Багшаар ажиллах” гол шалгуурт харьяалагдаж буй 21 индикатор бүгд тус бүрдээ 20-32 удаагийн илэрцийг бүртгэгджээ (Хүснэгт 8). Жишээлбэл, судалсан баримт бичгүүдээс багшлахуйн кластертай шууд ба дам хамааралтай байдлаар нь ялгаж тодорхойлсон нийт 208 судалгааны “нэгж объект” дундаас “БК4.3.4 Монголын нэгдмэл үнэт зүйл (түүх, хэл, соёл, зан заншил, үндэсний өв уламжлал, эх оронч сэтгэлгээ, ...)” индикатораар 32 удаагийн, “БК4.3.7 Цахим платформ ба шинэ лаборатор, тоног төхөөрөмжийн ашиглалт” индикатораар 30 удаагийн, “БК4.3.1 Мэргэшлийн шинжлэх ухаан дахь шинэ мэдлэг”, “БК4.3.5 Монгол бичиг, эх хэл” индикатораар 28 удаагийн агуулга тус тус бүртгэгдсэн байна.

Эндээс судалгаанд хамрагдсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд “Монголын нэгдмэл үнэт зүйл”, “Цахим шилжилт”, “Мэргэшлийн шинжлэх ухаан дахь шинэ мэдлэг”, “Монгол бичиг, эх хэл”-ний асуудлууд хамгийн олон давтамжтайгаар илэрч байгаа нь уг баримт бичгүүд нь “Алсын хараа-2050: Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын гол стратегүүдийг хангалттай хэмжээнд тусгасан болохыг харуулж байна.

Хүснэгт 8. Давтамж олонтой илэрц бүхий 21 индикатор

Код	Индикатор	Илэрцийн тоо
БК4.2.6	Бүх түвшний бүх төрлийн хичээлийн судалгаанууд (4.5.3-зөөж авчирсан)	20
БК4.7.5	Хөнгөлөлтүүд, орон сууц, эрүүл мэнд, г.м.	20
БК4.4.4	Хөгжлийн тусгай хэрэгцээтэй хүүхэдэд багшлах	21
БК4.1.7	Багшлахуйтай холбоотой суурь болон хавсрага судалгаа, инновацууд	23
БК4.6.6	Ажлын ачаалал, норм нормативийн мөрдөлт	23
БК4.2.5	Цахим шилжилтэд интеграцчилагдсан байх, гэх мэт	24
БК4.1.4	Санхүүжилтийн болон хяналт-шинжилгээ, үнэлгээний оновчтой тогтолцооны механизм бүхий эрх зүйн зохицуулалтуудтай байх	25
БК4.1.6	Хууль, эрх зүйн орчны зохицуулалт нь багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжсэн байх	25
БК4.2.2	Мэргэжлийн хөгжлөө тасралтгүй хангаж байх зарчим хэрэгждэг байх	25

БК4.3.6	Цахим бичиг үсгийн боловсрол, гэх мэт	25
БК4.6.1	Багш мэргэжилтэн, удирдах ажилтны эрэлт, нийлүүлэлтийн тооцоолол ба төлөвлөлт: хэрэгцээний прогноз, дутагдал, илүүдэл	25
БК4.6.8	Гамшигийн үеийн менежмент, сургалтын байгууллагын орчин дахь осол, гэмтэл	25
БК4.1.5	Багшийн ажил нь боловсролын шатлал, түвшин (СӨБ, БДБ, г.м.) хоорондын залгамж холбоо, нээлттэй шилжилтүүдийг хангахуйц байх	26
БК4.6.5	Ажиллах ба амьдрах орчин нөхцөл	26
БК4.3.2	Дидактик, сурган хүмүүжүүлэх ухаан дахь шинэ мэдлэг	27
БК4.3.3	ТХЗ-ын төлөөх ТХБ-ын агуулга, үнэт зүйл, ТХБ-ын цөм агуулга (тогтвортой хөгжил, хүний эрх, жендэрийн тэгш байдал, дэлхийн иргэний боловсрол)	27
БК4.5.2	Сургалтын хөтөлбөрийн менежментийн циклийн хүрээнд багшийн ажлын гүйцэтгэл ба болон ур чадварын өсөлтийг үнэлэх шалгуур индикаторууд, арга аргачлал: сургалтын байгууллага, багш, сурагчийн үнэлгээний нийцэл	27
БК4.3.1	Мэргэшлийн шинжлэх ухаан дахь шинэ мэдлэг	28
БК4.3.5	Монгол бичиг, эх хэл	28
БК4.3.7	Цахим платформ ба шинэ лаборатор, тоног төхөөрөмжийн ашиглалт	30
БК4.3.4	Монголын нэгдмэл үнэт зүйл (түүх, хэл, соёл, зан заншил, үндэсний өв уламжлал, эх оронч сэтгэлгээ, ...)	32

3.2. Боловсролын салбарт хийгдсэн судалгааны зөвлөмжүүдийн кластер шинжилгээний үр дүнгүүд

Энэ дэд бүлэгт судалгаанд хамрагдсан 11 баримт бичиг (Хүснэгт 1.)-ээс 6-11 дүгээрт бичигдсэн боловсролын салбарт хийгдсэн 6 судалгааны тайланд өгсөн зөвлөмжид хийсэн багшлахуйн кластер шинжилгээний тоон үзүүлэлтийн тархалт, давтамжийг танилцуулна. “Боловсролын суурь мэдээллийн тайлан” болон “Боловсролын бодлогын тойм шинжилгээ”-ний тайлангийн албан ёсны хэвлэлийг интернэтээс авсан бол “Боловсролын салбарын мастер төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэх техник туслалцааны төсөл (дугаар 51103-001)”-ийн хүрээнд хийгдсэн судалгааны хувьд захиалагчаас ирүүлсэн албан ёсны тайлангуудаар хязгаарласан болно. Судлаачдын хувьд судалгааны объект болгож “Алсын хараа 2050: Боловсролын салбарт эрх тэгш байдал, үр ашиг, үр дүнг нэмэгдүүлэх нь (2020)” тайланг сонгосон боловч “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа 2050-ыг дэмжих үүднээс боловсролын дэд салбарын асуудлаар хийгдсэн сүүлийн үеийн судалгааны үр дүнд тулгуурласан ...” зэргийг үндэслэн энэхүү судалгаанд хамруулаагүй болно.

Судалгааны тайлангууд: *Зөвлөмж, Стратеги, Асуудал (Excel файл 3)*

Энэ судалгаанд зориулж судлах объектын 7, судалгааны автоматчилагдсан үр дүнгийн 3, тайлбар 1, нийт 11 Sheet бүхий тусгай Excel файлыг бэлтгэсэн. (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Тоон анализ хийгдсэн судалгааны тайлан ба харгалзах Sheet-ийн нэр (илэрцийн тоогоор)

№	Баримт бичгийн нэр	Sheet-ийн нэр
1	Боловсролын суурь мэдээллийн тайлан	1. БСМТайлан-дэд салбар 2. БСМТайлан-дэд салбар дамнах
2	Монгол Улсын боловсролын бодлогын тойм шинжилгээ	3. Бодлогын шинжилгээ-2019
3	Сургуулийн өмнөх боловсролын салбарын дүн шинжилгээ	4. МТ-өмнө-СӨБ
4	Бага, дунд боловсролын дэд салбарын судалгааны тайлан	5. МТ-өмнө-БДБ
5	Дээд боловсролын дэд салбарын судалгааны тайлан	6. МТ-өмнө-Дээд
6	Монгол улсын Засгийн газрын 2021-2030 он хүртэлх Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөний үнэлгээ	7. МТ-үнэлгээ-Роберт

Эдгээр судалгааны тайлангаас боловсролын дэд салбар, дэд салбар дамнасан асуудалд хамаарах нийт 463 судалгааны нэгж объектыг сонгож, тэдгээрээс багшлах үйлийн хөгжилд шууд хамааралтай 124, дам хамааралтай 49 буюу нийт 173 нэгж объект (**Error! Reference source not found.**)-т кластер шинжилгээ хийж үр дүнг дараах 3 үе шаттайгаар боловсруулав. Үүнд:

- А.Багшлахуйн кластерийн ерөнхий бүтцийн гол шалгуураар илрүүлсэн үр дүн
- Б.Багшлахуйн кластерийн үндсэн бүтцийн дэд шалгуураар илрүүлсэн үр дүн
- В.Багшлахуйн кластерийн дэлгэрэнгүй бүтцийн индикаторуудаар илрүүлсэн үр дүн

3.2.1. Багшлахуйн кластерийн ерөнхий бүтцийн гол шалгуураар илрүүлсэн үр дүн

Кластер шинжилгээний үр дүнг “Багшлахуйн хөгжлийн кластерийн ерөнхий бүтцэд харгалзах 4 үе шат, 3 төлөв байдал (**Error! Reference source not found.**) бүхий 7 гол шалгуур бүрээр судалгааны 6 объект тус бүрт нэгтгэн авч үзье.

2018-2020 онд хийгдсэн судалгаа, үнэлгээ (БСДХХТ-ний үнэлгээ)-ний 6 тайланд тусгагдсан зөвлөмж, санал болгож буй стратеги, зарим тохиолдолд асуудал-бэрхшээлийг багтаасан 173 нэгж объектод хийсэн кластер шинжилгээгээр нийт 804 илэрц тодорхойлогдсоноос 303 буюу 37.7 хувь нь “Боловсролын салбарын суурь мэдээллийн тайлан”-д; 237 буюу 29.5 хувь нь “Монгол Улсын боловсролын бодлогын тойм шинжилгээ”-нд; 197 буюу 24.5 хувь нь “Бага, дунд боловсролын дэд салбарын судалгааны тайлан”-нд; харин бусад тайланд 67 буюу 8.3 хувь нь тус тус ногдож байна (Хүснэгт 10).

Хүснэгт 10. Багшлахуйн кластерийн ерөнхий бүтцийн шалгуураар үнэлэгдсэн үр дүн (илэрцийн тоогоор)

(Судалгааны тайлан тус бүрээр)

	1. БСМТ тайлан-дэд салбар	2. БСМТ тайлан-дэд салбар дамнах	3. Бодлогын шинжилгээ-2019	4. МТ-өмнө-СӨБ	5. МТ-өмнө-БДБ	6. МТ-өмнө-Дээд	7. МТ-үнэлгээ-Роберт	Нийлбэр
БК0. Мэргэжлийн чиг баримжаа өгөх	0	5	0	0	5	0	0	10
БК1. Багш бэлтгэх сургуульд элсүүлэх	0	14	18	0	4	9	0	45
БК2. Багш бэлтгэх	7	42	31	2	11	16	6	115
БК3. Багшийг ажилд авах	9	15	6	2	17	0	0	49
БК4. Багшаар ажиллах	37	170	179	15	157	1	16	575
БК5. Тэтгэвэр тогтоож, ажлаас чөлөөлөх	0	2	3	0	3	0	0	8
БК6. Зөвлөгөө, туслалцаа авах	2	0	0	0	0	0	0	2
Бүгд	55	248	237	19	197	26	22	804


“Дээд боловсролын дэд салбарын судалгааны тайлан”-д багшлахуйтай шууд хамааралтай судалгааны нэгж объект тодорхойлогдоогүйн зэрэгцээ дам хамааралтай 8 нэгж объектоос магадлах шинжилгээгээр тогтоогдсон 26 илэрцийн 9 нь буюу 34.6 хувь нь “БК1. Багш бэлтгэх сургуульд элсүүлэх”-тэй, 16 буюу 61.5 хувь нь “БК2. Багш бэлтгэх”-тэй хамааралтай байна. “Монгол улсын Засгийн газрын 2021-2030 он хүртэлх Боловсролын

салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөний үнэлгээ”-нд өгөгдсөн 11 зөвлөмжийн хураангуй нь Мастер төлөвлөгөөний боловсруулалт руу чиглэсэн байсан учраас багшлахуйд хамааралгүй нэгж объект болно. Зөвлөх Роберт Си тайландаа боловсролын бусад дэд салбараар тусгай зөвлөмж өгөөгүй хэрнээ “Бодлого ба хөтөлбөрийн нийц (хууд.16)” хэсэгт “Багш хөтөлбөрөө эзэмшин заах чадвартай байхын тулд дараах тодорхой үйл ажиллагаануудыг төлөвлөгөөнд тусгах шаардлагатай ...” гээд 9 зөвлөмж өгснийг бид судалгаандаа судалгааны 6 нэгж объект болгож авч үзсэн. Энэ нь энэхүү тайлангийн 3.1.1-д дурьдсан “Мастер төлөвлөгөөнд илэрсэн илэрц харьцангуй цөөн байгаа нь уг судалгааг зөвхөн СӨБ, БДБ-ын түвшинөөр хязгаарлаж, МБС болон дээд боловсролын түвшиний сургалтын байгууллагад ажиллах багш, профессор зориулсан 2 хөтөлбөр 10 үйл ажиллагааг судалгаанд хамруулан авч үзээгүйтэй холбоотой байж болно.” гэсэн бидний таамаглалын “эсрэг” нотолгоо гэж үзэж болох юм. Өөрөөр хэлбэл, зөвлөх Роберт Си. Уэст нь мастер төлөвлөгөөг сайжруулж боловсруулахдаа тусгасан байвал зохих “багш”-тай холбоотой “онцлох орхигдсон хэсэг”-ийг тусгайлан нэрлэсэн атал батлагдсан мастер төлөвлөгөөнд энэ асуудал орхигдсон хэвээр байгаа эсэхийг эргэн харах нөхцөл болж байна. Мөн “Дээд боловсролын дэд салбарын судалгааны тайлан”-аас бусад бүх тайланд “БК4. Багшаар ажиллах” үе шатны илэрц харьцангуй жигд тархалттай тодорхойлогдсон, нийт илэрцийн 71.5 хувь (575)-ийг эзэлж байгаа нь бодлого, төлөвлөлтийн баримт бичигт хийгдсэн судалгааны үр дүнтэй давхцаж байна.

Судалгаанд хамрагдсан бүх тайлангийн нийлбэр дүнгээр авч үзвэл “БК0. Мэргэжлийн чиг баримжааг өгөх”, “БК5. Тэтгэвэр тогтоож, ажлаас чөлөөлөх”, “БК6. Зөвлөгөө, туслалцаа авах”-д нийт илэрцийн 0.25-1.24 хувь, “БК1. Багш бэлтгэх сургуульд элсүүлэх”, “БК3. Багшийг ажилд авах”-д нийт илэрцийн 5.6-6.1 хувь ногдож байгаа нь мөн л бодлогын баримт бичгийн судалгааны үр дүнтэй давхцаж, цаашид судалгаа хийхдээ анхаарал хандуулах, бодит нөхцөл байдал, бэрхшээлтэй асуудлыг иж бүрэн хамруулж судалсан эсэхийг нягтлах шаардлагатайг харуулж байна (Зураг 12).

Зураг 12. Багшлахуйн кластерийн ерөнхий бүтцийн шалгуураар үнэлэгдсэн үр дүн

(судалгааны тайлангийн хувьд)




3.2.2. Багшлахуйн кластерийн үндсэн бүтцийн дэд шалгуураар илрүүлсэн үр дүн

“Багшлахуйн хөгжлийн кластерийн ерөнхий бүтцэд харгалзах 7 ерөнхий шалгуураар илэрсэн нийт 804 илэрцийг ерөнхий шалгуур тус бүрээр нь кластерийн үндсэн бүтцэд харгалзах 33 дэд шалгуур (Хүснэгт 4)-г задлан дараагийн түвшний шинжилгээгээр тодорхойлсон үр дүнтэй танилцъя.

"БК0. Мэргэжлийн чиг баримжаа өгөх" үе шат нь БК01-БК05 гэсэн кодтой, нийт 5 дэд шалгуур (Зураг 13)-аар тодорхойлогдоно.


Зураг 13. "БК0. Мэргэжлийн чиг баримжаа өгөх" үе шатны агуулгын илэрц



Багшлахуйн кластерийн энэ үе шатанд түүний ерөнхий бүтцийн шалгуураар илэрсэн нийт 10 илэрцийг үндсэн бүтцийн дэд шалгуур бүрээр задалж үзэхэд Боловсролын салбарын суурь мэдээллийн тайлангийн “3. Багш бэлтгэхэд дараах хүчин зүйлсийг тооцох хэрэгтэй. 3с. Чадварлаг элсэгчдийг татах цогц арга хэмжээ авах (2. БСМТайлан-дэд салбар дамнах sheet-ийн E16 нүд)”, Бага, дунд боловсролын дэд салбарын судалгааны тайлангийн “10. Багш болох сонирхолтой сурагчдыг суурь боловсролын дараагаас эхлэн сонгон шалгаруулж, чиг зорилготой бэлтгэх тогтолцоог бүсчилсэн байдлаар бий болгох (5. МТ-өмнө-БДБ sheet-ийн W19 нүд)” гэсэн 2 нэгж объектод харгалзаж байна. Энэ хоёр зөвлөмж нь мэргэжлийн чиг баримжаа өгөхтэй холбоотой ерөнхий асуудлыг тусгасан учраас кластерийн энэ үе шатны 5 дэд шалгуурт бүгдэд хамааралтай гэж үзсэн болно. Бусад баримт бичигт бүх дэд шалгуурт харгалзах нэг ч агуулга илрээгүй байна. Мастер төлөвлөгөөний өмнө хийгдсэн судалгааны зөвлөмжүүдээс ийм үр дүн гарсан нь бодлого, төлөвлөлтийн хэсгийн судалгаагаар “суралцагчдад “Багш” мэргэжлийн чиг баримжаа олгохын тулд БК0.1-БК0.5-ын агуулгын хүрээнд цогц арга хэмжээ авах шаардлагатай.” гэсэн гаргалгаа хийх нь зайлшгүй болохыг харуулж байна.

"БК1. Багш бэлтгэх сургуульд элсүүлэх" төлөв байдал нь БК1.1-БК1.5 гэсэн кодтой, нийт 5 дэд шалгуур (Зураг 14)-аар тодорхойлогдоно.


Зураг 14. "БК1. Багш бэлтгэх сургуульд элсүүлэх" төлөв байдлын агуулгын илэрц



Багшлахуйн кластерийн энэ үе шатанд түүний ерөнхий бүтцийн шалгуураар илэрсэн нийт нийт 45 илэрцийг үндсэн бүтцийн дэд шалгуур бүрээр задлаж үзэхэд Боловсролын суурь мэдээллийн тайлан болон МУ-ын Боловсролын бодлогын тойм шинжилгээнд харьцангуй олон буюу 14-18 илэрцтэй байна. Харин “БК1.3. Хүйс, жендерийн асуудлууд” гэсэн дэд шалгуураар зөвхөн Боловсролын суурь мэдээллийн тайланд “Зв. Боловсролын салбар дахь багш, ажилтны жендерийн зохистой харьцааг багш бэлтгэх сургалтаас эхлүүлэн мөрдөх (2. БСМТайлан-дэд салбар дамнах sheet-ийн E15 нүд)” гэсэн нэг нэгж объектод харгалзаж байна. “БК1.2. Мэргэжлийн ИДС-ийн элсэлт” гэсэн дэд шалгуураар 4 судалгааны тайланд нийт 10 илэрц, “БК1.4. Суралцах арга, хэлбэрийн сонголт” гэсэн дэд шалгуураар мөн 4 судалгааны тайланд 14 илэрц, “БК1.5. Тэтгэлэг, дэмжлэг” гэсэн дэд шалгуураар 3 судалгааны тайланд 16 илэрц бүртгэгдсэн байна.

“БК2. Багш бэлтгэх” үе шат нь БК2.1-БК2.5 гэсэн кодтой нийт 5 дэд шалгуур (Зураг 15)-аар тодорхойлогдоно.


Зураг 15. “БК2. Багш бэлтгэх” үе шатны агуулгын илэрц



Багшлахуйн кластерийн энэ үе шатанд түүний ерөнхий бүтцийн шалгуураар илэрсэн нийт 115 илэрцийг үндсэн бүтцийн дэд шалгуур бүрээр задлаж үзэхэд “БК2.1. Сургалтын хөтөлбөр, түүний магадлан итгэмжлэл” дэд шалгуураар илрэх агуулга нь бүх тайланд байсан бөгөөд 2-22 гэсэн харилцан адилгүй давтамж, тархалттай байна. Энэ бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн судалгааны дүнтэй төсөөтэй байгаа бөгөөд багш бэлтгэхэд сургалтын хөтөлбөр, түүний чанарт бусдаас илүү ач холбогдол өгдөг болохыг баталж байна.

“БК3. Багшийг ажилд авах” төлөв байдал нь БК3.1-БК3.4 гэсэн кодтой нийт 4 дэд шалгуур (Зураг 16)-аар тодорхойлогдоно.


Зураг 16. “БК3. Багшийг ажилд авах” төлөв байдлын агуулгын илэрц



Багшлахуйн кластерийн энэ үе шатанд түүний ерөнхий бүтцийн шалгуураар илэрсэн нийт 49 илэрцийг үндсэн бүтцийн дэд шалгуур бүрээр задлаж үзэхэд судалгааны тайлангуудад жигд биш илэрц тодорхойлогдсон байна. Бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн судалгааны нэгэн адилаар “БК3.2. Багшаар ажиллах хөдөлмөрийн харилцааны эрх зүйн орчныг судлах” дэд шалгуурт харгалзах илэрц нь дэд шалгуураасаа харьцангуй олон давтамжтай байгаагаас үзвэл багшийг ажилд авах зохицуулалтад илүү их ач холбогдол өгдөг байна.

“БК4. Багшаар ажиллах” үе шат нь БК4.1-БК4.5 гэсэн кодтой нийт 7 дэд шалгуур (Зураг 17)-аар тодорхойлогдоно.

Зураг 17. “БК4. Багшаар ажиллах” үе шатны агуулгын илэрц



Багшлахуйн кластерийн энэ үе шатанд түүний ерөнхий бүтцийн шалгуураар нийт 575 буюу нийт илэрцийн 71.5 хувийг эзлэх маш олон илэрц бүртгэгдсэн байна. Боловсролын суурь мэдээллийн тайлан, Боловсролын бодлогын тойм шинжилгээ болон Бага, дунд боловсролын дэд салбарын судалгааны тайланд хамгийн олон буюу харгалзан 207 (37+170), 179, 157 илэрц тодорхойлогдсон бөгөөд түүнийг үндсэн бүтцийн дэд шалгуур бүрээр задлаж үзэхэд дэд шалгуураар илрэх агуулга нь 0-62 хүртэлх давтамж бүхий жигд биш тархалттай байна. “БК4.1. Мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах тогтолцоо” болон “БК4.6.Багшийг тогтоон барих, багшийн хангамж” дэд шалгуурт харгалзах илэрц нь эдгээр баримт бичигт бусад дэд шалгуураасаа харьцангуй олон тоо (120-141) давтамжтай байна. Харин “БК4.4. Ялгаатай зорилгод бүлгүүдэд багшлах мэдлэг, ур чадварт тавигдах шалгуур, индикаторууд” маш цөөн (2-7) тоогоор Боловсролын бодлогын тойм шинжилгээ, Бага, дунд боловсролын дэд салбарын судалгааны тайланд тус тус тодорхойлогдсон байгаа нь бодлого, төлөвлөлтийн баримт бичигт хийгдсэн судалгааны үр дүн (**Error! Reference source not found.**)-гээс ялгаатай байна.

“БК5. Тэтгэвэр тогтоож, ажлаас чөлөөлөх” төлөв байдал нь БК5.1-БК5.2 гэсэн кодтой нийт 2 дэд шалгуур (Зураг 18)-аар тодорхойлогдоно.


Зураг 18. “БК5. Тэтгэвэр тогтоож, ажлаас чөлөөлөх” төлөв байдлын агуулгын илэрц



Багшлахуйн кластерийн энэ үе шатанд түүний ерөнхий бүтцийн шалгуураар ердөө 8 илэрц “БК5.1. Хууль тогтоомжийн дагуу төрөөс олгох тэтгэвэр тэтгэмж авах” дэд шалгуураар бүртгэгдсэн байна. Эдгээр 8 илэрц нь 5 нэгж объектод харгалзан тодорхойлогдсоноос зөвхөн нэг буюу “11. Бага ангийн багш нарын өндөр насны тэтгэвэрт гарах нас өндөр байгаа нь багшид болоод сурагчдын үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байна. (5. МТ-өмнө-БДБ sheet-ийн О22 нүд)” гэсэн нэгж объект нь тэтгэвэр, тэтгэмжтэй шууд хамааралтай, бусад нь дам хамааралтай байна.

"БК6. Зөвлөгөө, туслалцаа авах" үе шат нь БК6.1-БК6.5 гэсэн кодтой нийт 5 дэд шалгуур (Зураг 19)-аар тодорхойлогдоно.

Зураг 19. "БК6. Зөвлөгөө, туслалцаа авах" үе шатны агуулгын илэрц



Багшлахуйн кластерийн энэ үе шатанд түүний ерөнхий бүтцийн шалгуураар ердөө 2 илэрц бүртгэгдсэн байна. Энэ 2 илэрц зөвхөн нэг буюу “9. Сурах бичиг зохиох, хянах, эх бэлтгэх, судлах, турших хүний нөөцийг бэлтгэх, сургаж дадлагажуулах (2. БСМТайлан-дэд салбар sheet-ийн F20 нүд)” гэсэн нэгж объектод тодорхойлогдсон бөгөөд БК6.3 болон БК6.4-т дам хамааралтай байна. Үүнээс 2018-2020 хийгдсэн судалгаанд “БК6. Зөвлөгөө, туслалцаа авах”-д хамаарах асуудлыг хамруулаагүй байх магадлалтай байна.

3.2.3. Багшлахуйн кластерийн дэлгэрэнгүй бүтцийн индикаторуудаар илрүүлсэн үр дүн

Судалгаанд хамрагдсан тайлангуудаас ялгаж, сонгосон, багшлах үйлийн хөгжилд шууд ба дам хамааралтай нийт 173 нэгж объектод гол 7, дэд 33 шалгуурыг эрэмбэлэн тодорхойлоход зориулагдсан 3 дахь эрэмбийн нийт 103 индикатор (Хавсрал 1)-ыг ашиглан энэ түвшний үр дүнг боловсруулав.

Кластерийн үндсэн бүтцийн 33 дэд шалгуур бүрд харгалзах индикаторуудын тоо ба тэдгээрийн тусламжтайгаар бүртгэгдсэн илэрцийн тоог Хүснэгт 11-д харууллаа.

Хүснэгт 11. Багилахуйн кластерийн гол ба дэд шалгуур болон индикаторын тоо ба тэдгээрт харгалзах илэрцийн тоо

Үндсэн шалгуур	Дэд шалгуур		Индикатор	
	Агуулга	Тоо	Тоо	Илэрцийн тоо
БК0. Мэргэжлийн чиг баримжаа өгөх	БК0.1. Багш болох хүсэл, эрмэлзэл	5	0	2
	БК0.2. Өөрийгөө таньж, олох боломж		0	2
	БК0.3. Авъяас, чадамж (ability)-аа нээх боломж		0	2
	БК0.4. Багшийн мэргэжлээр элсэхэд тавигдах шаардлагууд		0	2
	БК0.5. "Багш" мэргэжлийн ухуулга, сурталчилгаа		0	2
	Бүгд		0	10
БК1. Багш бэлтгэх сургуульд элсүүлэх	БК1.1. Элсэлтийн шалгалт	5	4	4
	БК1.2. Мэргэжлийн ИДС-ийн элсэлт		2	10
	БК1.3. Хүйс, жендерийн асуудлууд		0	1
	БК1.4. Суралцах арга хэлбэрийн сонголт		2	14
	БК1.5. Тэтгэлэг, дэмжлэг		4	16
	Бүгд		12	45
БК2. Багш бэлтгэх	БК2.1. Сургалтын хөтөлбөр, түүний магадлан итгэмжлэл	5	4	61
	БК2.2. Багшлах дадлага		2	6
	БК2.3. ИДС-ийн профессор багш нарын хангалт, хөгжил		3	10
	БК2.4. ИДС-ийн магадан итгэмжлэл, хөгжил		4	20
	БК2.5. "Багш" мэргэжилтний хангамж		3	18
	Бүгд		16	115
БК3. Багшийг ажилд авах	БК3.1. Ажилд ороход тавигдах шаардлагуудыг судлах	4	3	4
	БК3.2. Багшаар ажиллах хөдөлмөрийн харилцааны эрх зүйн орчинг судлах		8	36
	БК3.3. Хөдөлмөрийн зах зээлээс ажлын байр олох		4	8
	БК3.4. Ажилд орох		4	1
	Бүгд		19	49
БК4. Багшаар ажиллах	БК4.1. Мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах тогтолцоо	7	7	141
	БК4.2. Насан туршийн суралцахуйг дэмжих арга механизм		6	92
	БК4.3. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх мэдлэг, ур чадвар (багшийн стандарт)		7	79
	БК4.4. Ялгаатай зорилтод бүлгүүдэд багшлах мэдлэг, ур чадвар		8	9
	БК4.5. Багш бэлтгэх, БМТХ-ийг хангах үйлийн төлөвлөлт, үнэлгээ, баталгаажилт		4	90
	БК4.6. Багшийг тогтоон барих, багшийн хангамж		10	120
	БК4.7. Цалин хөлс, нийгмийн халамж хамгаалал, амьжиргааны түвшин		6	44
	Бүгд		48	575
БК5. Тэтгэвэр тогтоож, ажлаас чөлөөлөх	БК5.1. Хууль, тогтоомжийн дагуу төрөөс олгох тэтгэвэр, тэтгэмж авах	2	4	8
	БК5.2. Хууль, тогтоомжийн дагуу төрөөс үзүүлэх дэмжлэгийг судлах, эдлэх		4	0
	Бүгд		8	8
БК6. Зөвлөгөө,	БК6.1. Шаардлагатай тохиолдолд цагийн багшаар ажиллах	5	0	0
	БК6.2. Ажиллаж буй багш нарт зөвлөн туслах (mentor)		0	0
	БК6.3. Сургалт, судалгаанд оролцох		0	1

туслалцаа авах	БК6.4. Бүгээл тууривах, ном, гарын авлага бичих, редакторлах	0	1
	БК6.5. Боловсролын чиглэлээр эвсэл холбоонд нэгдэн бусадтай хамтран ажиллах г.м.	0	0
	<i>Бүгд</i>	0	2
Нийт		33	103

Мөн дээрх хүснэгтээр байгуулсан Зураг 20-ээс нийт индикаторын тоо болон нийт агуулгын илэрцийн тоо кластерийн дэд шалгууруудад ямар давтамж, тархалттайгаар бүртгэгдсэн байдлын ерөнхий дүр зургийг харж болно. Тухайлбал, “БК4. Багшаар ажиллах” үе шатад нэг индикаторт дунджаар агуулгын 13 илэрц ногдохоор байгаагаас “БК4.5. Багш бэлтгэх, БМТХ-ийг хангах үйлийн төлөвлөлт, үнэлгээ, баталгаажилт” дэд шалгуурт хамгийн их буюу нэг индикаторт 22 илэрц, харин “БК4.4. Ялгаатай зорилтод бүлгүүдэд багшлах мэдлэг, ур чадвар” шалгуурт хамгийн цөөн буюу нэг индикаторт 1 илэрц ногдохоор байна. “БК2. Багш бэлтгэх” үе шатад “БК2.1. Сургалтын хөтөлбөр, түүний магадлан итгэмжлэл” дэд шалгуурт нэг индикаторт 15 илэрц ноогдож байхад бусад дэд шалгуурт нэг индикаторт 3-6 илэрц ноогдож байна. Харин “БК1. Мэргэжлийн чиг баримжаа өгөх”, “БК3. Багшийг ажилд авах”, “БК5. Тэтгэвэр тогтоож, ажлаас чөлөөлөх”, “БК6. Зөвлөгөө, туслалцаа авах” гэсэн үе шат, төлөв байдал (“БК3.2. Багшаар ажиллах хөдөлмөрийн харилцааны эрх зүйн орчинг судлах”-ыг эс тооцвол)-д нэг индикаторт 2-оос доош агуулга илэрсэн байна.

Зураг 20. Дэд шалгууруудад хамаарах индикаторын болон агуулгын илэрцийн тоо



Нийт 114 индикатор (3 дахь түвшний 103 дээр цааш задраагүй 2 дахь түвшний 11 индикатор ороод)-аас 33 индикатораар 1-2 удаагийн, 32 индикатораар 3-7 удаагийн, 10 индикатораар 8-11 удаагийн, 21 индикатораар 13-23 удаагийн, 4 индикатораар 28-30 удаагийн, 1 индикатораар 37 удаагийн агуулга тус тус илэрсэн байна. Тухайлбал, эдгээрээс 10-аас олон илэрц бүртгэгдсэн индикаторыг ялгаж үзвэл “БК2. Багш бэлтгэх” гол шалгуурт харьяалагдаж буй 3, “БК4.Багшаар ажиллах” гол шалгуурт харьяалагдаж буй 29 индикатор байна (Хүснэгт 12). Жишээлбэл, судалсан баримт бичгүүдээс багшлахуйн кластертай шууд ба дам хамааралтай байдлаар нь ялгаж тодорхойлсон нийт 175 судалгааны “нэгж объект” дундаас “БК4.1.1. Хөгжлийн бодлого, зарчмыг бүтээлчээр хэрэгжүүлэхэд зориулагдсан сонирхогч талууд, хувь нийлүүлэгчдийн оролцоо түншилэлд суурилсан байх” индикатораар 37 удаагийн, “БК4.5.2. Сургалтын хөтөлбөрийн менежментийн циклийн хүрээнд багшийн

ажлын гүйцэтгэл ба болон ур чадварын өсөлтийг үнэлэх шалгуур индикаторууд, арга аргачлал: сургалтын байгууллага, багш, сурагчийн үнэлгээний нийцэл” индикатораар 30 удаагийн, “БК4.5.4. Мэргэжлийн болон сургалтын байгууллагын хүний нөөцийн хөгжлийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, чанарын дотоод ба хөндлөнгийн баталгаажуулалт” индикатораар 29 удаагийн агуулга тус тус бүртгэгдсэн байна.

Хүснэгт 12. Давтамж олонтой илэрц бүхий 32 индикатор

№	Код	Индикатор	Илэрцийн тоо
1.	БК2.1.1	Сургалтын хөтөлбөрүүдийн төрөл, ангилал, сонголт хийх, мэргэжил, мэргэшлээрээ хөрвөх боломж	13
2.	БК2.1.2	Багшийн хөтөлбөр, хөтөлбөрт тавигдах шаардлагууд ба стандартууд	23
3.	БК2.1.4	Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, СӨБ, БДБ-ын салбарт хийгдэж буй сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний шинэчлэл, өөрчлөлтийг хурдтай мэдэрч тусгах механизм	18
4.	БК4.1.1	Хөгжлийн бодлого, зарчмыг бүтээлчээр хэрэгжүүлэхэд зориулагдсан сонирхогч талууд, хувь нийлүүлэгчдийн оролцоо түншлэлд суурилсан байх	37
5.	БК4.1.2	Үндэсний, орон нутгийн, сургалт байгууллагын, хувь хүний түвшинг бүхэлд нь хамарсан бүтэц, бүрэлдэхүүн бүхий байх	19
6.	БК4.1.3	Нээлттэй эрэлт-нийлүүлэлтэд суурилсан байх	15
7.	БК4.1.4	Санхүүжилтийн болон хяналт-шинжилгээ, үнэлгээний оновчтой тогтолцооны механизм бүхий эрх зүйн зохицуулалтуудтай байх	28
8.	БК4.1.5	Багшийн ажил нь боловсролын шатлал, түвшин (СӨБ, БДБ, г.м.) хоорондын залгамж холбоо, нээлттэй шилжилтүүдийг хангахуйц байх	16
9.	БК4.1.6	Хууль, эрх зүйн орчны зохицуулалт нь багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжсэн байх	13
10.	БК4.1.7	Багшлахуйтай холбоотой суурь болон хавсрага судалгаа, инновацууд	13
11.	БК4.2.1	Багш бүрт өөрийн хэрэгцээгээ үндэслэсэн сонголт хийх боломж олгосон байх	16
12.	БК4.2.2	Мэргэжлийн хөгжлөө тасралтгүй хангаж байх зарчим хэрэгждэг байх	20
13.	БК4.2.3	Нээлттэй эрэлт-нийлүүлэлтийн зохистой хувь харьцаат механизмтай байх	13
14.	БК4.2.4	Боловсролын удирдлагын мэдээллийн систем (БУМС)-д суурилсан байх	17
15.	БК4.2.5	Цахим шилжилтэд интеграцчилагдсан байх, гэх мэт	23
16.	БК4.3.2	Дидактик, сурган хүмүүжүүлэх ухаан дахь шинэ мэдлэг	10
17.	БК4.3.3	ТХЗ-ын төлөөх ТХБ-ын агуулга, үнэт зүйл, ТХБ-ын цөм агуулга (тогтвортой хөгжил, хүний эрх, жендэрийн тэгш байдал, дэлхийн иргэний боловсрол)	18
18.	БК4.3.4	Монголын нэгдмэл үнэт зүйл (түүх, хэл, соёл, зан заншил, үндэсний өв уламжлал, эх оронч сэтгэлгээ, ...)	10
19.	БК4.3.6	Цахим бичиг үсгийн боловсрол, гэх мэт	14
20.	БК4.3.7	Цахим платформ ба шинэ лаборатор, тоног төхөөрөмжийн ашиглалт	13
21.	БК4.5.1	Багшаар бэлтгэж, багшлах эрх олгох, тэдний тасралтгүй хөгжлийг үнэлж, мэргэжлийн зэрэг олгох, зохиогчийн эрх олгох гэрчилгээжилт ба баталгаажилт	16
22.	БК4.5.2	Сургалтын хөтөлбөрийн менежментийн циклийн хүрээнд багшийн ажлын гүйцэтгэл ба болон ур чадварын өсөлтийг үнэлэх шалгуур индикаторууд, арга аргачлал: сургалтын байгууллага, багш, сурагчийн үнэлгээний нийцэл	30
23.	БК4.5.3	Багшийн ажлын төлөвлөлт, үнэлгээ, дүгнэлт	15
24.	БК4.5.4	Мэргэжлийн болон сургалтын байгууллагын хүний нөөцийн хөгжлийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, чанарын дотоод ба хөндлөнгийн баталгаажуулалт	29
25.	БК4.6.1	Багш мэргэжилтэн, удирдах ажилтны эрэлт, нийлүүлэлтийн тооцоолол ба төлөвлөлт: хэрэгцээний прогноз, дутагдал, илүүдэл	21
26.	БК4.6.3	МХТехнологи	10

№	Код	Индикатор	Илэрцийн тоо
27.	БК4.6.5	Ажиллах ба амьдрах орчин нөхцөл	14
28.	БК4.6.6	Ажлын ачаалал, норм нормативийн мөрдөлт	15
29.	БК4.6.7	Цалин хөлс ба урамшуулал	11
30.	БК4.6.9	Мерит системд тулгурласан хүний нөөцийн тогтвортой хөгжлийн бодлого	28
31.	БК4.7.3	Нэмэгдлүүд: бүсийн болон, орон нутгийн, нэрэмжит, мэргэжлийн зэргийн, ур чадварын, г.м.	10
32.	БК4.7.5	Хөнгөлөлтүүд, орон сууц, эрүүл мэнд, г.м.	11

Гэвч бидний судалгааны энэ үр дүн нь 2018-2020 онд хийгдсэн судалгаануудад Багшлахуйн кластерийн тухайн индикатораар тодорхойлогдох асуудал “бүрэн тусгагдсан” гэдгийг илэрхийлэхгүй бөгөөд харин цаашид боловсролын салбарын судалгаанд Багшлахуйтай холбоотой асуудлыг авч үзэхдээ энэхүү Багшлахуйн кластерийг судалгааны үндсэн дээр боловсронгуй болгож хэрэглэх шаардлагатайг илэрхийлнэ. Энэ талаар энэхүү тайлангийн 4.3-т тодорхой тайлбарлана.

ДӨРӨВ. МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН (ЧАНАРЫН ШИНЖИЛГЭЭ)

Энэ бүлэгт кластер шинжилгээний үр дүнд суурилан хийсэн магадлан шинжилгээний санал, зөвлөмжүүдийг “Алсын хараа 2020-2050”, ЗГ-ын дунд хугацааны төлөвлөгөөнүүд, боловсролын салбарт хийгдсэн судалгааны зөвлөмжүүд гэсэн 3 түвшинд ангилан боловсруулсан чанарын анализын үр дүнг танилцуулна. Чанарын анализын үр дүнг судалгаанд хамруулсан 11 баримт бичгийн агуулгын зорилт, хүрэх үр дүнгийн хүрээнд “Багшлахуйн кластер”-ийн 143 шалгуур, индикаторуудын тусламжтайгаар илрүүлсэн нийт 1951 илэрц бүхий 383 нэгж объектод “санал, зөвлөмж” хэлбэрээр өгөгдсөн үр дүнг нэгтгэн дэд бүлэг бүрийн онцлогтойгоор багцлан боловсруулсан болно.

4.1. “Алсын хараа 2020-2050: Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого”-д хийгдсэн магадлан шинжилгээний үр дүн

УИХ-ын 2020 оны 52-р тогтоолын 1-р хавсралтаар “АЛСЫН ХАРАА-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2-р хавсралтаар 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааг тус тус баталсан.

Уг баримт бичиг 580 гаруй хуудастай томоохон баримт бичиг тул түүнд тусгагдсан боловсролын асуудлууд, ялангуяа багшлахуйтай холбоотой агуулгыг судлахад хэрэглэгчдэд хялбар дөхөмтэй болгох зорилгоор энэ баримт бичгийг судалж, дараах 9 Sheet бүхий Excel файл 1-ийг бэлтгэсэн. Үүнд:

- **Sheet 1:** Монгол улсын хөгжлийн загвар: *Урт хугацааны хөгжлийн бодлогын суурь үнэт зүйл (УИХ-ын 2020 оны 52-р тогтоолын 1-р хавсралт)*
- **Sheet 2:** Монгол улсын хөгжлийн загвар: *Урт хугацааны хөгжлийн бодлогын 9 эрхэм зорилго, хөгжлийн суурь шийдлүүд, зарим түлхүүр нэр томъёо (УИХ-ын 2020 оны 52-р тогтоолын 1-р хавсралт)*
- **Sheet 3:** Бүлэг Нэг. Үндэсний нэгдмэл үнэт зүйл: *Зорилго ба 5 зорилт, тэдгээрийг хөгжлийн үе шат бүрд харгалзуулсан задаргаа (УИХ-ын 2020 оны 52-р тогтоолын 1-р хавсралт)*
- **Sheet 4:** Бүлэг Нэг. Үндэсний нэгдмэл үнэт зүйл: *5 зорилт бүрийн хүрээнд хөгжлийн үе шатуудад харгалзуулан тодорхойлон хүрэх үр дүнгүүд (УИХ-ын 2020 оны 52-р тогтоолын 1-р хавсралт)*
- **Sheet 5:** Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого: *2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (УИХ-ын 2020 оны 52-р тогтоолын 2-р хавсралт)*

- **Sheet 6:** Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого: Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин (УИХ-ын 2020 оны 52-р тогтоолын 3-р хавсралт)
- **Sheet 7:** Бүлэг Хоёр. Хүний хөгжил: **Боловсрол; Зорилго, хөгжлийн үе шат бүр дэх бодлогууд, тэдгээрт харгалзах хүрэх үр дүн (УИХ-ын 2020 оны 52-р тогтоолын 1-р хавсралт)**
- **Sheet 8:** Бүлэг Хоёр. Хүний хөгжил: **Боловсрол; Зорилт 2.1 Бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (УИХ-ын 2020 оны 52-р тогтоолын 2-р хавсралт)**
- **Sheet 9:** Бүлэг Хоёр. Хүний хөгжил: **Боловсрол; Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин (УИХ, 2020 оны 52-р тогтоолын 3-р хавсралт)**

Энэ цахим мэдээлэл нь боловсролын салбарт аливаа асуудлаар урт, дунд, богино хугацаанд баримтлах бодлого, онол, арга зүйн шийдэл бүхий үзэл баримтлал, боловсруулах, стратегийн болон үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад үргэлж анхаарал, хараандаа байлгаж, Монгол улсын хөгжлийн жанжин шугам болгон баримталж байхад тус дэмтэй гэж тус судалгааны багийн зүгээс үзсэн болно.

“Алсын хараа 2020-2050” баримт бичиг нь урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг учраас энэхүү судалгааны ажлын хүрээнд түүнд “Багшлахуйн кластер шинжилгээ” хийгээгүй болно. Мөн энэ бодлогын баримт бичгийн агуулга, үзэл санаа нь боловсролын салбарын урт болон дунд хугацааны баримт бичигт хэрхэн тусгалаа олсон талаарх асуудлыг хөндөөгүй бөгөөд зөвхөн салбарын дунд хугацааны төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр нарийвчилсан төлөвлөлт хийхдээ зайлшгүй анхаарах хэрэгтэй зарим нэг ерөнхий санал зөвлөмж өгсөн болно.

4.1.1. Монгол Улсын хөгжлийн загвар

“Алсын хараа 2020-2050”-д “Ирэх 30 жилийн хугацаанд өнгөрсөн, одоо, ирээдүйн орчилд монголчуудын оюун санаа, хурд, мөн чанар амилж, тэргүүлэгч гүрэн болох алсын хараа биеллээ олж, үндэсний дахин давтагдашгүй онцлогт суурилсан дэлхийн дэвшилтэд үзэл санаатай хослуулсан загвар нь Монгол Улсын хөгжлийн загвар байх”-аар тодорхойлсон байна. Энэ загварын хүрээнд монгол Улсын суурь үнэт зүйл, хөгжлийн суурь шийдлүүд, эрхэм зорилгуудыг үндэсний түвшинд дараах байдлаар тус тус тодорхойлжээ.

Монгол Улсын суурь үнэт зүйл

Монгол Улсын хөгжлийн загварт суурь үнэт зүйлийг Монголын эзэн гүрэн, өнөөгийн ба ирээдүйн Монгол Улс гэсэн 3 цагийн хэлхээнд авч үзсэн байдлыг Файл 1-ийн Sheet 1-ээс үзнэ үү. Тайлангийн энэ хэсэгт тэдгээрээс боловсролд хамгийн ойр хамааралтай гэж үзэж болохоор дараах үнэт зүйлийг Хүснэгт 13-д үзүүлэв.

Хүснэгт 13. Боловсролд хамаарах Монгол Улсын суурь үнэт зүйл

Үнэт зүйл	Хэмжээс	Одоо (2019)	Ирээдүйд (2050)
Оюун санаа	Сайн засаглал Ногоон хөгжил Нийгмийн хөгжил	Дэлхийн хөгжлийн суурь үзүүлэлт хангалтгүй нийгэм	Дундаж орлоготой, боловсролтой , эрүүл, идэвхитэй иргэд
Хурд	Эдийн засаг Дэд бүтэц Бүсчилсэн хөгжил	Таатай байршил-үр ашиггүй хуваарилалт	Мэдээллийн технологийн дэвшилд тулгуурласан хөгжил
Мөн чанар	Монгол хүн	Ирээдүйдээ итгэлгүй-хуучнаа санагалзагчид	Ирээдүйдээ итгэлтэй, төгс-чинээлэг дундаж давхаргад хамаарах хүн

	Үндэсний нэгдмэл үнэт зүйлс		
	Үндэсний аюулгүй байдал		

2050 он гэхэд хүрсэн байх дээрх суурь үнэт зүйлийн хөгжлийн гол агуулгыг илэрхийлж буй “**Дундаж давхарга**” гэсэн түлхүүр нэр томъёог уг баримт бичигт дараах байдлаар тодорхойлжээ.

“Орлогын голчийн 67-200 хувьтай тэнцэх хэмжээний орлоготой, байнгын хөдөлмөр эрхэлдэг, орон сууцанд амьдардаг, жилд ядаж нэг удаа эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамрагдаж чаддаг, жилд ядаж нэг удаа гэр бүлээрээ өөрсдийн хүссэн улс орон руу аяллаар явах боломжтой, хадгаламж хуримтлалтай (хүүхдийнхээ ирээдүйд зориулсан эсвэл өрхийн санхүүгийн эрсдэлт байдлыг даван туулах хэмжээний), нийгмийн идэвх оролцоо сайтай хүн амыг “**Дундаж давхарга**”-ын гэж үзнэ”.

Хөгжлийн суурь шийдлүүд

“Алсын хараа 2020-2050”-д Монгол Улсын хөгжлийн шинэ загварт хөтлөх дараах **суурь шийдлүүд** хийгджээ (Файл 1-ийн Sheet 2). Тухайлбал,

Бодлогын цөм нь Монгол хүн.

Урт хугацааны бодлогын тулгуур суурь нь ногоон хөгжил, эдийн засгийн хөгжил, нийгмийн хөгжлийн бодлогын мөн чанарын шүтэлцээ, харилцан хамаарал

Бодлогын суурь эхлэлтийн цэг нь Ногоон хөгжил байна.

- Байгаль орчны нөөц бололцоо, газар зүйн байршлын давуу талдаа тулгуурлан эдийн засаг, дэд бүтэц, бүс нутгийг хөгжүүлнэ.
- Эдийн засгийн хөгжлөөр бий болсон баялагийг хүндээ хүргэж, нийгмийн хөгжлийг хангана.
- Ухамсартай, боловсролтой иргэд ирээдүйд байгаль орчноо зохистой ашиглах болно.

Тулгуур бүтэц нь ногоон хөгжил, эдийн засгийн хөгжил, нийгмийн хөгжлийн үр нөлөөг хүндээ хүргэх гурвалжингийн доторх дотоод тулгуур бүтэц нь сайн засаглал, үндэсний үнэт зүйл, үндэстний аюулгүй байдлын бодлогоор тус тодорхойлогдоно. Тухайлбал,

- Эдийн засгийн хөгжлийг нийгмийн хөгжилд үр дүнтэй хүргэх арга зам нь Сайн засаглалын бодлого байна. Хэрэв хүн өөрөө л хичээвэл хуулийн орчин нь шударга учир хүн бүрд тэгш боломж бүрдэнэ.
- Нийгмийн хөгжлийн үр дүнд үндэсний нэгдмэл үнэт зүйлээ эрхэмлэсэн, нийгмийн оролцоотой, иргэдийг төлөвшүүлснээр ногоон хөгжлийн үндэс суурь тавигдана
- Ногоон хөгжлийн болон эдийн засгийн хөгжлийн бодлого нь Үндэсний аюулгүй байдлын бодлогод тулгуурлана.

Урт хугацааны бодлогын эцсийн эрхэм зорилго нь чинээлэг-дундаж давхаргыг бий болгох явдал юм. Үүний тулд баялаг бүтээхийг хүссэн иргэн бүрд нээлттэй, шударга бизнесийн орчин, тэгш үйлчилдэг хуулийн засаглал ижил боломжийг олгох болно.

Баялагийн хуваарилалтын хамгийн төгс, зохистой хувилбарыг зөв талсттай, юунд ч үл автах хатуу "Очир эрдэнэ"-өөр дүрслэн илэрхийлж болно.

Эрхэм зорилгууд

Монгол Улсын 2050 он хүртэлх урт хугацааны хөгжлийн бодлогын энэ баримт бичигт дараах бодлогын түвшний 9 эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна. Үүнд:

1. **Үндэсний нэгдмэл үнэт зүйл:** Үндэсний нэгдмэл үнэт зүйлийн гүн ухамсар, дархлаатай улс үндэстэн болно.
2. **Хүний хөгжил:** Монгол Улсын хүний хөгжлийн индексийг 09-д хүргэж, аз жаргалын индексээр дэлхийн эхний 10 орны тоонд багтана
3. **Амьдралын чанар ба дундаж давхарга:** Сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг 2050 он гэхэд нийт хүн амын 80 хувьд хүргэнэ.
4. **Эдийн засаг:** ДНБ 6.1 дахин нэмэгдэж, нэг хүнд оногдох ДНБ 3.6 дахин өсөж, 15.000 ам. долларт хүрч дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын босгыг давна
5. **Сайн засаглал:** Тогтвортой засаглал тогтож, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.
6. **Ногоон хөгжил:** Ногоон хөгжлийг эрхэмлэн байгаль орчны тогтвортой байдлыг хангана.
7. **Амар тайван, аюулгүй нийгэм:** Үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалах гадаад, дотоод таатай орчин бүрдэнэ.
8. **Бүсчилсэн хөгжил:** Бүс нутгийн эдийн засгийн интеграцад нэгдсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, өрсөлдөх чадвартай улс доторх бүсүүдийг хөгжүүлнэ.
9. **Улаанбаатар ба дагуул хот:** Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй хүн төвтэй хот болгон хөгжүүлнэ.

4.1.2. Үндэсний нэгдмэл үнэт зүйлийн урт хугацааны хөгжлийн бодлого

Монгол улсын суурь үнэт зүйл, хөгжлийн суурь шийдлүүдэд суурилсан 2050 он хүртэлх хөгжлийн дээрх 9 эрхэм зорилгоос эхний 3 эрхэм зорилгын агуулгыг судалж, боловсролын салбарт, түүний дотор багшлахуйн асуудалд хамаарах агуулгыг өөрсдийн энэхүү судалгаанд болон боловсролын салбарын хэрэглэгчдэд тусгайлан зориулсан өгөгдөл, мэдээлэл болгон бэлтгэж энэхүү судалгаанд ашигласан болно.

Алсын хараа 2020-2050 баримт бичгийн нэгдүгээр бүлэг болох “Үндэсний нэгдмэл үнэт зүйл” гэсэн бүлэгт эхний эрхэм зорилгыг хөгжлийн бодлого, зорилго, зорилт, тус бүр 10 жилийн хугацаатай хөгжлийн 3 үе шатанд хүрсэн байх үр дүн болгон нарийвчилж, тэдгээрийг дараах байдлаар тодорхойлжээ (*Файл 1, Sheet 3*).

Зорилго 1. Орчин үеийн шинжлэх ухааны арга зүйгээр нарийвчлан судалж, хөдөлшгүй бодит баримтад үндэслэсэн “эх хэл, эх түүх, өв соёлыг” нийт хүн амд төлөвшүүлж, үндэсний ижилсэл-ондоошлын гүн ухамсар, дархлаатай үндэстэн-улс байгуулахад тулгуур болохуйц нэгдмэл үнэт зүйлсийг цогцлооно.

Зорилт 1.1. Үндэсний бахархал, эв нэгдэл: Төрт ёсны уламжлал, түүх, соёлын дурсгал, утга зохиол, урлагийн бүтээлээр үндэсний бахархал төлөвшүүлж, эх оронч үзэл, эв нэгдлийг нягтруулна.

Зорилт 1.2. Нүүдлийн соёл иргэншилт монгол: Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээгч монгол хүн төвтэй нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болно.

Зорилт 1.3. Монгол хэл, бичиг: Монгол хэл, бичгээ үндэсний үнэт зүйлийн бүрдэл болгон иргэн бүр чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшинэ.

Зорилт 1.4. Эрдэм судлал-нийгмийн соён гэгээрэл: Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэл болсон монголын түүх, хэл, соёл, ёс заншил, нүүдлийн соёл иргэншил, шашин, гүн ухааны судалгааг хийж нийтийн хүртээл болгон хэвшүүлж, нийгмийн соён гэгээрлийг өндөр түвшинд хүргэнэ.

Зорилт 1.5. Дэлхийн монгол: Дэлхий дахинд монгол үндэсний үнэт зүйлсийн дархлаа тогтож, монгол соёлыг түгээн дэлгэрүүлж, гадаад нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлж, хилийн чанад дахь монголчууд, монгол угсаатны хамтын ажиллагаа төлөвшинэ.

Хүрэх үр дүнгүүд: Дээрх зорилтын хүрээнд хүрэх үр дүнгүүд тэдгээрийн үнэлэх шалгуур индикаторуудыг уг баримт бичигт нарийвчлан тодорхойлсон бөгөөд тэдгээрийг Файл 1-ийн Sheet 4, Sheet 6-аас үзнэ үү.

Үйл ажиллагаа: “Алсын хараа-2020-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын “Үндэсний нэгдмэл үнэт зүйл” бүлэгт тодорхойлсон зорилтуудыг хэрэгжүүлэх эхний үе шат болох 2021-2030 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 64 үйл ажиллагаанаас боловсрол болон багшлахуйд хамаарах дараах 16 үйл ажиллагааг онцлон ялгав. Эдгээр үйл ажиллагаа нь боловсролын тогтолцоог салбар дамнасан төлөвлөлтийн арга хандлагаар болон нийгэм, олон нийт, иргэдийн бүтээлч оролцоотойгоор Монгол улсын ТХ-ийн төлөө хувирган өөрчлөх гол үндэслэл болох ач холбогдолтой гэж үзлээ (Хүснэгт 14).

Хүснэгт 14. “Алсын хараа-2050: 2021-2030 онд үндэсний түвшинд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тусгагдсан багшлахуйтай холбоотой үйл ажиллагаанууд

Үндэсний бахархал, эв нэгдэл: Зорилт 1.1. Төрт ёсны уламжлал, түүх, соёлын дурсгал, утга зохиол, урлагийн бүтээлээр үндэсний бахархал төлөвшүүлж, эх оронч үзэл, эв нэгдлийг нягтруулна.	Шууд	1.1.19. Соёл урлагийг хүүхэд, залуучууд, бүх нийтэд түгээн дэлгэрүүлэхэд шаардлагатай театр, чуулга, соёлын ордны барилгыг шинээр барьж, тоног төхөөрөмжийг шинэчилнэ.
	Дам	1.1.7. Үндэсний бахархал болсон ном судар, баримтат өвүүдийг нийтэд таниулан сурталчилна. 1.1.14. Дэлхийн болон монгол сонгодог зохиолууд, үндэсний онцлогтой утга зохиолын бүтээлүүдээс бүрдсэн бичил номын сан, гэрийн номын сантай болгох аян өрнүүлж хүүхэд залууст заавал унших ном, сонсох подкаст, үзэх кино, цахим хуудас бий болгоно.
Нүүдлийн соёл иргэншилт монгол Зорилт 1.2. Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээгч монгол хүн төвтэй нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болно.	Шууд	1.2.3. Боловсролын сургалтын хөтөлбөрт нүүдэлчин ахуй, зан заншил, өв соёлын агуулгыг тусгаж, бүх шатны боловсролын байгууллагын суралцагчдад үндэсний өв соёл, уламжлалт наадгайн төрлийн мэдлэг, чадвар эзэмшүүлнэ.
	Дам	1.2.1. “Гэр бүл-монгол соёлын анхдагч орчин” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж, “Монгол хүүхэд”, “Монгол гэр бүл”, “Монгол төрийн гэр бүлийн талаарх бодлого” гэсэн гуравласан холбоог үүсгэж, гэр бүлийн гишүүдийн харилцан хүндлэл, ажил үүрэг, түүний дотор эцэг эхийн үүргийн тэгш хуваарь, эх хүүхдийн халамж, хамгааллын үнэт зүйлсэд суурилсан уламжлалт ёсыг хадгална. 1.2.5. Үндэсний ижилсэл, соёлын дархлаатай монгол хүнийг бэлтгэхэд чиглэсэн өв соёлын өргөө, соёлын төвүүд, үндэсний спортын дугуйлангуудын үйл ажиллагааг дэмжиж, соёлын биет бус өв, язгуур урлагийн шавь сургалтыг бий болгосон бүлэг, хамт олон, өвлөн уламжлагчдыг дэмжиж урамшуулах тогтолцоог бий болгоно.
Монгол хэл, бичиг Зорилт 1.3. Монгол хэл, бичгээ үндэсний үнэт зүйлийн бүрдэл болгон иргэн бүр чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшинэ.	Шууд	1.3.5. Нутгийн хэл, соёл, аман аялгууг хадгалах, хамгаалах чиглэлд бүтээлч хөтөлбөрүүд хэрэгжүүлж монгол хэл, бичгийг гадаад, дотоодод түгээн дэлгэрүүлж байгаа байгууллага, багш, суралцагчдыг урамшуулж дэмжинэ. 1.3.10. “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ыг хэрэгжүүлнэ.
	Дам	1.3.1. Дэлхийн шинжлэх ухаан, техник, технологийн нэршил, нэр томъёог монгол хэлэнд нутагшуулан баяжуулах, мэдлэг шингэсэн монгол хэлний үгсийн санг бий болгох ажлыг тогтмолжуулж, хялбаршуулсан болон шинжлэх ухааны салбар бүрийн мэргэжлийн нэр томъёоны толь боловсруулан, цахим хэлбэрээр түгээж, нийтийн хэрэглээнд нэвтрүүлнэ.

		1.3.3. Төрийн болон албан хэрэг хөтлөлтийн монгол хэл, бичигт тавигдах шалгуур үзүүлэлтийг өндөрсгөж, төрийн албан хаагчаас монгол хэлний шалгалт авч, шалгуур хангасан байх шаардлага тавина.
		1.3.6. Гадаадын иргэдэд монгол хэл заах сургууль, тэнхимийг нэмэгдүүлж, зуны сургалтыг дэмжинэ.
Эрдэм судлал-нийгмийн соён гэгээрэл Зорилт 1.4. Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэл болсон монголын түүх, хэл, соёл, ёс заншил, нүүдлийн соёл	Дам	1.4.6. Монгол хүний ёс суртахууны хэм хэмжээний талаарх судалгааг өргөжүүлэн хүүхэд залуус, төрийн албан хаагч, хууль, хүчний байгууллагын ажилтны ёс суртахууны нарийвчилсан судалгааг хийнэ.
Дэлхийн монгол Зорилт 1.5. Дэлхий дахинд монгол үндэсний үнэт зүйлсийн дархлаа тогтож, монгол соёлыг түгээн дэлгэрүүлж, гадаад нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлж, хилийн чанад дахь монголчууд, монгол угсаатны хамтын ажиллагаа төлөвшинэ.	Шууд	1.5.1. Монгол хүний бусдаас ялгарах онцлог, давуу талыг “Бүтээлч сэтгэлгээ, оюуны чадвар өндөр, дасан зохицох чадвартай, эрчист Монгол” хэмээн тодорхойлж энэ чанарыг хүн бүрд хэвшүүлж, хүүхдийг бага наснаас нь төлөвшүүлнэ.
		1.5.4. Олон улсын түвшинд зохион байгуулагдаж байгаа олимпиад, уралдаан, тэмцээнд оролцож, амжилт үзүүлсэн суралцагч, багш, багийг дэмжиж урамшуулан алдаршуулна.
	1.5.10. Хилийн чанад дахь монголчууд, монгол угсаатнуудын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, хэл, соёл, уламжлалаа хадгалан хөгжүүлэхэд нь дэмжих чиглэлээр монгол хэл, соёлын сургалт, хөтөлбөрийг бий болгон хэрэгжүүлнэ.	
	Дам	1.5.2. Монгол хүнийг насан туршид нь хөгжүүлэхдээ ураг байх үеэс эхлэн хүний нас, хөгжлийн онцлогт тохирсон эрүүл мэнд, соёл урлаг, боловсролын цогц уялдаатай үйлчилгээ үзүүлнэ.

4.1.2. Боловсролын салбарын урт хугацааны хөгжлийн бодлого

“Алсын хараа 2020-2050” баримт бичгийн хоёрдугаар бүлэг болох “Хүний хөгжил” гэсэн бүлгийн эхний хэсэгт хөгжлийн хоёр дахь эрхэм зорилгын хүрээнд боловсролын салбарын урт хугацааны хөгжлийн бодлого, зорилго, зорилт болон 2050 онд хүрсэн байх үр дүнг тус бүр 10 жилийн хугацаатай 3 үе шаттай байхаар дараах байдлаар тодорхойлжээ. Тухайлбал,

Зорилго 2. Чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалтай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн идэвхтэй, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ. (Файл 1, Sheet 7).

Зорилт 2.1 Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ (*УИХ-ын 2020 оны 52-р тогтоолын 1-р хавсралт*)

Хүрэх үр дүнгүүд: Боловсролын салбарт тодорхойлогдсон дараах хүрэх үр дүнүүдийн шалгуур үзүүлэлтүүд уг баримт бичигт нарийвчлан тодорхойлогдсон бөгөөд тэдгээрийг Файл 1-ийн Sheet 6 ба Sheet 9-өөс тодруулан үзнэ үү.

I шат (2020-2030): Хүн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцооны шинэчлэлийн үе.

1. Салбарын хүрээнд судалгаа, нотолгоонд суурилсан бодлого, хөгжлийн төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх удирдлагын тогтолцоо болон олон талт түншлэл бэхэжсэн байна.
2. Иргэн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлэн, тэгш хамруулж, бүх шатны боловсролын залгамж холбоог хангаж, сургалт, үйл ажиллагааны чанарыг дээшлүүлсэн байна
3. Суралцагчийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг хангасан, бүтээлч, чадварлаг багш, хүний нөөцөөр хангана.
4. Боловсролын салбарын удирдлагын мэдээллийн системийг бүрэн хөгжүүлж, хэрэглэж хэвшсэн байна.
5. Нээлттэй боловсролын тогтолцоог хөгжүүлж, цахим сургалтын нэгдсэн платформ бий болгон хүн бүр орон зай, цаг хугацаанаас үл хамааран өөрийн хүссэн чиглэлээр насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлсэн байна.
6. Олон улсын хөдөлмөрийн зах зээлд хүлээн зөвшөөрөгдөхүйц мэдлэг, ур чадвартай төгсөгчдийг бэлтгэн гаргадаг дээд боловсролын тогтолцоотой болсон байна.

II шат (2030-2040): Чанартай боловсрол олгох, насан туршидаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлэх үе.

1. Бүсийн төв, аймаг, орон нутаг дахь ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, политехник коллеж, технологийн коллеж, их, дээд сургуулиудын үүрэг, оролцоо нэмэгдсэн байна.
2. Бүх насны иргэд, нийгмийн салбар бүрийг хамарсан насан туршийн боловсролын нээлттэй, уян хатан тогтолцоо бэхэжсэн байна.
3. Олон улсын шаардлага хангасан дээд боловсролын сургалтын байгууллагын тоог нэмэгдүүлж, чанарыг дээшлүүлэн олон улсад эрэмбэлэгдсэн, хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөр бүхий үндэсний судалгааны их сургуультай болсон байна
4. Боловсролын засаглал, удирдлагын тогтолцоог тодорхой болгож, тасралтгүй сайжрах хариуцлагын тогтолцоог бүрдүүлсэн байна.

III шат (2040-2050): Насан туршидаа суралцахуйг дэмжсэн нээлттэй боловсролын тогтолцоог бэхжүүлэх үе.

1. Сургалтын уян хатан арга замуудтай, харилцан уялдаа бүхий бусадтай хамтран амьдрах, ажиллах чадавх (үнэт зүйлс, зан үйл, амьдралын хэв маяг) бүхий иргэнийг бэлтгэнэ.
2. Нээлттэй сургалтын хөтөлбөр, агуулгыг баяжуулж, боловсролын бүх шатанд хиймэл оюун ухаанд суурилсан технологийг нэвтрүүлсэн байна.

Дээрх зорилго, зорилтын хүрээнд хөгжлийн эхний үе шат болох 2020-2030 онд товлогдсон 6 үр дүн хүрэхийн тулд нийт 44 үйл ажиллагаа төлөвлөснөөс багшлахуйтай шууд ба дам хамааралтай байж болох нийт 34 үйл ажиллагааг ялган тэмдэглэсэн болно (Файл 1, Sheet 8-аас үзнэ үү).

4.2. “Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-т суурилсан магадлан шинжилгээний үр дүн

Төрийн удирдлага, зохион байгуулалтын тогтолцооны бүх түвшинд холбогдох хууль тогтоомжийн дагуу хагас болон бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гүйцэтгэлийг дүгнэн тайлагнаж, холбогдох арга хэмжээг төлөвлөж байдаг гол баримт бичиг болох “ЗГ-ын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-өөс боловсролын салбартай холбоотой нийт 36 зорилтыг түүж, тэдгээрээс багшлахуйтай шууд ба дам холбоотой 3 зорилтыг ялган агуулгаар 8 хэсэгт төрөлжүүлж, төрөл доторх болон төрөл хоорондын холбоог харгалзан багцлах замаар чанарын анализын үр дүн болох санал, зөвлөмжүүдийн агуулгын ерөнхий хүрээ, бүтцийг тодорхойлсон болно (Хавсралт 2).

Түүнчлэн санал, зөвлөмжийн дээрх ерөнхий хүрээ, бүтцэд нийцүүлэн бусад баримт бичгийг магадлан шинжлэх явцад гаргасан зөвлөмжүүдийг нэмж тусгасан бөгөөд чанарын анализын нийт үр дүнгээс харахад ЗГ-ын 2020-2024 онд үйл ажиллагааны хөтөлбөрийг үр өгөөжтэй, амжилттай хэрэгжүүлэхийн тулд бүх баримт бичигт тодорхойлсон зорилт, үйл ажиллагаа, хүрэх үр дүнгээ доор дурьдсан хэд хэдэн бие даасан хөтөлбөрүүд болгон боловсруулж хэрэгжүүлэх боломж байна. Үүнд:

- “Чадварлаг багш”
- “Боловсролын мэргэжлийн байгууллагуудын кластер суурьтай бүтцийн өөрчлөлт”
- “Боловсролын салбарын цахим шилжилт”
- “ТХБ ба боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр”
- “Чанар, бүтээмжийн гүйцэтгэлийн ахицад суурилсан үнэлгээний тогтолцоо”
- “Боловсрол ба салбар хоорондын түншлэл”
- “Сургуулийн зураглал ба ТХЗ-4” гэх мэт

Энэхүү судалгааны зорилго, зорилтдоо нийцүүлж, судалгааны үр дүнгээ үндэслэн “Чадварлаг багш” хөтөлбөр боловсруулах, түүнчлэн бусад хөтөлбөрийг боловсруулахад багштай холбоотой асуудлуудыг тусгахад тус тус хувь нэмэр оруулахыг зорьж чанарын судалгааны үр дүнгээ “ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулан багшлахуйн кластер шинжилгээнд тулгуурлан боловсруулсан зөвлөмж” хэлбэрээр боловсруулж, тайлангийн энэ дэд бүлэгт танилцуулж байна.

4.2.1. ЗГҮАХ- “Чадварлаг багш” арга хэмжээ

“Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлж, мэргэжлийн стандартыг нэвтрүүлэн, үнэлэмжийг хөдөлмөрийн бүтээмж, гүйцэтгэлд суурилсан тогтолцоонд шилжүүлнэ (ЗГҮАХ: 2.3.8)

"Чадварлаг багш" арга хэмжээ бол нэг талаас, ЗГ-ын түвшинд бол арга хэмжээ, харин боловсролын салбарын түвшинд бол багшийн хөгжлийн гол асуудлуудыг харилцан хамааралд нь шийдвэрлэх боломжтой салбарын түвшний бие даасан хөтөлбөр байж болох юм. Учир нь түүний агуулга нь багшлахуйн кластерийн “Багш бэлтгэх”, “Багшаар ажиллах” гэсэн чухал хоёр үе шатны оролт ба гаралт, тэдгээрийн хоорондох бүхий л үйл ажиллагааны агуулга багтаахад томъёологдсон байна. Мөн багшлахуйн кластерийн бусад үе шат, төлөв байдалд хамаарах зорилт, хүрэх үр дүнгүүд ЗГ-ын арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд тодорхой хэмжээгээр тусгагдсан байгаа тул ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан энэ зорилтыг бусад зорилттой уялдуулах замаар ***“Чадварлаг багш”*** боловсролын салбарын бие даасан хөтөлбөр болгон боловсруулах бүрэн үндэслэл байна.

“Чадварлаг багш” (2.3.8.) арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн бусад зорилтууд болон ЗГАХТ, Мастер төлөвлөгөөнд тусгагдсан зорилтууд, хүрэх үр дүнгүүдтэй нягт уялдуулан авч үзэх шаардлагатай. Тухайлбал,

- Үндэсний түвшний мэргэжлийн байгууллагуудын уялдаа холбоо тухайлбал, Боловсролын хүрээлэнгийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчилж, чадавхийг дээшлүүлэх (2.3.4)
- Багш мэргэжлийн стандарт нэвтрүүлэх (4.2.9)
- Боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрт орох өөрчлөлтүүдтэй уялдуулах (2.3.3, 2.3.4, 2.3.11, 2.3.16, 4.2.7)
- Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд тавигдах шалгууруудыг нарийвчилж, хариуцлагыг өндөржүүлэх (4.2.5)
- Бүтээмж, үр дүнгийн үнэлгээнд суурилсан цалин хөлсний систем нэвтрүүлж, инфляц, бүтээмжтэй уялдуулан цалин хөлсийг үе шаттайгаар нэмэгдүүлэх (4.2.4)
- Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, шимтгэлийн нэрийн дансны үлдэгдлийн тодорхой хувийг гэр бүлд нь өвлүүлэх (2.5.1, 2.5.2, 2.5.5)

- Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн иргэдийг орон сууцжуулах, орон нутагт анх удаа очиж ажиллах багш, эмчийг түр орон байраар хангах арга хэмээг хэрэгжүүлэх (3.7.8, 6.2.12, 2.5.5)
- Эрүүл мэндийн салбартай хамтран ажиллаж, багшийн хангамж, сурагчдын завсардалтын эрсдлээс сэргийлэх (1.1.15)
- Соёл, урлагийн салбартай хамтран ажиллаж, сургууль, багш нарын түншлэлийг хөгжүүлэх (2.6.16)
- Шинэ сургууль, цэцэрлэг барьж, багшийн ачаалал, ажлын орчин нөхцөлийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлсэн сургуулийн байршил, бүтэц, хэмжээ, хэв шинжтэй уялдуулан сайжруулах (2.3.9.2)
- СӨБ-ын тогтолцооны бүтцийг шинэчилж, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн шинэ цэцэрлэгүүд барьж хамран сургалтыг нэмэгдүүлэх, сургуулийн өмнөх ба бага боловсролын залгамж холбоог хангах (2.3.1, 2.3.9.1, 2.3.2)
- Багшлахуйн кластерийн “БК1.Багш бэлтгэх сургуульд элсүүлэх”, “БК2.Багш бэлтгэх”, “БК3.Багшийг ажилд авах”, “БК4.Багшаар ажиллах”, “БК5.тэтгэвэр тогтоож, ажлаас чөлөөлөх” зэрэг үе шат, төлөв байдалд харгалзах ЗГАХТ болон Мастер төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээнүүд (*Файл 2: Sheet2-ийн J67, N67, J68, L68; Sheet11-ийн B13 г.м*)

Уг арга хэмжээг дээрх зорилтуудтай уялдуулж багшлах үйлийн тогтолцоог хувирган өөрчлөхдөө УИХ, ЗГ-аас 2020 онд батлагдсан Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдэд хийсэн бидний энэхүү судалгааны үр дүн болон сүүлийн жилүүдэд боловсролын салбарт хийгдсэн судалгаануудын дүгнэлт, зөвлөмжүүдийг харгалзан үзэх хэрэгтэй. Багшлах үйлийн тогтолцоог хувирган өөрчлөхдөө дараах алхмуудыг хэрэгжүүлж болох юм. Үүнд:

- Энэ зорилтын хэрэгжүүлэхдээ багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжил (БМТХ)-ийг багшлах үйл явцын кластер тогтолцоо байдлаар хөгжүүлэх *бодлого* баримтлах
- Багшлахуйн кластер тогтолцоо (0, 2, 4, 6 гэсэн дэд кластерууд буюу үе шатууд хийгээд тэдгээрийн шилжилтийн 1, 3, ... 5 гэсэн төлөв байдлууд хоорондын Х1.1-Х1.5 ба Х2.1-Х2.5 гэсэн шулуун ба эргэх холбоосууд)-ны судалгааны дүгнэлт, зөвлөмжүүдэд үндэслэн багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн үзэл баримтлал (хөгжлийн бодлого, стратегүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх бүтэц, тогтолцоогоо нарийвчлах үндсэн шийдлүүд)-ыг боловсруулж, түүний дотор "Чадварлаг багш" гэсэн ойлголтоо тодорхойлох
- Улмаар 2020-2024 онд хэрэгжүүлж болох баталгаатай хөрөнгө оруулалт, санхүүжилттэй, багшлах үйлийн хувирган өөрчлөлтийн үндэс суурийг тавих цогц арга хэмжээ бүхий бие даасан *салбарын хөтөлбөр* болгон боловсруулж, баталгаажуулан хэрэгжүүлж эхлэх

Ингэхдээ энэхүү судалгааны ажлын хүрээнд багшлахуйн талаарх бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн холбогдох хэсгүүдэд тодорхойлогдсон зорилт, арга хэмжээ бүрд өгөгдсөн тусгайлсан санал, зөвлөмжүүдийг тусгах боломжтой (Excel файл 2.).

4.2.2. Боловсролын хүрээлэнгийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчилж, чадавхийг дээшлүүлнэ (ЗГҮАХ: 2.3.13)

Энэ зорилт нь зөвхөн "Боловсролын хүрээлэн" гэсэн нэг байгууллагын асуудал биш бөгөөд энэ өөрчлөлтийг хийхдээ боловсролын үндэсний түвшний мэргэжлийн байгууллагуудын чиг үүрэг, үйл ажиллагааг тус тусад нь салангид байдлаар бус харин тэдгээрийг харилцан хамаарал, уялдаа холбоонд нэгдмэл буюу кластер байдлаар авч үзэж хэрэгжүүлэх зорилт гэж ойлгох нь зүйтэй.

Боловсролын бүх түвшин, хэлбэрийн хувьд сургалтын хөтөлбөрийн хөгжлийн динамик тогтолцоо нь боловсролын хөгжлийн хэрэгцээ, суралцахуйн зорилт буюу хүлээгдэж буй үр дүнгүүд, агуулга, арга зүй, үнэлгээний дэд тогтолцоонууд байх бөгөөд сургалтын хөтөлбөр

бүтээх онол арга зүйн болон менежментийн зарчмуудын сонголт, түүний хөгжүүлэлт, хэрэгжилт, хяналт шинжилгээ, үнэлгээ, тэдгээрийн баталгаажилт, гэрчилгээжүүлэлтийн эргэх холбоог хангасан үе шатууд бүхий цикл үйл явц байдаг.

Иймд БХ, БМДИ, БҮТ, НТСҮТ, БМИҮТ, БТС, зэрэг үндэсний түвшний мэргэжлийн байгууллагуудаа кластер байдлаар хөгжүүлэх бодлого баримталж, энхүү кластерийн техник эдийн засгийн нарийвчилсан үндэслэл (ТЭЗҮ)-ийг боловсруулах иж бүрэн судалгаа хийж, судалгаанд үндэслэсэн шийдвэр гарган хэрэгжүүлэх нь зүйтэй.

Багшлахуйн кластерийн “БК4. Багшаар ажиллах” дэд кластерийн тухайд л гэхэд ямар олон асуудал бие биетэйгээ харилцан хамааралтай болохыг тэнд өгөгдсөн тус кластерийн кодын тооноос, тэдгээрийн ард байгаа агуулгаас харагдаж байна (Зураг 3, *Хүснэгт 7*). Хэрвээ бид бие даасан мэргэжлийн байгууллагуудын чиг үүрэг, гол үйл ажиллагааны харилцан хамаарлын уялдаа холбооны механизм, түүний шинж чанарт анхаарал төвлөрүүлэхгүй бол эдгээр байгууллагууд тус тусын салангид үйл ажиллагаанд төвлөрсөн хэвээрээ байх болно. Энэ тохиолдолд боловсролын талаар хичнээн өөдрөг зорилт дэвшүүлж, хичнээн их хөрөнгө зарсан ч үр ашиг, үр өгөөж, чанар, тогтвортой байдал бүрэн хангагдаж чадахгүй.

Асуудлыг тэдгээрийн харилцан хамаарлын уялдаа холбооны механизм, чанарт төвлөрүүлэх энэ санааг Мастер төлөвлөгөөний Sheet 12-ийн D15, C50 дурьдсан хөтөлбөрүүд болон энэ Sheet-ийн J43 нүдэнд өгөгдсөн "Үндэсний зөвлөл" байгуулж ажиллуулах талаар өгсөн зөвлөмжтэй уялдуулж, цогцоор нь авч үзэх замаар хэрэгжүүлэх боломжтой.

ТЭЗҮ-ийн дээрх судалгааг хийх тохиолдолд БМТХ-ийг чиглэлээр мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаа дахь харилцан хамаарлын агуулга, мөн чанарыг илрүүлж, хамтын ажиллагааны талбарыг тогтоох шаардлагатай. Тухайлбал,

Сургалтын хөтөлбөрийн хүлээгдэж буй үр дүнгүүд, багшийн хөгжлийн стандартын шаардлагууд, багшийн ажлын гүйцэтгэл болон суралцагчдын сурлагын амжилтыг үнэлэх шалгуур, индикаторууд болон арга хэлбэр хоорондын нийцлийг тодорхойлж, шаардлагатай тохиолдолд энэ нийцлийг хангах эрх зүйн зохицуулалтууд хийж, мөрдүүлэх шаардлагатай.

БМДИ сургалтын хөтөлбөрүүдийн нэр төрлийг багш бүрийн эрэлт хэрэгцээнд нийцэхээр сонголттой, суралцах арга хэлбэрийг олон хувилбартай болгох, сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлтэй төрийн болон төрийн бус байгууллагуудын бүтээлч оролцоог хангах замаар өнөөгийн дийлэнхидээ нийлүүлэлтэд суурилсан үйлчилгээний менежментээ багш нарын мэргэжлийн насан туршийн суралцахуйн эрэлт хэрэгцээнд суурилсан, нээлттэй үйлчилгээний менежментийг хөгжүүлэх зэрэг болно.

Ийнхүү Боловсролын хүрээлэнгийн бүтэц, зохион байгуулалтыг боловсролын тогтолцооны хувирган өөрчлөлтийн өргөн хүрээнд харж, боловсролын тогтвортой хөгжлийн суурь бүтэц буюу кластер болохынх нь хувьд мэргэжил, арга зүйн бусад байгууллагуудын үйл ажиллагааны үр ашиг, үр өгөөжийг эрс дээшлүүлэх суурь шийдэл хэмээн үзэж, онцгой хүчин чармайлт гарган оюуны, материаллаг, санхүүгийн дорвитой хөрөнгө оруулалт хийх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, боловсролын үндэсний түвшний мэргэжил, арга зүйн байгууллагуудынхаа бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг ТХБ-ын суурь зарчмуудыг бодит үйл хэрэг болгох боломж олгодог сектор бүхлээрээ ажиллах арга хандлага; асуудлыг тогтолцоонд нь харж, танин мэдэх сэтгэлгээний арга барил; зөвшилцөж, ойлголцож байж шийдвэр гаргах ёс зүйд суралцсанаар хэрэгжүүлэх боломжтой. Үүнийг монгол ардын зүйр цэцэн үгүүд ч баталдаг. Жишээлбэл, "Дээдэх нь хөлөө олохгүй бол доодох нь суудлаа олохгүй", мөн "Дуугарвал дуу нэг, дугтарвал хүч нэг", бас "Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй" гэдгийг бид үргэлж санаж явах хэрэгтэй..

Боловсролын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт хийсэн багшлахуйн кластер шинжилгээний үр дүнгээс харахад "БК4.Багшаар ажиллах" үе шатны дэд шалгуур, индикаторуудаар бүртгэгдэж тодорхойлогдсон агуулгын илэрц нь нийт илэрцийн 80 гаруй

хувийг (Зураг 3) эзлэж байгаа тул "Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлэхэд БХ, БМДИ, БҮТ-д энэ үе шатны ажлын гол хариуцлага, ачаалал ногдож байгааг гэрчилж байна. Иймээс зөвхөн "Чадварлаг багш" төдийгүй бусад дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд боловсролын чанарын баталгааны "амин холбоо"-г хангах түвшинд мэргэжлийн байгууллагуудын чиг үүрэг, үйл ажиллагааг уялдуулж, энэ "амин холбоо"-нд суурилсан үндэсний түвшний кластерийг үүсгэж, үндэсний түвшний боловсролын мэргэжлийн удирдлагын бүтэц, зохион байгуулалтыг хувирган өөрчлөх хэрэгцээ бол байна аа.

4.2.3. СӨБ, БДБ, багш бэлтгэх боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрүүд (ЗГҮАХ: 2.3.4, 4.2.9, 2.3.16, 2.3.11, 2.5.4)

- *Монголын түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, шударга ёсны үзэл, хандлага болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн агуулгаар баяжуулсан монгол хүний хүмүүжлийг дээдэлсэн, монгол хүний онцлогт тохирсон зан чанар, хүмүүжил, сургалтын хөтөлбөрийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр цэцэрлэг, сургуульд хэрэгжүүлнэ (ЗГҮАХ 2.3.4).*
- *Олон улсад өрсөлдөх чадвартай боловсролын хөтөлбөрийг бий болгох эрх зүйн шинэтгэл хийж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ (ЗГҮАХ 2.3.16).*
- *Үндэсний стандартуудыг олон улсын түвшинд нийцүүлж шинэчилнэ (ЗГҮАХ: 4.2.9).*

А. СӨБ, БДБ-ын стандартууд

Үндэсний стандартуудыг олон улсын түвшинд нийцүүлж шинэчилнэ (ЗГҮАХ: 4.2.9)

Боловсролын стандартуудыг боловсролын нэг бие даасан кластер болгон авч үзэж, тэдгээрийн хоорондох зохицол, нийцлийг хангахад онцгой анхаарах шаардлагатай. СӨБ болон БДБ-ын сургалтын хөтөлбөрийн менежментийн циклийн хүрээнд дараах стандартуудыг цогцоор нь шинэчлэн сайжруулах хэрэгтэй. Үүнд:

- СӨБ-ын үйл ажиллагааны хөтөлбөр, БДБ-ын стандарт, сургалтын хөтөлбөр, асуудлыг боловсролын тухай багш хуулийн өөрчлөлтөөр нэг мөр ойлгомжтой болгож шийдвэрлэх
- Боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх үзэл баримтлал, үйлийн бүтэцчилсэн хүрээг шинэчлэн сайжруулах
- Батлагдсан хуулийн заалт, үзэл баримтлалд нийцүүлэн өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй стандартуудад тэдгээрийг кластер байдлаар хөгжүүлэх өнцөгөөс иж бүрэн судалгаа хийж, дараах стандартуудыг шинэчлэх. Тухайлбал,
- СӨБ, Бага дунд боловсролын стандартыг шинэчлэн батлуулж мөрдөх (хэрэв хуулиар боловсролын стандартыг сургалтын хөтөлбөрөөр төлөөлүүлэх тохиолдолд сургалтын хөтөлбөрийн зорилт ба хүлээгдэж буй үр дүнгийн хэсгийг анги бүрийн бус боловсролын түвшингүүдээр ялган тодорхойлох)
- Батлагдсан стандарт (сургалтын хөтөлбөр)-т нийцүүлэн сурагчийн хэвлэмэл болон цахим сурах бичгийн стандартуудыг шинэчлэх
- Батлагдсан стандарт (сургалтын хөтөлбөр)-т нийцүүлэн сурагчийн сурлагын амжилтыг үнэлэх шалгуур, индикаторууд болон гүйцэтгэлийн даалгавруудыг үнэлэн сайжруулах
- Батлагдсан стандарт (сургалтын хөтөлбөр)-т нийцүүлэн "Багш" мэргэжилтний стандартыг шинэчлэн сайжруулах
- Багшийн мэргэжлийн ур чадварыг үнэлэх шалгуур, индикаторуудыг үнэлж сайжруулах
- Багшийн ажлын норм, нормативуудыг үнэлэн сайжруулах
- Сургууль (цэцэрлэг, үндэсний болон орон нутгийн түвшний мэргэжлийн агентлагууд) бүхлээрээ ажиллах арга хандлага-СБААХ (Whole school approach-

WSA)-ыг сургалтын болон холбогдох байгууллагын менежментэд нэвтрүүлж буй ШХА-ийн "ТХБ-II" төслийн үр дүнг тооцож, үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх замаар боловсролын болон сургалтын байгууллагуудын хөгжлийн тогтвортой байдлыг хангах зэрэг болно.

Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага” MNS 2008:5418 стандарт, холбогдох журмыг шинэчлэн баталсан байна. I-XII ангийн сурах бичигт сайжруулалт хийж, хэвлэгдсэн байх талаар (Файл 2: Sheet2-ийн J45)

ЗГ-ын 2020-2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд одоо байгаа сурах бичгүүдийг **шинэчлэн хэвлэх** ямар үндэслэл, шаардлага байгааг сайн ойлгохгүй байна. Ойрын 2-3 жилд сурах бичгийг дахин хэвлэж, элэгдэл, хорогдлыг нөхөх нь ойлгомжтой. Харин шинэчлэн боловсруулах ажил нь сургалтын хөтөлбөрийн шинэчлэлтэй зэрэгцэн эхлэх нь илүү оновчтой.

Цаашид салан баавгайн үлгэр шиг хэт үрэлгэн, чанарын менежментгүй явж болохгүй. Харин үүнээс өмнө сурах бичгийн салбарт дараах 2 суурь судалгааг заавал хийх хэрэгтэй байна. Үүнд:

1. 2004 батлагдан мөрдөгдсөн цогц чадамжид суурилсан бага, дунд боловсролын стандартын дагуу сурах бичгийн хөгжлийн шинэ үе шат эхэлсэн *2005 оноос эхлэн өнөөг хүртэлх хугацаанд зохиогдсон бүх сурах бичгүүдийг хичээл бүрээр нь судалж, сурах бичгүүд хэрхэн өөрчлөгдөж ирсэн ямар, алдаа дутагдал, ололт амжилт байгаагаа илрүүлэх баримт бичгийн томоохон суурь судалгааг* хийх явдал нь сурах бичиг хангамжийн талаар баримтлах бодлого, сурах бичгийн хөгжлийн үзэл баримтлал, стандартыг боловсруулах нотолгоот үндэслэл болно.

Сургалтын хөтөлбөрийг сайжруулах шинэ үзэл баримтлал, түүнд нийцсэн сургалтын хөтөлбөрүүд боловсрогдож, туршихтай зэрэгцээд шинэ сурах бичгийн эхүүд бэлтгэгдэж, хэлэлцэгдэж, туршигдаж, сайжруулагдаж байгаад шинэ хөтөлбөртэй хамт шинэ сурах бичгүүд хэвлэгдвэл илүү тустай.

Өнгөрсөн хугацаанд нэг жилд хэд хэдэн ангийн олон сурах бичгийг зохиож бичихэд ямар хүндрэл, сөрөг талууд гардаг талаар хангалттай сургамж авсан шүү дээ. Тухайлбал, сурах бичиг бичих, хэвлэх нь хэт богино хугацаатай байх нь алдаа мадаг гарах, оруулж буй өөрчлөлтийг мэргэжлийн нийгэмлэгүүд хэлэлцэж, нэгдсэн шийдэлд хүрэх боломжгүй зохиогч хэдхэн хүний үзэмжээр шийдэгдэж, зарим тохиолдолд багш, сурагчдад бодит бэрхшээлүүд үүсгэж зарим тохиолдолд чанарын шаардлага хангахгүй сурах бичгүүд гарч, “Бушуу туулай борвиндоо...” гэгчийн үлгэр болдог байсан.

ЗГ-ын арга хэмжээний төлөвлөгөөний төслөөс харахад сурагчийн сурах бичгээс гадна багшийн ном цаашид хийгдэх эсэх нь тодорхойгүй байна. Мөн цаашид сурах бичгийг цахимжуулах, түүнийг хэрэглэхтэй холбоотой технологийн болон эрх зүйн олон асуудлууд шийдлээ хүлээж байна.

2. Мөн 1990 оноос хойш *сурах бичиг хангамжийн талаар баримталж ирсэн бодлого, холбогдох журмуудад хийгдсэн шийдлүүд, тэдгээрийн үр дагаврыг үнэлэх суурь судалгааг* хийж, бодлогын болон эрх зүйн орчноо сайжруулах зайлшгүй хэрэгцээ байгааг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Учир нь сурах бичгийн хангамжийн тогтолцоо гэдэг хичээл бүрээр сурах бичигтэй байх уу? нэг сурах бичгийг хэдэн хүүхэд хэрэглэх вэ гэдгээс эхлээд, тэдгээрийн төрөл, тоо хэмжээ, боловсруулах, магадлан шинжлэх, хэвлэх, түгээх зэргийг хамарсан гинжин хэлхээт тасралтгүй үйл явц байдаг. Хэрэв бид түүнийг кластер байдлаар хөгжүүлнэ гэж үзвэл, бодлогодоо зарчмын өөрчлөлт оруулах шаардлага гарна. Өөрөөр хэлбэл, олон улсын нийтлэг жишгийн дагуу хэвлэлийн газар төвтэй сурах бичиг хангамжийн тогтолцоо байх уу? эсвэл одоогийнхоороо төрийн зохицуулалттай тогтолцоо байх уу гэх мэт.

Цаашид сурах бичгийг захиалагч тал нь түүнийг зохиох, магадлан шинжлэхэд тавигдах шаардлагыг сургалтын хөтөлбөр, багшлахуй, хэрэглэгдэхүүн ба орчин, үнэлгээ гэсэн системийн том кластерийн цар хүрээнд харж, "чанар шаардсан маш сайн ажлын даалгавар" боловсруулж гүйцэтгүүлдэг болоход онцгой анхаарах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээг захиалагч тал нь ерөнхий чиг өгчихөөд хийсэн зүйлийг нь хүлээж авдаг практикаас татгалзах нь зүйтэй. Энэ нь зөвхөн сурах бичиг төдийгүй, ямар ч захиалгат ажлын чанарт сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийн нэг байж болох талтай.

Б. СӨБ, БДБ-ын сургалтын хөтөлбөрүүд

Монголын түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, шударга ёсны үзэл, хандлага болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн агуулгаар баяжуулсан монгол хүний хүмүүжлийг дээдэлсэн, монгол хүний онцлогт тохирсон зан чанар, хүмүүжил, сургалтын хөтөлбөрийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр цэцэрлэг, сургуульд хэрэгжүүлнэ. (ЗГҮАХ 2.3.4)

СӨБ болон БДБ-ын сургалтын хөтөлбөрт шинжилгээ хийж, үзэл баримтлал боловсруулан түүнийг сургалтын хөтөлбөрт тусган туршиж, олон нийт, сургууль, багш нар т үе шаттайгаар хэлэлцүүлж, сайжруулсан байх талаар

Энэ зорилтыг хэрэгжүүлэхдээ энэ төлөвлөгөөний зорилт 4 (Монголын түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, шударга ёсны үзэл, хандлага болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн агуулгаар баяжуулсан монгол хүний онцлогт тохирсон зан чанар, хүмүүжлийг дээдлэх)-т тавигдсан шаардлагууд болон дээрх код бүхий агуулгад тавигдах үндсэн шалгуур болгож, сургалтын хөтөлбөрийн менежментийн циклийн төлөвлөлттэй уялдуулан сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөрт шинжилгээ хийж, сургалтын хөтөлбөрийн тогтолцоо суралцахуйн хэрэгцээ, зорилт, агуулга, арга зүй, орчин, үнэлгээ)-г шинэчлэн сайжруулах цогц суурь шийдлүүдийг тодорхойлсон үзэл баримтлалыг боловсруулахад анхаарах хэрэгтэй.

Засгийн Газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд тусгасан БДБ-ын сургалтын хөтөлбөрийг бага, суурь, бүрэн дунд боловсролын шатлалаар нь цаг хугацааны хувьд цувуулж хийх төлөвлөлтийн саналыг судлаачийн хувьд дэмжихгүй байгаа ба энэ талаар өөр байр суурьтай байна.

Учир нь сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж хэлэлцэх, туршин сайжруулах, баталгаажуулан нийтээр мөрдөх цикл үйлийн цаг хугацааны төлөвлөлтийг боловсролын шатлал, түвшингээр нь дэс дараалан цувуулж хийхээс илүүтэйгээр нэгэн зэрэг бүх шатлал, түвшнээ бүхэлд хамарч, харин цикл үйлийн үе шатуудаа дэс дараатайгаар цувуулж хийх нь багш нараа сурган бэлтгэх, сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийг шинээр бүрдүүлэх зэрэг бэлтгэл ажлууд тавиу хугацаанд хангагдахын зэрэгцээ хамгийн гол нь түвшин хоорондын залгамж холбоог хангахын тулд боловсруулах, турших явцдаа тохируулга, сайжруулалт хийх давуу талыг олгодог.

Хэрэв богино хугацаанд нэг шатлалын сургалтын хөтөлбөрийг нийтээр хэрэгжүүлээд эхэлсэн бол, түүнийг бусад, шатлал, түвшингийн боловсруулалт хийх явцад тохиргоо хийж, сайжруулах боломжгүй болдог. Ийм туршлагаас бид сургамж авсан баймаар юм.

"Сургалтын хөтөлбөрийн менежмент, төлөвлөлтийг зохион байгуулах "Үндэсний зөвлөл" байгуулсан байна. Сургуулийн өмнөх болон бага, суурь боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулгыг Монгол хүүхдийг төлөвшүүлэхэд, бүрэн дунд болон багш бэлтгэдэг их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийг Дэлхийд өрсөлдөхүйц Монгол хүнийг бэлтгэхэд чиглүүлэн сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг боловсруулж, олон нийтэд үе шаттайгаар хэлэлцүүлсэн байна." гэсэн зорилтын талаар.

Сургалтын хөтөлбөрийг сайжруулан боловсруулах, түүний хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ болон тэдгээрийн менежмент, төлөвлөлтөд сонирхогч талууд, хувь нийлүүлэгчдийн

бүтээлч оролцоо, түншлэлийг хангах "Үндэсний зөвлөл"-ийг байгуулж ажиллуулах нь боловсролыг улс төрийн болон бусад нөлөөллөөс хамаарсан үндэслэл, нотолгоо муутай шийдвэр гаргаж, салбарын үйл ажиллагааг доголдуулж болзошгүй эрсдэлээс хамгаалахад тустай юм.

Хамтын шийдвэр гаргах энэ бүтэц, механизм, түүний эрх үүргийг хууль, тогтоомжоор баталгаажуулах нь зүйтэй. Энэ бүтэц, механизмыг боловсролын салбарын үндэсний түвшний мэргэжлийн байгууллагуудын кластерийн механизмыг ажиллуулахад ч ашиглаж болох юм.

Түүнчлэн сургалтын хөтөлбөрийн шинэ үзэл баримтлалыг боловсруулах, түүний дагуу сургалтын хөтөлбөрүүдийг шинэчлэн сайжруулахдаа "Алсын хараа-2050: Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого" баримт бичигт тодорхойлсон 9 эрхэм зорилгын эхний 2 эрхэм зорилго болох "Үндэсний нэгдмэл үнэт зүйл", "Хүний хөгжил" гэсэн эрхэм зорилгыг үргэлж хараандаа байлгаж байх нь чухал юм.

Энэ зорилтыг хэрэгжүүлэхдээ энэ төлөвлөгөөний зорилт 4 (Монголын түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, шударга ёсны үзэл, хандлага болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн агуулгаар баяжуулсан монгол хүний онцлогт тохирсон зан чанар, хүмүүжлийг дээдлэх)-т тавигдсан шаардлагууд болон дээрх код бүхий агуулгад тавигдах үндсэн шалгуур болгож, сургалтын хөтөлбөрийн менежментийн циклийн төлөвлөлттэй уялдуулан сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөрт шинжилгээ хийж, сургалтын хөтөлбөрийн тогтолцоо суралцахуйн хэрэгцээ, зорилт, агуулга, арга зүй, орчин, үнэлгээ)-г шинэчлэн сайжруулах цогц суурь шийдлүүдийг тодорхойлсон үзэл баримтлалыг боловсруулахад анхаарах хэрэгтэй байна.

Энэ зорилтод тодорхойлогдсон агуулга бүхий сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх мэдлэг, чадвар, цогц чадамжтай багш бэлтгэх, ажилд авах, багшлах хугацааны тасралтгүй хөгжлийг дэмжих кластерууд хоорондын уялдааг хангах цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар.

Энэ зорилтыг соёл, шинжлэх ухааны салбарын зорилт, үйл ажиллагаатай уялдуулж, салбарын дунд хугацааны төлөвлөгөөнд нарийвчлан задалж, хүрэх үр дүнгүүдийг харилцан уялдаа холбоотойгоор, хэмжиж, бодитоор хэрэгжүүлж болохоор тодорхой томъёолж, бие даасан төсөл, хөтөлбөрүүд хэлбэрээр багшлахуйн кластерийн дээрх код бүхий агуулгын хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатай.

Ингэхдээ энэхүү судалгааны ажлын хүрээнд багшлахуйн талаарх бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн холбогдох хэсгүүдэд тодорхойлогдсон зорилт, арга хэмжээ бүрд өгөгдсөн санал, зөвлөмжүүдийг тусгах боломжтой.

Сургалтын хөтөлбөрийн агуулгыг эх оронч сэтгэлгээ, монгол уламжлал соёлыг дээдэлсэн, хүмүүжил, төлөвшил, хувь хүний болон шинжлэх ухааны эрэл хайгуул хийх ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр залгамж холбоотойгоор шинэчилж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй нийцүүлэн сайжруулах энэ зорилтын дагуу сургалтын хөтөлбөрийн менежментийн циклийн хүрээнд багшийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх цогц арга хэмжээ авч, тэдний ажлын гүйцэтгэл ба болон ур чадварын өсөлтийг үнэлэх шалгуур үзүүлэлт, арга аргачлал тухайлбал, сургалтын байгууллага, багш, сурагчийн үнэлгээний нийцлийг хангах нь чухал байна.

Мастер төлөвлөгөөнд тусгагдсан "Хөтөлбөр 1.1.1: Бүх түвшний сургалтын хөтөлбөр, үнэлгээний нийцийг сайжруулах" нь бие даасан хөтөлбөр байж болохоор томъёологдсон боловч түүнийг үйл ажиллагаанууд болгон задалсан байдал нь оновчтой бус байна. Учир нь нийцийг зөвхөн агуулгад орж буй өөрчлөлтөөс гадна бусад олон хүчин зүйлсийг нөлөөллийг тооцож байж сайжруулах ёстой.

Нэгэнт энэ төлөвлөгөө батлагдсан учир цаашид энэ зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар баримтлах бодлого, стратегийг тодруулан ойлгож, тэдгээрийг жил бүрийн төлөвлөгөөгөөр нарийвчлахдаа дараах баримт бичгүүдэд багшлахуйн кластерийн бүтэц, агуулгыг шалгуур болгон ашиглаж, өгсөн зөвлөмжүүдийг харгалан үзэх боломжтой.

Үндэсний цөөнхөд зориулсан монгол хэл, эх хэлний сургалтын хөтөлбөрийг боловсруулсан байх. Хос хэлний боловсролын багш бэлтгэх, чадавхжуулах, тэдэнд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлсэн байх талаар.

“Алсын хараа-2050” монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 1.3.5-д “Нутгийн хэл, соёл, аман аялгууг хадгалах, хамгаалах чиглэлд бүтээлч хөтөлбөрүүд хэрэгжүүлж монгол хэл, бичгийг гадаад, дотоодод түгээн дэлгэрүүлж байгаа байгууллага, багш, суралцагчдыг урамшуулж дэмжинэ” хэмээн заасан байна. Иймээс аймгийн БСГ-ууд болон орон нутгийн сургууль, багш нар нутгийн хэл, соёл, аман аялгууны талаар мэргэжлийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр судалгаа явуулж, тэдгээрийн хадгалах, хамгаалах сонирхогч бүх талуудын оролцоо, дэмжлэгтэйгээр дунд хугацааны төлөвлөгөөтэй ажиллавал зохилтой санагдаж байна.

Энд хос хэлээр суралцах зорилгод бүлгүүдийн хэрэгцээг судлан тогтоож, ердийн сургууль, төрөлжсөн сургууль, гэр бүлд зориулсан гэх мэт сургалтын төрлүүдээ ялгаж байгаад зорилтот бүлгүүдийн нас насны бүлэгт тохирсон сургалтын хөтөлбөрүүд боловсруулах, турших, улмаар тэдгээр сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэдэн багшийг ямар арга замаар хэрхэн бэлтгэж, үр дүнг нь тооцох зэргийг нарийвчлах хэрэгтэй.

Мөн хэрэгцээгээ тодорхойлсны дараа хөтөлбөр, хүний нөөц, сургалтын хэрэглэгдэхүүнээ цаг хугацааны хувьд цувуулж бус харин нэгэн зэрэг багцаар нь эхлүүлж, үйл ажиллагааныхаа үе шатуудыг цаг хугацааны хувьд цувуулж, аймаг/нийслэлийн Боловсролын газар, сум орон нутагтай хамтран хэрэгжүүлэх замаар бүх үйл ажиллагааг төрийн санхүүжилт, мэргэжлийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр орон нутагт төвлөрүүлэн институтчилах нь илүү оновчтой шийдэл болох байх.

Хэсэг хэсгээр нь богино хугацаанд хийсэн үйл ажиллагаанууд хоорондоо уялдаагүй болж, үр ашиг, үр өгөөж нь сулрах эрсдэлтэйн зэрэгцээ энэ зорилтыг нэг удаагийн арга хэмжээ болгож болохгүй тасралтгүй авч явах бодлогын түвшинд авч явах нь чухал юм.

Эх хэлний сургалтын чанарыг дээшлүүлж, монгол бичгийн сургалт, судалгаа, хэрэглээний орчныг сайжруулах талаар (Алсын хараа 2020-2050: Sheet3-ийн D4, D5; Sheet4-ийн E4, E5, E7, E13; МУ 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн ҮЧ: Sheet3-ийн C20, C21)

Алсын хараа-2050-ийн 2020-2030 онд хэрэгжих эхний үе шатанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны "Зорилт 1.3. Монгол хэл, бичгээ үндэсний үнэт зүйлийн бүрдэл болгон иргэн бүр чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшинэ" гэсэн зорилтын "1.3.2. Монгол хэл, бичгийг нийтийн болон албан хэргийн түвшинд зөв хэрэглэж хэвшүүлнэ" ба "1.3.10. “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ыг хэрэгжүүлнэ" гэсэн үйл ажиллагаа болон улмаар 2041-2050 он гэхэд "Иргэдийн монгол хэл, бичгийн боловсролыг төгөлдөржүүлж, нэгдмэл үнэт зүйл болгон төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ" гэсэн алсын харааны хүрээнд бэлтгэгдэж байгаа болон ажиллаж байгаа бүх багшийн монгол бичгийн чадварыг дээшлүүлэх нь боловсролын салбарын тулгамдсан зорилтын нэг болоод байна.

Иймд энэ алсын хараа, 2021-2030 оны эхний үе шатны урт хугацааны зорилт, үйл ажиллагаа болон Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн хэрэгжүүлэх дунд хугацааны үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төрийн албан хаагч болохынхоо хувьд үеийн бүх багш нарт монгол бичгийн төгс сайн чадвар эзэмшүүлэх зорилт нь бүх шатны албан болон албан бус сургалтаар дамжуулан нийт иргэдийг нэгдмэл үнэт зүйлтэй болтол нь сургах явдал боловсролын салбарын өмнө тулгарч буй томоохон сорилт болж байна.

Сонсох, ярих, унших, бичих чадвар нь аль ч хэлний суурь чадварууд болохынхоо хувьд Монгол бичгийн боловсролд мөн ижил тавигдах бөгөөд багш нарыг энэ 4 чадварт богино хугацаанд тэгш, төгс суралцуулах тусгайлсан бодлого, хөрөнгө оруулалт бүхий бие даасан дэд хөтөлбөрүүдийг залгамж холбоотойгоор хэрэгжүүлэх нь оновчтой байх болов уу? Эхний дэд хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлээд эхлэх боломж бий юу?

Энэ асуудлыг сурах бичиг, сургалтын бусад хэрэглэгдэхүүн, орчинтой нь нэгдмэл байдлаар авч үзэх хэрэгтэй. Ийм хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж чадвал, Монголчуудын бахархал төдийгүй, тусгаар тогтнол, аюулгүй байдлаа хангаж, сэргэн мандалтын үндэс сууриа тавьж байгаа орчин үеийн шилдэг туршлагын нэг болно.

Олон улсад өрсөлдөх чадвартай боловсролын хөтөлбөрийг бий болгох эрх зүйн шинэтгэл хийж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ. (ЗГҮАХ 2.3.16)

Энэ зорилт боловсролын бүх түвшинд хамаарах эсэх нь тодорхой бус томъёологджээ. Гэвч өнөөдөр нийгэмд анхаарал татаад байгаа "Кембрижийн хөтөлбөр" буюу БДБ-ын түвшинд илүү хамаарна гэдэг утгаар дараах санал, зөвлөмжийг өглөө.

Монгол тусгаар тогтносон, бие даасан улс байхын нэг гол баталгаа болох оюун сэтгэлгээний тусгаар тогтнолын баталгааг хангах явдал нь боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийн талаарх үзэл баримтлал, түүний хэрэгжилтээр тодорхойлогдоно.

Энэ үзэл баримтлалын нэг гол чиглэл нь олон улсад өрсөлдөхүйц байх асуудал. Харин энэ асуудлаа шийдвэрлэхдээ "гадны бэлэн хөтөлбөр нутагшуулах" аргаар хийж, бусадтай өрсөлдөх үү? эсвэл, "өөрсдөө сэргэг соргог, ухаалгаар хичээн зүтгэж байж өөрсдийн хөтөлбөрөө бүтээх" замаар олон улсад өрсөлдөх үү? гэдэг арга замын сонголтын өмнө бид ирээд байна. Бидэнд ийм сонголт, тулгалтыг даван туулж ирсэн чамлахааргүй туршлага бий.

Хувь судлаачийн хувьд бол "өөрсдөө бүтээж, бусдаар хүлээн зөвшөөрүүлэх" гэсэн байр суурь дээр байдаг. Учир нь бидэнд өнөөдрийн "өндөрлөг"-өөс харахад энэ замыг сонгож хэрэгжүүлэх нөөц боломж бий.

Монгол улсад 1990-ээд оноос эхэлсэн боловсролын өөрчлөлт нь эрин үеийн бодит нийгэм-түүхэн нөхцлийн хэрэгцээ шаардлагад үндэслэгдсэн, боловсролын бүх төвшин, бүрэлдэхүүн хэсгийг хамарсан, цогц шинжтэй, бүхэл бүтэн тогтолцооны шинэчлэл байсан бөгөөд өнөөдөр ч энэ үйл явц гүнзгийрсээр байна. Боловсролын хөгжлийг хангах гарааны суурь шийдлүүд нь бүх төвшний боловсролын үндэсний стандарт ба киррикулимыг хөгжүүлэх үзэл баримтлалд тусгалаа олсон байдаг.

Байгуулагдаад 10-аад жил болж байгаа "Кембрижийн хөтөлбөр"-өөр хичээллэдэг төрийн өмчит 3 сургуулийн хамт олон өнгөрсөн хугацаанд багагүй туршлага хуримтлуулж, бага, дунд боловсролын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж байгааг үгүйсгэх аргагүй бөгөөд харин цаашид эндээс ямар шинэ үр соёлоуулж, Монголын бага дунд боловсролын сургалтын үндэсний хөтөлбөрийн хөгжилд хувь нэмэр оруулах тал дээр тодорхой бодлоготой ажиллах шаардлага байна. Энэ чиглэлд БШУЯ ч үүсгэн байгуулагчийнхаа хувьд санаачлагатай ажиллах хэрэгтэй болов уу.

Монголд үйл ажиллагаа явуулж байгаа хувийн болон олон улсын хамтарсан сургуулиудад боловсролын чанар, өрсөлдөх чадварын төлөө сургалтын онцлог хөтөлбөрүүд, дэвшилтэд технологи, сургалтын байгууллагын өвөрмөц менежментүүд туршигдан боловсорч, Монголын ЕБС-ийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулж, бага, дунд боловсролыг шинэ өнгө төрхөөр "солонгоруулж" байна.

Төрийн өмчийн сургуулиуд маань яамны бодлого, стратегийн дэмжлэгтэйгээр цогц чадамжид суурилсан боловсролын стандартууд, тэдгээрт нийцсэн сургалтын үндэсний ба цөм хөтөлбөрүүдийг богино хугацаанд маш их ачаалал авч хэрэгжүүлэхийн төлөө хичээж

байна. Түүнчлэн сургуулийн менежмент, сургалтын үйл ажиллагаандаа олон улсын сайн туршлага, инновацийг туршин нэвтрүүлж байна.

Иймээс цаашид ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт харьцангуй оновчтой тодорхойлогдсон энэ зорилтыг "өөрсдөө бүтээж, бусдаар хүлээн зөвшөөрүүлэх" гэсэн стратегитэйгээр авч явж, сурталчилан таниулж, Боловсролын хүрээлэн болон бусад мэргэжлийн байгууллагуудаа кластер загвараар хөгжүүлэх бодлого баримталж ажиллахыг энэ салбарт хөгжлийн бодлого, стратеги, хэрэгжилтийн зохицуулалт, судалгааны чиглэлээр 40 гаруй жил ажилласан ахмад хүний хувьд хичээнгүйлэн хүсч байна.

ЕБС-ийн төсвийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, бодлогын хэрэгжилтийн үр дүнг сайжруулах чиглэлээр сургуулийн бүтэц, хэв шинжийн зураглалыг орон нутгийн хүн амын өсөлт, эдийн засаг хөгжлийн тэргүүлэх чиглэл, бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулж, төрөлжсөн ахлах сургуулийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлсэн байна (МТ: Файл 2, Sheet 11-ийн С26).

Мастер төлөвлөгөөнд тусгагдсан энэ зорилт нь зөвхөн ахлах сургуульд илүү төвлөрсөн байна. Гэтэл бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурласан сургуулийн зураглал (school mapping) нь БДБ-ын хөгжлийг тодорхойлдог суурь хүчин зүйл болж, бүх асуудлыг шийдвэрлэх үндэслэл болдогийг тооцож, бусад зорилтуудаа түүнд нийцүүлэн харилцан уялдаатайгаар тодорхойлох шаардлагатай байдаг. Иймээс өнөөгийн сургуулийн зураглал нь БДБ-д үүссэн олон асуудлын үндсэн ***далд шалтгааны*** нэг болж байгаа учраас "Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хүссэн ч, эс хүссэн ч сургуулийн зураглалын шинэчлэлтэй нягт холбон авч үзэх тохиолдолд ил харагдах "үзэгдэл" хэлбэрээр илэрч байгаа харилцан бие биеэсээ хамаарсан олон асуудлыг цогцоороо шийдвэрлэх суурь нөхцөл бүрдэнэ. Тухайлбал,

- Сургуулийн хэмжээ, бүтэц, хэв шинж, байршилд нийцүүлэн мөн хүүхэд бүрийн чанартай боловсролыг аюулгүй орчинд эзэмших эрх, жендэрийн мэдрэмж, тэгш байдлыг хангах түвшинд цэцэрлэг, сургуулийн хичээлийн болон дотуур байр, бусад байгууламжууд, дэд бүтцийн зураг төслийн хувилбаруудыг боловсруулж, баталгаажуулан мөрдөх
- Сургуулийн шинэ зураглалд үндэслэн аль төрлийн сургуульд ямар мэргэжлийн хэдэн багш хэрэгтэйг тооцоолох
- Багшийг хувийн болон төрийн өмчийн тохилог орон сууцаар хангах олон хувилбар боломжуудыг бий болгох
- Хөдөөгийн сургуулиудад байгаа мэргэжлийн багшийн далд дутагдлыг арилгах
- Багшийн ажлын норм, нормативийг мөрдүүлж, ажлын ачааллыг жигдлэх
- Багш нарыг орон нутагт сэлгэн ажиллуулж, бүтээлч туршлагуудыг судлах, түгээн дэлгэрүүлэх, харилцан суралцах
- Хичээлийн судалгааг бүтээлчээр явуулж, багш нар ажлын байрандаа мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломж нэмэгдэх
- Ахлах ангийн суралцагчдын сонгон суралцах боломжийг нэмэгдүүлэх
- Хөдөөгийн сургуулиудад чадварлаг багш нар тогтвортой ажиллах
- Сургуулиудын хэмжээ, хэв шинжид нийцүүлэн суралцахуй ба багшлахуйг дэмжих сургуулийн болон сургалтын орчин, дэд бүтцэд оруулах хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх
- Сургалт, үйл ажиллагааны чанар дээшлэх
- Сурагчдын сурлагын амжилт дахь хот, хөдөөгийн сурагчдын гүйцэтгэлийн ялгаа багасах зэрэг асуудлууд шийдвэрлэгдэх боломжтой.

Ахлах ангийн сургалтад багц цаг (кредит)-ийн систем нэвтрүүлэх, харилцан хүлээн зөвшөөрөх зохицуулалтыг бий болгох талаар (ЗГАХТ: Файл 2, Sheet 2-ийн Е40).

Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд тусгагдсан энэ зорилтыг хувь судлаачийн хувьд энд томъёолсон байдлаар нь огт зөвшөөрөх боломжгүй гэж үзэж байна.

Учир нь бүрэн дунд болон дээд боловсролын түвшин хоорондын залгамж холбоог ийм байдлаар хангах нь бага, дунд боловсролын бие даасан дэд түвшингийн кластерийн бүх бүрэлдэхүүн хэсгүүд болон холбогдох эрх зүйн зохицуулалт, тэдгээрийн мөрдөлтөд олон хүндрэлтэй асуудлыг үүсгэх сөрөг үр дагавартай юм. Тухайлбал, багшийн ажлын норм, нормативыг тогтоох үндэслэл, хэмжих нэгж олон төрөл хувилбартай болж салаалснаар багш хангамжийн асуудлууд, жишээ нь төлөвлөлт, санхүүжилт, бүртгэл тооцоо, хэрэгжилтэд тодорхой бодит бэрхшээлүүд үүснэ. Мөн хөдөөд ахлах сургууль хөгжих боломж хязгаарлагдаж, улмаар тэнд ажиллах нэг мэргэжлийн багш нарын дунд хүссэн ч хүсээгүй ч ялгаатай хандлагууд үүсч багшид хамаарах equity ба inclusion-д асуудлууд үүснэ. Улмаар Дэлхийд ялгарахын ганц давуу тал, үндэслэл болсон *нүүдлийн ахуй амьдралд нийцсэн боловсролын үйлчилгээ, тогтолцоог бүрдүүлэх нь бидний эрхэм зорилго, үнэт зүйл болохоос биш*, дэлхий нийтэд бүтээгдчихсэн ахлах сургуулийн загварыг нүүдлийн амьдралд тулгаж, гэхдээ нийтээр нь дээд боловсролын агуулга болон багшийн ажилтай холих нь бидний эрхэм зорилго яв ч биш.

Дээрх тайлбар, үндэслэлээрээ ахлах сургуулийн сургалтын хөтөлбөрийг сонголттой болгох, түүнийг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх зорилтыг үгүйсгээгүй. Хэрэв үүнийг сайн төлөвлөж, хэрэгжүүлж чадвал бүрэн дунд болон дээд боловсролын бакалаврын шатны сургалтын залгамж холбоог хангахад үнэхээр тустай.

Харин *ахлах ангийн сургалтад кредит систем нэвтрүүлнэ гэдгийг хүлээн зөвшөөрөх боломжгүй юм*. Бүрэн дундын түвшинд өөрсдийнхөө төрөлжсөн, гүнзгийрсэн агуулгыг яаж цагтаа багтааж, чанартай хэрэгжүүлэх дөрөө олоогүй байж, их дээд сургуулийн хөтөлбөрийг нааш нь татан, тооцуулж, тэдний ажлыг "хөнгөлөх" ямар сонирхол, шаардлага байна вэ?. "Даахгүй нохой булуу хураана" гэгчээр дээд сургуулийн багшийн түвшинд багшаа бэлтгэх үү? гэх мэт олон асуудал байна. Харин дээд боловсролын түвшинд чадварлаг сурагчдын гүнзгийрүүлэн судалсан хичээлийн кредитийг тусгай шалгуур тавьж байгаад шууд тооцуулах арга механизмыг бий болгож болно. Ингэх нь дээд боловсролын тогтолцоонд нээлттэй байдаг, ингэх нь дээд боловсролын тогтолцоог ч эвдэхгүй. Тэгээд ч сар бүрээр нь гүйцэтгэл тооцож олгодог дунд сургуулийн багшид цалин олгох механизм, дээд сургуулийн кредитээр тооцож, хагас ба бүтэн жилээр гүйцэтгэл тооцож, багшийн цалин хөлсийг сар бүр тооцож олгодог арга механизм хоорондоо тохирохгүй. Үүнийг Сангийн яам ч зөвшөөрч санхүүжүүлэх, гүйцэтгэлийг хянахад төвөг учирна.

Иймд шатлал, түвшин хоорондын залгамж холбоог хангана гэдэг нь бие биеийнхээ ажлыг "нөхөж, булааж" хийхийн нэр биш харин тэдгээрийн бие даасан дэд тогтолцоо (өөрийн гэсэн бодлого, стратеги, төлөвлөлт, менежмент, санхүүжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ) болохыг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ *хүний хөгжлийн амин холбоог илэрхийлдэг тэдний хөгжих хэрэгцээ, агуулга, арга зүй, ахицын үнэлгээний залгамж холбоо* болохыг ухаарах хэрэгтэй байна.

Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн урлаг, биеийн тамирын хичээлийн агуулга, хөтөлбөрийг сайжруулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангана (ЗГҮАХ: 2.3.11).

Сургууль, цэцэрлэгийн урлаг, биеийн тамирын хичээлийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээг эдгээр хичээлийн сургалтын хөтөлбөрүүд; биеийн тамирын болон урлагийн танхим, сургалтын тоног, төхөөрөмжийн хангалт ба хүртээмж; багшийн ур чадварын хэрэгцээ; суралцагчдын хөгжил; бүлэг дүүргэлтийн хэмжээ зэрэг олон хүчин зүйлийг тооцон хийсний дараа эхлээд тэдгээрийг сайжруулах шийдлүүд-үзэл баримтлал, зардлын тооцоолол, санхүүжилтийн эх үүсвэрээ тодорхойлох нь чухал юм.

Өөрөөр хэлбэл, ЗГ-ын арга хэмжээний төлөвлөгөөнд заасан шиг нэг зорилт дээр нэг арга хэмжээ биччихээд, хүрэх үр дүн дээр хөтөлбөрийн хэрэгжилт эхэлчихсэн байхаар төлөвлөж болохгүй.

Бүх нийтэд хүний эрх, жендэрийн боловсрол олгох үндэсний тогтолцоог хөгжүүлж, жендэрийн тэгш байдлыг хангах бодлого баримтална (ЗГҮАХ 4.2.7).

Бүх түвшний, бүх хэлбэрийн боловсролын сургалтын хөтөлбөрүүдэд хүний эрх, жендэрийн боловсролын интерацчилагдсан байдал болон тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тогтмол хяналт-шинжилгээ, үнэлгээ гүйцэтгэж, шаардлагатай тохируулгуудыг хийж занших нь суралцагчдад хүний эрх, жендэрийн боловсрол эзэмшүүлэхэд чухал ач холбогдолтой.

Боловсролын бүх түвшний байгууллагын менежментийн хөгжил, соёлын төлөвшил, ялангуяа шийдвэр гаргалтад жендэрийн тэгш байдлыг хангах мөн СӨБ, БДБ-ын түвшний багшлахуйн кластерийн бүх үе шатанд жендэрийн харьцааг хангах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Тухайлбал, үүний хамгийн гол хөшүүрэг нь нийгмийн чинээлэг дундаж давхаргын дээд шатлалд харгалзахаар багшийн амьдралын чанарын баталгааг хангахуйц түвшний цалин хөлс, нийгмийн халамж, хамгааллыг бий болгох явдал юм. Энэ нөхцөл хангагдсан тохиолдолд эрэгтэй элсэгчид, багш нар энэ салбарт татагдан орж ирэх нь ойлгомжтой. Боловсрол дахь энэ хөрөнгө оруулалтыг даруй хийвэл түүний үр нөлөө нь ойрын 10-аад жилийн дараа боловсролын чанарын дорвитой ахицаар илт мэдрэгдэнэ. Боловсролын, ялангуяа сургалтын байгууллагад жендэрийн мэдрэмжтэй хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлт, санхүүжилт хэрэгтэй байна.

Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох талаар

ЗГ-ын 2020-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд тусгагдсан энэ зорилтыг хэрэгжүүлэхдээ хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн төрөл, онцлогийг үндэслэн тогтоосон ердийн сургууль, тусгай сургууль, гэр бүлд зориулсан гэх мэт сургалтын төрлүүдээ ялгаж байгаад тусгай хэрэгцээ бүрд нь тохирсон сургалтуудад хэрэглэх хөтөлбөр боловсруулах, турших, улмаар тэдгээр сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэдэн багшийг ямар арга замаар хэрхэн бэлтгэж, үр дүнг нь тооцох зэргийг нарийвчлах хэрэгтэй. Мөн хэрэгцээгээ тодорхойлсны дараа хөтөлбөр, хүний нөөц, сургалтын хэрэглэгдэхүүнээ нэгэн зэрэг багцаар нь цаг хугацааны хувьд бага зэргийн ялгаатайгаар эхлүүлж, зарцуулах хугацаагаа үйл ажиллагааныхаа үе шатуудад харгалзуулан хувааж гүйцэтгэх нь илүү оновчтой бус уу? Хэсэг хэсгээр нь богино хугацаанд хийсэн үйл ажиллагаанууд хоорондоо уялдаагүй болж, үр ашиг, үр өгөөж нь сулрах эрсдэлтэй. Энэ хэвээрээ байвал төлөвлөгөө гэхэд хэцүү, хэдэн санаа төдий болчих гээд байна. Бас үнэлгээний асуудал огт тусгагдаагүй байна.

Хүүхэд бүр ялангуяа малчин, ядуу өрхийн болон тусгай хэрэгцээт хүүхдүүд хэрэгцээ, боломждоо нийцсэн СӨБ-ын үйлчилгээнд хамрагдсан байх талаар.

ЗГ-ын 2020-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд дэвшүүлсэн энэ зорилтын хүрээнд хүүхэд бүр ялангуяа малчин, ядуу өрхийн болон хөгжлийн тусгай хэрэгцээт хүүхдүүдийн хэрэгцээ, боломжид нийцсэн СӨБ-ын ердийн, гүнзгийрүүлсэн, дүйцүүлсэн, тусгай ба дүйцсэн сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд багшид шаардлагатай мэдлэг, ур чадварууд эзэмшүүлэх чиглэлээр багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрүүдийн салшгүй нэг бүрэлдэхүүн хэсэг болгон интеграцчилж, тэднийг мэргэшүүлэх, багшийн ажлын үнэлгээний гол шалгууруудын нэг болгон журамлах нь оновчтой юм. Ингэх нь тулгамдсан асуудлыг тодорхой цаг хугацаанд тодорхой төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, "гал унтрааж" шийдвэрлэхээс илүүтэйгээр дэлхий нийтийн болон Монгол Улсын хөгжлийн урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод тусгалаа олсон ТХЗ-4-ын гол үзэл санаа, зорилтууд, Мастер төлөвлөгөөний харгалзах зорилтууд,

ЗГҮАХ-ийн 4.2.7-д заасан зорилтуудын хэрэгжилтийн тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой.

В. Багш бэлтгэх боловсролын стандарт ба сургалтын хөтөлбөр

- *Бүх түвшний багш, удирдах ажилтны мэргэжлийн ур чадвар, тасралтгүй хөгжих боломжийг бий болгох уян хатан сургалтын хэлбэрүүдийг нэмэгдүүлж, мерит зарчимд тулгуурласан хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлж, цалин хөлс, нийгмийн баталгаа сайжирсан байна (МТЗб: Файл2, Sheet 11-ийн С14).*
- *Багш мэргэжлийн стандартыг боловсруулан батлуулсан байна (ЗГАХХ: Файл2, Sheet 2-ийн J67).*
- *Монгол хүүхдийг төлөвшүүлэх, Дэлхийд өрсөлдөхүйц монгол хүнийг бэлтгэх үзэл баримтлалыг их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгасан байна (Файл2, Sheet 2-ийн J44)..*
- *Багш мэргэжлээр элсэгчдэд тавигдах шаардлагыг өөрчилж, сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэх зохицуулалтыг бий болгох, Багш мэргэжлээр элсэгчдийн хүйсийн тэнцвэрт байдлыг хангах чиглэлээр дэмжлэг үзүүлэх зохицуулалтыг хийх, Багш мэргэжлээр суралцагчдад тавигдах шаардлагыг өөрчилж, сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэх зохицуулалтыг бий болгосон байна (ЗГАХХ: Файл2, Sheet 2-ийн J68).*

Мастер төлөвлөгөөний салбарын түвшинд тодорхойсон “хүрэх үр дүн” хэсэгт тусгагдсан “Бүх түвшний багш, удирдах ажилтны мэргэжлийн ур чадвар, тасралтгүй хөгжих боломжийг бий болгох уян хатан сургалтын хэлбэрүүдийг нэмэгдүүлж, мерит зарчимд тулгуурласан хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлж, цалин хөлс, нийгмийн баталгаа сайжирсан байна” гэсэн хэт хураангуйлан ерөнхийлөгдөж, маш их агуулгыг багтааж томъёологдсон энэхүү хүрэх үр дүн нь салбарын хэмжээнд онцолсон боловсролын бүх түвшний хүний нөөцийн хөгжилтэй холбоотой хүрэх үр дүн боловч СӨБ болон БДБ-ын дэд салбарт аль зорилтын болон хүрэх үр дүнд тус тус оноогдож байгаа нь тодорхойгүй байгаа тул энэ төлөвлөгөөний тухайд салбарын хэмжээнд тодорхойлогдсон дээрх хүрэх үр дүнг хэрэгжүүлэх болон үнэлэхэд төвөгтэй байдлыг үүсгэж байна.

"Чадварлаг багш" арга хэмжээ нь нэг талаас, шинэчлэн батлагдах сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж чадах, нөгөө талаас, боловсролын инклюзив ба үл алагчилах (equity) зарчмыг хэрэгжүүлэхийн тулд багш суралцагчдын янз бүрийн зорилтод бүлгүүдтэй ажиллах, мэдлэг, чадвар, эв дүйг эзэмшсэн байх асуудлын аль алийг багтаасан байх нь зүйтэй. Тухайлбал, багшийн ур чадварт суралцагчдад Монгол Улсын нэгдмэл үнэт зүйлийн өвлүүлэх, эх хэлний сургалтын чанарыг сайжруулж, монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, ТХБ-ыг эзэмшүүлэх, орчин үеийн шинжлэх ухаан, ажил амьдралын ур чадвараар гүнзгийрсэн олон улсад өрсөлдөх чадвартай сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх шаардлага; түүнчлэн малчдын болон ядуу өрхийн хүүхдүүд, үндэсний цөөнх, хөгжлийн тусгай хэрэгцээтэй, онцгой авьяас чадвартай хүүхдүүд, сургууль завсардсан насанд хүрэгчид, эцэг эхтэй ажиллах зэрэг арга зүйн тусгай мэдлэг, ур чадварын шаардлагууд тавигдана. Иймээс "Чадварлаг багш"-ид эдгээр бүх шаардлагууд тавигдаж, багш мэргэжлээр суралцах элсэгчдийг татах, багшаар бэлтгэх, багшаар ажиллуулах хөгжлийн цогц бодлогод зангидагдсан байх шаардлага байна.

Багш мэргэжлээр элсэгчдэд тавигдах шаардлагуудыг өөрчлөх, хүйсийн тэнцвэрт байдлыг хангах болон суралцах хугацаанд нь сургалтын төлбөрийн зээл олгох, эрдэм судлалын ажилд дадлагажуулах, багшлах дадлагын хугацааг уртасгах зэрэг дэмжлэгүүд үзүүлэх талаар

ЗГ-ын 2020-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл болон Мастер төлөвлөгөөнд тусгагдсан багш мэргэжлээр элсэгчдэд болон суралцагчдад үзүүлэх дэмжлэгүүд болон шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг бий болгохдоо өөр хооронд нь

нягт уялдуулахын зэрэгцээ багшлах үйлийн хөгжил буюу багшлахуйн кластерийн бүхэл бүтэн тогтолцоонд авч үзэж шийдвэрлэх нь зүйтэй юм. Тухайлбал,

"Багшлах дадлагын хугацаанд өөрчлөлт оруулж, дадлагын хугацааг ажилласан жилд тооцох, урамшуулал олгох эрх зүйн зохицуулалт хийсэн байна" гэсэн зорилт нь хуулиар зохицуулж болох ч гэсэн багшлах дадлагыг ажилласан жилд тооцохын тулд тэд нийгмийн даатгалын шимтгэл төлөх болно. Энэ шимтгэлийг оюутан бүр төлж чадах уу, оюутанд цалин өгөх үү? өгөх тохиолдолд эх үүсвэрийг баталгаажуулж чадах уу? дунд сургуулийн багш цалингаа бүтэн авах үндэслэл хөндөгдөх үү? гэх мэт олон асуултад хариулт олж, эерэг үр дагавраас гадна гарч болзошгүй сөрөг үр дагаврыг сайн тооцох хэрэгтэй.

“Боловсролын зээлийн сан”-г орлогын олон талт эх үүсвэр бүхий “Боловсролын хөгжлийн сан” болгож оюутныг дэмжсэн үндэсний тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх талаар

Сургалтын байгууллагын болон сургалтын хөтөлбөр нь магадлан итгэмжлэгдсэн багш бэлтгэдэг их, дээд сургуулийн голч дүн өндөртэй оюутнуудад сургалтын төлбөрийн зээл олгох, эрэгтэй болон олон хүүхэд нь зэрэг суралцаж, дээрх шаардлагыг хангасан оюутнуудын төлбөрийг бүрэн даах, тодорхой хэмжээгээр хөнгөлөх үйл ажиллагааг илүү үр өгөөжтэй, үр ашигтайгаар зохион байгуулахдаа "Багш" мэргэжилтний эрэлт нийлүүлэлтийн харьцааг тооцож байх нь илүү үр ашигтай байх нэг нөхцөл болно. Төрийн сангийн зээл авчихаад сургуульд багшлахгүй, өөр салбарт ажиллах, эсвэл ажлын байрны эрэлтээс давсан илүүдлийг бий болгох зэрэг нь боловсролын энэ төрлийн зардал үр ашиггүй байхад хүргэж болзошгүй юм. Харин Боловсролын төрийн сангийн тодорхой хэсгийг зохих шаардлага хангасан багш нар боловсролын зэргээ ахиулж, мастерийн болон докторын хөтөлбөрийн ахисан төвшний сургалтад хамрагдахад дэмжлэг, хөнгөлөлт үзүүлдэг болгон өөрчлөх зохицуулалт хийж болох юм.

Багш бэлтгэх, бакалавр, мастер, докторын хөтөлбөр болон ИДС-ийн магадлан итгэмжлэх талаар

Багш бэлтгэх тогтолцоог сайжруулахаар төлөвлөсөн ЗГ-ын арга хэмжээний төлөвлөгөөний төсөл болон Мастер төлөвлөгөөнд дэвшүүлсэн багш мэргэжлийн стандартыг шинэчлэх, их, дээд сургуулиудаар багш бэлтгэх бакалавр, магистр, докторын хөтөлбөрийг мэргэжлийн чиглэлээр ангилж, чанарын үнэлгээг тасралтгүй хийх, бакалавр, мастер, докторын сургалтын хөтөлбөрийг заавал магадлан итгэмжлэх эрх зүйн зохицуулалт хийх, сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийг чанаржуулах, багш бэлтгэдэг их, дээд сургуулиудыг аттестатчилах, төгсөгчдийг ажилд томилон ажиллуулах, эдгээр өөрчлөлтийг баталгаажуулан холбогдох хууль, тогтоомжид өөрчлөлт оруулах зэрэг зорилтуудыг өөр хооронд нь нягт уялдуулахын зэрэгцээ багшлах үйлийн хөгжил буюу багшлахуйн кластерийн бүхэл бүтэн тогтолцоонд авч үзэж шийдвэрлэх нь оновчтой юм.

Мөн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн мөшгих судалгааг жил бүр хийж, багш мэргэжлээр элссэн, төгссөн, ажиллаж байгаа багш нарын мэдээллийн статистикт тулгуурлан багшаар бэлтгэхэд гарах дотоод үр ашиг, бэлтгэсэн багшийг бусад салбар болон ажилд алдах гадаад үр ашгийн болон багшийг тогтоон барихад нөлөөлж буй хүчин зүйлсийн нөлөөллийн судалгааг тогтмолжуулж, нотолгоонд суурилсан холбогдох арга хэмжээ авч байх чухал юм.

Багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл, түүний дотор эрх зүйн орчныг бүрдүүлэхдээ хөтөлбөрийн чанар, түүний хэрэгжилтийн түвшинг тогтоож зэрэглэхэд хэрэглэгдэх нэгдсэн шалгуур, индикаторууд болон тэдгээрийн хэмжилтийн нарийвчлалыг сайжруулах хэрэгтэй. Дашрамд тэмдэглэхэд, магадлан итгэмжлэх багийн гишүүдийн ажлын хөлсний хэмжээг энэ ажлынх нь мөн чанарт нийцсэн байдлаар тогтоож, эгэх хариуцлагын өндөржүүлэх нь магадлан итгэмжлэл чанартай, үр өгөөжтэй хийгдэхэд тустай.

4.2.4. Багшлахуйн хөгжил-Боловсролын салбарын цахим шилжилт

Өнөөгийн мэргэжил дээшлүүлэх тогтолцоог багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах гол стратегийн хүрээнд багшаар ажиллах бүх хугацааны туршид тэдний хэрэгцээ, сонирхолд суурилсан, ажлаа хийнгээ тасралтгүй суралцах боломж олгосон, нээлттэй, сонголттой, үр ашигтай, үр өгөөжтэй, мэргэжил дээшлүүлэх үйлчилгээний тогтвортой, уян хатан тогтолцоо болгон хувирган өөрчлөх бодит хэрэгцээ, шаардлага байна. Үүний тулд дараах цөм асуудлуудад анхаарал хандуулан шийдвэрлэх шаардлагатай. Үүнд:

- Төрөлжсөн сургалтууд нь нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангасан байх
- Боловсролын үндэсний түвшний мэргэжлийн байгууллагуудын чиг, үүрэг үйл ажиллагаа, бүрэн эрх, тэдгээрт тавигдах шаардлагуудыг судалж, гарсан үр дүн, дүгнэлт, зөвлөмжийг өргөн хүрээнд үр өгөөжтэй хэлбэрээр хэлэлцүүлэн шаардлагатай бол БМДИ-ийн үндсэн чиг үүрэг үйл ажиллагааны чиглэлийг өөрчилж, байгууллагын хөгжлийн стратегийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж баталгаажуулан хэрэгжүүлэх
- Боловсролын мэргэжлийн байгууллагын хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх нэгдсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх
- Мэргэжил дээшлүүлэх үндсэн хөтөлбөрийн зэрэгцээ сургалтын хөтөлбөрүүдийн нэр төрлийг багш бүрийн эрэлт хэрэгцээнд нийцэхээр сонголттой болгох
- Суралцах арга хэлбэрийг олон хувилбартай болгох
- Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлтэй төрийн болон төрийн бус байгууллагуудыг шударгаар сонгон шалгаруулах замаар тэдний боловсролын, түүний дотор багшийн хөгжилд оруулах хувь нэмэр, бүтээлч оролцоог нэмэгдүүлэх

Товчоор хэлбэл, төвөөс зохицуулсан нийлүүлэлт давамгайлсан БМДИ-ийн өнөөгийн үйлчилгээний менежментийг багш бүрийн мэргэжлийн насан туршийн суралцахуйн эрэлт хэрэгцээнд суурилсан, бүртгэл тооцоогоор баталгаажсан нээлттэй үйлчилгээний менежмент болгон хөгжүүлэх хэрэгцээ байна. Үүний тулд багш бүр мэргэжлээрээ хөгжих өөрийн хэрэгцээгээ шуурхай, чанартай хангуулах сонголт хийх боломж олгодог байх хэмжээнд мэргэжлийн хөгжлийн "Супермаркет"-ийг бий болгон үйлчилдэг, хэрвээ сургууль, хамт олноороо болон аймаг орон нутгийн хэмжээнд мэргэжлийн багуудаар хандах тохиолдолд "Хапермаркет"-ийн түвшний үйлчилгээ, зуучлал үзүүлэх менежментийг эрхлэдэг байхаар БМДИ-ийн чиг үүргийг хувирган өөрчилнө гэсэн үг юм.

Цэцэрлэг, ЕБС-ийн багш, удирдах ажилтнуудад ажлаа хийнгээ боловсролын магистр, докторын хөтөлбөр дүүргэх боломжит дэмжлэгүүдийг үзүүлж, тэдний ажил мэргэжлээрээ тасралтгүй хөгжих үйл явцыг мерит системд тулгуурласан хүний нөөцийн тогтвортой хөгжлийн бодлоготой уялдуулах нь чухал аа.

Цахим сургалтын платформыг хөгжүүлж, цахим сургалтын хөтөлбөрийг боловсруулан, цахим агуулга, цахим хичээл боловсруулан бүх насны иргэдэд насан туршидаа суралцахуйг дэмжих боломжийг бүрдүүлнэ (ЗГҮАХ 2.3.12).

Цахим сургалтын байнгын болон түр хугацааны платформыг хөгжүүлж, бүх насны иргэдийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн насан туршийн суралцахуйн цахим сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, цахим онлайн аргаар хичээл явуулах багш нарыг бэлтгэх, бүртгэн гэрчилгээжүүлэх, тэдний хамтран ажиллах онлайн сүлжээг бий болгох тусгайлсан хөтөлбөр боловсруулж, "Чадварлаг багш" үндэсний хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэх нь зүйтэй.

Энэ зорилтыг Боловсролын суурь зарчим болох хүн бүрийн насан туршийн суралцахуйн зарчмын өнцгөөс харж, зөвхөн цахим сургалтаар хязгаарлахгүйгээр багшлахуйн кластертай холбоотой бүх төрлийн үйл ажиллагаанд зориулагдан төрөлжсөн, нэгдсэн сүлжээ бүхий платформуудыг бүтээх нь хүн бүрийн насан туршийн суралцахуйн тогтвортой хөгжлийг хангах суурь тавигдахад илүү ач холбогдолтой. Ингэхдээ энэхүү судалгааны ажлын хүрээнд

багшлахуйн талаарх бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн холбогдох хэсгүүдэд тодорхойлогдсон зорилт, арга хэмжээ бүрд өгөгдсөн санал, зөвлөмжүүдийг харгалзан үзэх боломжтой.

Цахим сургалтын нэгдсэн платформ бий болгож, цахим хичээлийн сан бүрдүүлэх талаар

Цахим сургалтын нэгдсэн платформыг байнгын болон богино хугацааны хувилбартайгаар бүтээж, сургалтад нэвтрүүлэх нь суралцахуйн үйл явцдаа биет, материаллаг объектой харьцах замаар анги танхимын хүрээн дэх хамтын ажиллагаагаар явагддаг суралцагчдын танин мэдэхүйг тэдгээр объектыг тоон хэлбэрт шилжүүлсэн дижитал объектоор дамжуулан анги, сургуулиас хальсан үндэсний (олон улсын) түвшний сүлжээнд бусадтай хамтран ажиллах замаар явагдах танин мэдэхүйн үйл ажиллагаа болгон хувиргаж байгаагаараа сургалтын технологи, арга зүйн зарчимд гарч буй том өөрчлөлт юм.

Түүнчлэн сургалтын цахимжилт нь бусад үйл ажиллагааны цахимжилтаас ялгаатай. Тухайлбал, бусад платформуудыг хүмүүс шууд хэрэглэдэг бол багш, сурагч бол түүнийг хэрэглэх замаар өөрсдийгөө хөгжүүлдэг онцлогтой субъектүүд юм. Бас платформууд, түүнийг дагасан мэдлэг чадвар нь богино хугацаанд хуучирч, байнга хөгжиж байдаг онцлогтой.

Иймд сургалтын үйл явцыг цахимжуулахдаа платформын хөгжүүлэлт, багшийн мэдлэг чадварын гүнзгийрэлт, шаардлагатай хэрэглэгдэхүүн, дэд бүтцийн хангамж, хүртээмж, цахим агуулгын чанар, суралцагчийн хөгжил зэрэг асуудлыг цогцоор нь авч үзсэн, найдвартай, тогтвортой, тасралтгүй ажиллагааны баталгааг хангасан алсын хараа бүхий бодлого, стратеги баримтлах нь зүйтэй.

Багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг цахим хэлбэрт шилжүүлж, багшийг мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилсан сургалт явуулах арга зүйд сургах ажлыг үе шаттай зохион байгуулах талаар

ЗГ-ын 2020-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд тусгагдсан энэ зорилтын "Багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг цахим хэлбэрт шилжүүлж," гэдэг хэсэг нь шууд хүлээн зөвшөөрөхөд эрсдэлтэй. Тухайн нэг багш 25-30 жил багшлах хугацаанд нь багшийн хөгжлийг дэмжсэн "танхимын" үндсэн сургалтууд хэрэгтэй. Ер нь бий болгосон зүйлээ нэг удаагийн үндэслэл муутай шийдвэрээр үгүй хийх шиг амархан зүйл байхгүй. Харин түүнийг бүтээх гэж зүтгэсэн олон жилийн хүчин чармайлтынхаа явцад, алдаж, оносон зүйлээ тогтоож, улам сайжруулж байх нь тогтвортой хөгжлийн гол зарчим байдаг. Үүний оронд одоогийн нөхцөл байдлаа сайн үнэлж, илүү сайн арга замыг олж, "үндсэн сургалт"-аа зөвхөн цахимд даатгалгүй авч үлдэж, хөгжүүлэх нь болзошгүй бүх эрсдлийн бэлэн байдлыг хадгалахад ая тустай.

Мөн дээрх зорилтыг зөвхөн мэргэжил дээшлүүлэх төдийгүй, багш бэлтгэх сургуулийн сургалтад цахим агуулгын хэрэглээг өргөтгөж, сургалтын хөтөлбөрт нь цахим агуулга боловсруулах арга зүйг тусгах чиглэлээр өргөтгөн томьёолох нь зүйтэй.

Цахим сургалтын платформ бий болгож, цахим агуулга хөгжүүлж, бэлтгэнэ. Зурагт болон интернэтгүй өрх, хүн амыг цахим сургалтад хамрагдах боломжийг бий болгохын тулд тохирсон сургалтын хэлбэр, хувилбаруудыг судалж, бэлтгэнэ (ЗГҮАХ 1.1.12).

Цахим сургалтын платформыг ашиглан бүх түвшний боловсролын бүх хичээлийн багш нар бие даан бусдаас суралцах, туршлагаа хуваалцах, суралцагч бүртэйгээ тулж ажиллах, эцэг эхтэй хамтран ажиллах багшлахуйн шинэлэг арга барил, технологи ашиглах ёс зүй, шинэ соёлд суралцах боломж бүрдэнэ. Түүнчлэн багш нар зурагт болон интернетгүй өрх, хүн амыг цахим сургалтад хамруулах бусад сүлжээний арга технологийг эзэмшсэн байх хэрэгтэй болж байна.

Энэ зорилтыг салбарын дунд хугацааны төлөвлөгөөнд нарийвчлан задалж, хүрэх үр дүнгүүдийг харилцан уялдаа холбоотойгоор, хэмжиж, бодитоор хэрэгжүүлж болохоор тодорхой томъёолж, бие даасан төсөл, хөтөлбөрүүд хэлбэрээр багшлахуйн кластерийн дээрх код бүхий агуулгын хүрээнд хэрэгжүүлж болно. Ингэхдээ энэхүү судалгааны ажлын хүрээнд багшлахуйн талаарх бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн холбогдох хэсгүүдэд тодорхойлогдсон зорилт, арга хэмжээ бүрд өгөгдсөн санал, зөвлөмжүүдийг тусгах боломжтой.

Цахим сургалтын тогтолцоог бий болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ (ЗГҮАХ 1.1.13).

Цахим сургалтыг боловсролын болон бусад холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах, дүрэм журмыг шинэчлэн боловсруулахдаа зөвхөн цахим сургалтад төвлөрөхгүйгээр ердийн болон гамшигийн үед сургалтын байгууллагад онлайн цахим сургалт явуулах, мөн сургалтын байгууллагад сургалтын менежментийн цахим систем нэвтрүүлэх гэх мэтчилэн боловсролын тусгай зориулалтаар төрөлжүүлсэн бусад платформуудыг бүтээж, *боловсролын үйл ажиллагаанд бүхэлд нь цахим шилжилт хийх алсын хараатайгаар асуудалд хандах нь чухал* юм. Тухайлбал, багшлахуйн кластерийн бүх үе шатууд, зангилгаа төлөв байдлуудад хамаарах үйл ажиллагаануудыг цахимжуулсан платформуудыг бүтээх, тэдгээрийн найдвартай ажиллагаа, аюулгүй байдал, сүлжээнд ажиллах, технологийг хэрэглэх, цахим мэдээллийг ашиглахтай холбоотой иж бүрэн эрх зүйн зохицуулалтыг бий болгож болно.

Боловсролын салбарын үндсэн үйл ажиллагаа болох сургалтыг "цахим сургалт"-ын тогтолцоонд шилжүүлэхдээ түүний агуулга, арга зүй, сургалтын хэрэглэгдэхүүн, үнэлгээг бүрэн хамарсан, цахим сургалтыг хэрэгжүүлэх хүний нөөцийн хөгжил, энэ харилцаанд оролцогчдын эрх үүрэг, хариуцлага, дэд бүтэц, тоног төрөөрөмжийн хангалт зэрэг ердийн анги танхимд тавигддаг стандартууд, үүсэх харилцаануудыг цахим орчны онцлогтой нийцүүлсэн хууль, эрх зүйн иж бүрэн зохицуулалтыг бий болгох шаардлагатай. Энэ эрх зүйн зохицуулалтыг бий болгохын тулд цахимжуулалтын үндсэн үе шат бүрийг нарийвчилсан сургалт болон тухайн үйл ажиллагааг нарийвчлан бүрэн алгоритмчилах судалгаанууд шийдвэрлэх ач холбогдолтой.

Багш бүрийг цахим агуулга боловсруулах боломжоор хангаж, цахим хичээлийн үр дүнгээр нэмэлт орлого олох боломжийг олгох талаар

ЗГ-ын 2020-2024 оны арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд тодорхойлсон энэ үр дүнг хүлээн зөвшөөрөх үр дүн мөн эсэх тал дээр эргэлзэж байна. Хэрвээ багш нар цахим агуулга боловсруулаад борлуулж орлого олдог болвол тэд үндсэн ажилдаа төвлөрч, ач холбогдол өгөлгүй орлогын хойноос хөөцөлдөж, цахим агуулгын цахим худалдаа цэцэглэвэл яах вэ? Үүнийг үгүйсгэх аргагүй. Харин хийсэн цахим агуулгынхаа зохиогчийн эрхийг баталгаажуулаад мэргэжлийн зэрэг, ур чадварын нэмэгдлээрээ дамжуулж, орлогоо нэмэгдүүлэх боломжтой юм. Иймд энэ томъёоллыг эргэн харж хэлэлцэх хэрэгтэй.

Бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ (ЗГҮАХ 4.1.7).

Юуны өмнө цахим систем хөгжүүлэлтийг Бизнес анализ-Системийн анализ- Хөгжүүлэлт- Туршилт гэсэн үе шат бүхий дарааллаар гүйцэтгэж, зориулалтаар нь төрөлжүүлсэн, тал бүрийн хэрэглээтэй платформуудыг бүтээж, нэгдсэн сүлжээнд холбож, тэдгээрийн найдвартай, аюулгүй ажиллагааг хангах шаардлагатай. Энэ нь боловсролын нэгдсэн цахим сүлжээний хүрээнд хийгдэх цахим шилжилтийн ажлууд байх болов уу.

Харин нэг талаас, багш нар эдгээр платформууд, сүлжээнд ажиллах ур чадвартай байхын тулд зохих хүчин чадал бүхий компьютерээр хангах, тэдэнд зориулсан цахим бичиг үсгийн стандарт боловсруулж мөрдөх, энэ стандартыг хангах түвшний сургалтын хөтөлбөрүүд

боловсруулан хэрэгжүүлэх, багш бэлтгэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг олон арга хэлбэрээр явуулж үр дүнг тооцох, багш нар сургалтын болон бусад үйл ажиллагаандаа цахим технологийг нэвтрүүлэх зэрэг цогц арга хэмжээг авах хэрэгтэй.

Нөгөө талаас, багш нар сурагчид, тэдний эцэг эхийн МХТ-ийн мэдлэг чадварыг дээшлүүлэхэд туслах үүрэгтэй. Ялангуяа, малчид, хөгжлийн тусгай хэрэгцээтэй хүүхдүүд, тэдний эцэг эхийн энэ төрлийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх тусгай төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломжтой юм.

Энэ зорилтыг салбарын дунд хугацааны төлөвлөгөөнд нарийвчлан задалж, хүрэх үр дүнгүүдийг харилцан уялдаа холбоотойгоор хэмжиж, бодитоор хэрэгжүүлж болохоор тодорхой томъёолж, багшлахуйн кластерийн дээрх код бүхий агуулгын хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатай.

Хөтөлбөр 2.2.5: Нээлттэй боловсролын хөтөлбөрийн талаар

Энэ хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ бүх нийтэд зориулсан нээлттэй, ТХБ-д суурилсан, насан туршийн суралцахуйн зөвхөн сургалтын хөтөлбөр бус бусад асуудлыг хамарсан тогтолцооны үндэс суурийг бүрдүүлэх гэсэн утгаар өргөтгөн авч үзэж, холбогдох үйл ажиллагаануудыг нэмж тусгасан нь зүйтэй болов уу. Дашрамд тэмдэглэхэд, Мастер төлөвлөгөөний “Хөтөлбөр 1.3.2.5-д заасан “ТХЗ-4”-ийн хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний арга зүйг боловсруулж, дунд болон сүүлчийн шатны үнэлгээг хийх”-ийг эс тооцвол, **ЗГ-ын түвшний бүх төлөвлөгөөнд ТХБ-ын тухай "огт дурьдаагүй" гэхэд болохоор байна.** Мөн Мастер төлөвлөгөөнд НТБҮТ-ийг ямар статустайгаар яаж хөгжүүлэх, мөн албан бус боловсролыг дэмжих талаар зорилт, үйл ажиллагаа маш явцуу хүрээнд нэр төдий тусгагдсан байна. Уг нь энэ асуудал боловсролын тухай хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн бие даасан боловсролын институт болохынхоо хувьд өнгөрсөн бүх хугацаанд хөгжлийн бодлого, төлөвлөгөөнд бие даасан статустайгаар төлөвлөгдөж ирсэн байдаг. Боловсролын тогтолцооны хувирган өөрчлөлтийн суурь зарчим болсон "насан туршийн суралцахуй"-н зарчмыг судалгаанд хамрагдсан бүх баримт бичигт тодорхой нэг зорилтын хүрээнд халт дурьдах, зарчим хэсэгт нэр төдий л дурьдсан байна. Гэтэл өнгөрсөн хугацаанд бий болгож, явцуу хүрээнд ч гэсэн ойлгож, алдаа оноотой ч гэсэн хэрэгжүүлж ирсэн хүчин чармайлтаа боловсролын тогтолцооны хувирган өөрчлөлтийн цөм агуулга болгон дэвшүүлэн гаргаж, түүнийг дэмжсэн бодлого, төлөвлөгөө шаардлагатай байгааг "Алсын хараа-2050: Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-д баталгаажуулж, сүүлийн жилүүдэд хийгдсэн дотоод, гадаадын олон судалгааны зөвлөмжид онцлон зөвлөсөөр байтал байдлыг улам бүдгэрүүлж дордуулсан байгаа бөгөөд тодорхой дурьдаагүй ч магадгүй түүнийг "цахимжилт ба нээлттэй боловсрол"-оор орлуулсан байдал ажиглагдаж байна. **Энэ бол том ухралт, бас хариуцлагагүй явдал юм.** Энэ асуудлыг хэрхэхээ шийдвэрлэх шаардлагатай.

Боловсролын салбарт мэдээллийн системийн инновацийг нэвтрүүлж, нэгдсэн сүлжээг өргөтгөх замаар мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх талаар

Боловсролын салбарын хүний нөөцийн цөм болохынх нь хувьд багш мэргэжлээр суралцагчдын өсөлтийн прогноз, сургалтын байгууллагын шинэ зураглал зэрэгт нийцүүлэн бэлтгэх мэргэжилтний хэрэгцээг боловсролын шатлал, бүлэг дүүргэлт, боловсролын зэрэг, мэргэжлийн ангиллаар тооцоолж, бэлтгэх тодорхой төлөвлөгөө боловсруулж багшийн нөөц, түүний хөгжлийн талаар баримтлах бодлого, тэргүүлэх чиглэл, стратегийн төлөвлөлттэй байх нь чухал юм.

Боловсролын салбарт мэдээллийн системийн инновацийг нэвтрүүлж, нэгдсэн сүлжээг өргөтгөх замаар мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх, багшлахуйн кластер дахь багш, удирдах ажилтантай холбоотой доорх кодын хүрээнд багтах болон шаардлагатай бусад агуулга бүхий мэдээллийг боловсролын салбарын мэдээллийн санд нарийвчлан задлаж оруулж, тэдгээрт анализ хийж, дүгнэлт гаргах замаар холбогдох бодлого, шийдвэрүүдийг гаргадаг болох хэрэгтэй. Үүнд:

{БК2.1.3}; {БК2.3.1}; {БК2.3.2}; {БК2.4.2}; {БК1.1.4}; {БК2.2.4}; {БК2.5.1}; {БК2.5.2}; {БК2.5.3}; {БК3.3.1}; {БК4.5.1}; {БК4.5.2}; {БК4.5.3}; {БК4.5.1}; {БК4.6.1}; {БК4.6.3}; {БК4.6.4}; {БК4.6.5}; {БК4.6.6}; {БК4.6.7}; {БК4.6.8}; {БК4.6.9}; {БК4.7.1}; {БК4.7.2}; {БК4.7.3}; {БК4.7.4}; {БК4.7.5}; {БК4.7.6}; {БК5.1.2}; {БК5.1.4}; {БК6.1}; {БК6.2}; {БК6.3}; {БК6.4}; {БК6.5};

Боловсролын салбарын мэдээллийн системийг уялдаа холбоог сайжруулж, харилцан мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлж, боловсролын байгууллагуудыг нэгтгэсэн салбарын сургалт, судалгаанд зориулсан өргөн зурвасын сүлжээг өргөжүүлэх талаар

Боловсролын удирдлагын мэдээллийн системийн өгөгдлийг ашиглан багш, удирдах ажилтны сургалтын агуулгыг модулчилах, боловсролын аль ч чиглэлийн судалгаа хийхдээ мэдээллийн цахим сүлжээ ашиглан эх сурвалжуудыг ашиглах боломж бүрдэнэ.

ЗГ-ын арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд багш, удирдах ажилтныг бэлтгэх, тэдний мэргэжил дээшлүүлэх асуудал бие даасан зорилт байдлаар тусгагдаагүй, зөвхөн зорилт ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 1.1.12 ба 2.3.12 хүрээнд цахим талаас нь харсан байгаа тул дээрх төлөвлөгөөний төсөлд багшлахуйн кластерийн цөм асуудлууд энд тэнд тарсан байдалтайгаар тусгагдаж, "Чадварлаг багш" арга хэмжээнд базагдаж чадаагүй байна. Энэ байдлаас болоод уг арга хэмжээ маань ч бас сарнимал байдалтай тусгагдсан байгаа тул төлөвлөгөөг сайжруулахдаа анхаарах хэрэгтэй.

4.2.5. Чанарын гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

Ерөнхий боловсролын сургалтын чанарыг дэлхийн жишигт нийцүүлэх зорилгоор олон улсын PISA үнэлгээнд хамруулж, үндэсний чанарын үнэлгээний тогтолцоог бэхжүүлнэ. (ЗГҮАХ 2.3.3)

Суралцагчийн сурлагын амжилт, багшийн ажлын гүйцэтгэл ба ур чадварын өсөлт, сургалтын байгууллагын үйл ажиллагааг үнэлэх, шалгуур, индикаторууд, тэдгээрийг үнэлэх арга хэлбэрийг оновчлох болон боловсролын чанарын үнэлгээний тогтолцоог бэхжүүлэхдээ дараах шалгуур индикаторуудын нийцэл, холбоо хамаарлыг бүрэн хангах шаардлагатай. Үүнд:

- Боловсролын хөгжлийн урт ба дунд хугацааны бодлого, төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх шалгуур индикаторууд
- Боловсролын стандарт болон сургалтын хөтөлбөр дэх хүлээгдэж буй үр дүнгүүд, тэдгээрийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд,
- Сурагчийн сурлагын амжилтын үнэлэх шалгуур индикаторууд,
- Багшийн ажил болон мэргэжлийн хөгжлийг үнэлэх шалгуур индикаторууд,
- Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг үнэлэх шалгуур, индикаторууд
- Боловсролын хөгжлийн дунд ба богино хугацааны бодлого, төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлэх шалгуур индикаторууд зэрэг болно.

Энэ тогтолцоог бүрдүүлэхэд бүх түвшний боломжтой бүх төрлийн шалгалт ба үнэлгээний ажлыг цахимжуулах, тестийн баялаг сан бүрдүүлэх, хүний нөөцөө чадавхижуулах зэрэг цогц үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэх нь ойлгомжтой. Энд дараах 3 зүйлийг чухалчилан тэмдэглэж байна. Үүнд:

- Үнэлгээний түлхүүр нэр томьёо (үнэлгээний төрлүүдтэй холбоотой нэр томьёонууд, шалгуур, индикатор, үзүүлэлт гэх мэт)-уудыг тогтож, нийтээрээ нэгэн утгаар ойлгох, хэрэглэх (ярих, бичих).
- Аливаа үнэлгээ, түүний дотор багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг менежментийн бусад үе шатнаас нь салангид авч үзэхгүй байх. Тухайлбал, багшийн ажлыг төлөвлөх, үнэлэх, дүгнэн урамшуулах үйл ажиллагааг нэгдмэл байдлаар авч үзэж, нийцэл

зохицлын хангасан зохицуулалт бүхий журам хэрэгтэй. Зүйрлэвэл, "юуг яаж л тарина, түүнийгээ л хураан авна"

- Аливаа үнэлгээ, түүний дотор PISA үнэлгээг зориулалтаар нь хэрэглэх. Өөрөөр хэлбэл, үнэлгээний "харааны онь" нь буюу зориулалт нь байгууллага, хүмүүсийг зэрэглэн урамшуулах зэмлэх гэхээсээ илүү боловсролын чанарын талаар баримтлах бодлого, стратегээ, эрх зүйн зохицуулалтаа нарийвчлан сайжруулах арга хэрэгсэл, нотолгоо, үндэслэл болж байдаг талаас нь хандах зүйтэй.

Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлогыг боловсруулан хэрэгжүүлж, 0-6 хүртэлх насны хүүхдийн цогц хөгжлийн судалгааг 3 жил тутамд зохион байгуулж, хүүхдийн цогц хөгжлийн үнэлгээний шалгуурыг тогтоох талаар

Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх зорилтын хүрээнд 0-6 хүртэлх настай хүүхдийн хөгжлийн судалгаа явуулж, тэдний цогц хөгжлийг үнэлэх шалгуур, индикаторыг тогтоохдоо багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх болон цэцэрлэг, орон нутаг, үндэсний хэмжээнд явагдах хөндлөнгийн үнэлгээний шалгуур, индикаторууд хоорондын нийцлийг хангахад онцгойлон анхаарч, судалгааг тогтмолжуулан, СӨБ-ын сургалтын чанарын тогтвортой хөгжлийг хангаж ажиллах нь тустай билээ.

Цогц судалгааны чанар ба нийцлийг хангах чиглэлээр хэрэгжүүлэх энэ хөтөлбөр нь хэрэгжилт нь сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, багшийн хөгжил, орчны бүрдүүлэлт, хүүхдийн хөгжлийн үнэлгээг шинэчлэн уялдаа холбоонд нь авч үзэж сайжруулахад чухал ач холбогдолтой.

Суралцагчийн сургалтын ахиц, дэвшлийн үнэлгээг тогтмол хийх талаар

(4-12 анги бүрийн сурагчдаас санамсаргүй түүврийн аргаар давхардсан тоогоор нийт 140 судлагдахууны даалгаврын санг бүрдүүлж, улирал тутмын хөндлөнгийн үнэлгээ онлайнгаар авдаг болно)

ЕБС-ийн 4-12 анги бүрийн сурагчдаас санамсаргүй түүврийн аргаар давхардсан тоогоор нийт 140 судлагдахууны даалгаврын санг бүрдүүлж, улирал тутмын хөндлөнгийн үнэлгээг онлайнгаар авах судалгаа хийж байх зорилтын тухайд дараах зүйлийг анхаарах шаардлагатай. Элсэлтийн шалгалтад бэлтгэх практикаас харахад сургууль, багш нарыг улирал бүрийн энэ үнэлгээнд гол анхаарлаа хандуулж, сургалтын бусад ажилдаа төвлөрөх анхаарлыг сулруулах өндөр магадлалтай тул сурагчдын ахиц, дэвшлийг үнэлэх хугацааг оновчлох шаардлагатай. Тэгээд ч 7 хоногт цөөхөн цагаар ордог хичээлүүдийн тухайд суралцагчдын суралцахуйд гарах ахицыг улирлаар тогтоох нь эзэмшихүйн зүй тогтол талаасаа ч багшлахуй талаасаа ч учир дутагдалтай.

Хэрвээ багшийн гүйцэтгэлийн үнэлгээг сурагчдын сурлагын ахицтай холбох, багшийн өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний үр дүнгийн зөрөөг багасгах бодлого, стратеги баримталж байгаа бол багш хүүхдүүдтэйгээ хөндлөнгийн ямар ч шахалт дарамтгүйгээр хичээж ажиллах, энэ хичээл зүтгэлийг нь шударгаар үнэлж, цалин хөлс, бодит урамшуулал нь түр зуурын бус, даацтай, тогтвортой байдлаар уялдуулах нь чухал юм. Сурагчдын сурлагын амжилтыг үнэлэх үндэсний хэмжээнд бий болон төлөвшиж байгаа хөндлөнгийн үнэлгээний чадавхийг ашиглан яаж сурагчийн суралцахуйн амжилтыг багшийн ажлын үнэлгээ, цалин хөлс, урамшуулалтай нь холбох талаар зохих судалгаа хийж, өргөн хэлэлцүүлэг явуулах шаардлага байна.

Дашрамд тэмдэглэхэд, бүх “хэлэлцүүлэг”-ийг хэлбэр төдий бус нэлээд чамбайрсан хувилбарийн үр дагавар, үр нөлөөг нь урьдчилан тооцсон гол шийдлүүд, шаардлагатай бол шийдлүүдийн хувилбарууд дээр оролцогчдын сонирхол, анхаарлыг төвлөрүүлж урьдчилсан санал, зөвлөмжийг авдаг, төгсгөлд нь зарчмын өөрчлөлт бараг орохооргүй болсон эцсийн хувилбарыг нийтээр хэлэлцүүлдэг байх гэдэг ч юм уу? ямартай ч

хэлэлцүүлгийн шинэ менежменттэй болж, хэлэлцүүлэгийн ач холбогдол, үр өгөөжийг нэмэгдүүлмээр байна. Өнөөдөр түгээмэл хэрэглэгдэж байгаа хэлэлцүүлэгүүд маань “мөсөн уулны гүнд байгаа чухал санал, зөвлөмж”-ийг тэр бүр илрүүлэн ашиглаж чадахгүй, зарим тохиолдолд хүсэхгүй, хэлбэр тал нь давамгайлаад байгаа тал ажиглагддаг. Үнэ цэнэтэй хэлэлцүүлэг нь уг ажлыг гүйцэтгэгчдийн ч хувьд үнэтэй санал, онолоо нэмэрлэсэн хүмүүсийн ч хувьд “зохиогчийн эрх”-ийн асуудлыг хөнддөг тул шударга зохицуулалттай байхыг шинэ менежментэд бас тооцох шаардлагатай.

Эерэг үр дагавар авчирахуйц оновчтой зөв шийдэл олж байж, холбогдох журмуудад өөрчлөлт оруулах нь зүйтэй.

Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана (ЗГҮАХ 4.2.5).

ЗГ-ын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан энэ зорилгыг хэрэгжүүлэхдээ багшийн ажлын үнэлгээнд ажлын гүйцэтгэлийн явцын болон үр дүнгийн үнэлгээний шалгуур, индикаторуудыг оновчлох, өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ, суралцагч, эцэг эхийн үнэлгээний ялгаа зөрүүг багасгах цогц арга хэмжээг хэрэгжүүлсэн тохиолдолд мэргэжлийн ёс зүй болон сахилга, хариуцлагын зөрчил гаргасан тохиолдолд хүлээлгэх хариуцлага нэмэгдэнэ. Энэ арга хэмжээ авагдаж, зохих шийдлүүд хийгдсэний дараа л шаардлагатай бол багштай холбоотой холбогдох эрх зүйн актуудад зохих өөрчлөлтүүд оруулах нь оновчтой болов уу.

Хөтөлбөр 1.1.2: Хүний нөөцийн чадавх, менежментийг сайжруулах, багшийн үнэлэмжийг хөдөлмөрийн бүтээмж, гүйцэтгэлд суурилсан тогтолцоонд шилжүүлэх талаар

Энэ хөтөлбөр нь боловсролын бүх түвшин буюу боловсролын салбарын хүний нөөц түүний дотор багш хамрагдана гэж ойлговол үйл ажиллагаануудад багшид хандсан тодорхой зүйлс харагдахгүй байна. Үйл ажиллагаанууд нь "хүний нөөц" гэсэн хэт ерөнхий хүрээг хамарсан байгаагийн зэрэгцээ бусад урт, дунд хугацааны төлөвлөлтөд "багшид" онолсон зорилт, үр дүнгийн түвшинд томъёологджээ. Өөрөөр хэлбэл, зорилтууд нь хөтөлбөрүүд, хөтөлбөрүүд нь үйл ажиллагаа болон задарч, үйл ажиллагаа бүрийг үр дүнгийн цогцоор хүрэх үр дүн зорилтдоо харгалзан ерөнхийлөгддөг байтал Үйл ажиллагаа нь зорилтоосоо ялгарах юмгүй, харин ч хамрах хүрээгээрээ илүү ерөнхий болсон тохиолдлууд байна.

Боловсролын бүх түвшинд чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын тогтолцоог өргөжүүлсэн байх талаар

Боловсролын салбарын дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгагдсан энэ зорилтыг хэрэгжүүлэхдээ боловсролын бүх түвшний боловсролын захиргааны болон мэргэжил, арга зүйн байгууллагууд, мөн сургалтын байгууллагууд (цэцэрлэг, ЕБС)-ын менежментэд “Байгууллага бүхлээрээ ажиллах арга хандлага” (Whole institution/school Approach) болон чанарын удирдлагын систем нэвтрүүлэх шаардлагатай.

Эдгээр шинэлэг арга хандлагыг байгууллагын менежментийг нэвтрүүлж, чанарын баталгаажилтын тогтолцоог бүрдүүлэхдээ багшийн хөгжлийг кластерийн загвараар хөгжүүлэх бодлого баримталж, эхний ээлжинд багшлахуйн кластерийн бүх үе шатууд болон зангилаа төлөв байдлуудад хамаарах үнэлгээний шалгуур индикаторуудын хоорондох нийцлийг хангах эрх зүйн зохицуулалт бий болгох, багшийн өөрийн ба бүх түвшний хөндлөнгийн үнэлгээний зөрөөг багасгахад шаардлагатай нөхцөл, боломжуудыг бүрдүүлэх, үнэлгээний арга, технологийг онлайн хэлбэрт шилжүүлж цахимжуулах, энэ чиглэлээр ялангуяа багш нарын чадавхийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх нь тустай.

4.2.6. Багшийн ажлын норм норматив-Цалин хөлс, нийгмийн халамж, хамгаалал

Хөдөлмөрийн зах зээлийг орчин үеийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн шинэчилж, бүтээмж, үр дүнд суурилсан цалин хөлс, ажлын үнэлгээний систем нэвтрүүлж, зайнаас болон цагаар ажиллах уян хатан зохицуулалт бий болгон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ (ЗГҮАХ 2.5.4).

"Алсын хараа 2050: Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого"-д заасны дагуу Монгол Улс нь үндэсний нэгдмэл үнэт зүйлийн гүн ухамсар дархлаатай улс үндэстэн болж хөгжихийн тулд энэ бодлогын цөм болсон "Монгол хүн", ялангуяа хүүхэд, залуучуудад үндэстний нэгдмэл үнэт зүйлийг төлөвшүүлэн өвлүүлж, хүний хөгжлийг хангах үндсэн чиг үүрэг хүлээсэн төрийн албан хаагч болох "Багш" мэргэжилтний нийгэмд эзлэх байр суурь, үнэлэмж, нэр хүндийг төрөөс тусгайлан авч үзэж, тэдний төрийн албан хаагчдын ангилал, зэрэглэлд эзлэх түвшинг дээшлүүлж, үндсэн цалинг онцгойлон нэмэгдүүлж, нэмэгдэл хөлс, нэмэгдэл урамшууллыг ажлын бүтээмж, үр дүнгийн үнэлгээтэй уялдуулсан системийг нэвтрүүлэх шаардлагатай. Ингэх нь нь багш нараас эгэх хариуцлага нэхэх гол үндэслэл болно.

Багшийн үндсэн цалинг өндөр тогтоож, "Багш" мэргэжлийн нийгэмд эзлэх байр суурь, үнэлэмж, нэр хүндийг дээшлүүлж, амьдралын чанарыг баталгаажуулах нь чадварлаг элсэгчдийг татах, чанартай багш бэлтгэх, багшлах хугацаандаа бие дааж мэргэжлийн тасралтгүй хөгжлөө хангах зэрэг багшлахуйн кластерийн бүх үе шатуудад маш том эерэг нөлөө үзүүлж, боловсролын чанарыг эрс дээшлүүлэх үндсэн нөхцөл хангагдах ач холбогдолтой.

Түүнээс гадна багшийн үндсэн цалин өндөр байлгаж, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, төрөл бүрийн урамшуулал, тэтгэмжийн харьцааг оновчтой харьцаанд барих нь багш "бүх нэмэгдэл"-ээс хүртэх шалгууруудыг хангахын төлөө "хөөцөлдөх"-ийг хязгаарлаж, үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаандаа төвлөрөх боломжийг олгоно.

Ингэхийн тулд багшийн ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийн үнэлгээ, дүгнэлтийн асуудлуудыг цогцоор нь харж, эрх зүйн оновчтой зохицуулалт хийж, эдгээр үйл ажиллагаа багшид ойлгомжтой, ил тод, шударга, хүнд сурталгүйгээр явагддаг байхаар цахимжуулах шаардлага байна.

Дашрамд тэмдэглэхэд, 2020 онд УИХ-аар шинэчлэн батлагдсан "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай" хуульд зааснаар Монгол Улсын төрийн бүх түвшний байгууллагууд, байгууллага доторх нэгжүүд, нэгжийн төрийн жинхэнэ албан хаагч бүр үйл ажиллагааныхаа "гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г улсын хэмжээнд ЗГ-аас тогтоосон нэгдсэн бүтэц, дизайн, шаардлагын дагуу боловсруулан мөрдөх болсон. Өөрөөр хэлбэл, төлөвлөлтөд төрөөс онцгой ач холбогдол өгч байгаа нь сайшаалтай. Энэ тохиолдолд БШУЯ-аас төрийн үйлчилгээний албан хаагч болох СӨБ ба БДБ-ын 40 гаруй мянган багш нарын ажлыг төлөвлөх үлгэрчилсэн журмыг тэдний ажлын гүйцэтгэлийн үнэлгээ ба дүгнэн урамшуулах, хариуцлага тооцох журамтай хамтад нь боловсруулан гаргах шаардлагатай. Учир нь төлөвлөөгүй ажлаар багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэхэд учир дутагдалтай юм.

Багшийн ажлын норм, норматив болон сургалтын төлөвлөгөөтэй уялдуулан сургууль, цэцэрлэгийн бүтэц, орон тооны жишиг нормативыг шинэчлэн батлуулсан байх талаар.

ЗГ-ын 2020-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд тусгагдсан энэ арга хэмжээг хэрэгжүүлэхдээ доор дурьдсан маш олон хүчин зүйлсийг тооцон байж, Төрийн албаны болон Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн НХХЯ, СЯ, ХЗЯ зэрэг бусад салбарын зохицуулалттайгаар шийдвэрлэх талуудын ойлголцол, зөвшилцөл их шаардсан ажил байдаг. Үүнд:

- "Багш" мэргэжлийн онцлог;
- Сургууль, цэцэрлэгийн орон тоо;

- Багшийн ажлын байрны тодорхойлолт: үндсэн чиг үүрэг, гол үйл ажиллагаа, ажлын үүрэг хариуцлага;
- Нэг багшид ирэх ачаалал;
- ЕБС, цэцэрлэгийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнүүд;
- Багш бэлтгэх сургалтын хөтөлбөрүүд;
- Сургууль, цэцэрлэгийн байршил, бүтэц, хэмжээ, хэв шинжийн ялгаатай байдал; хөгжлийн бодлого, стратегитэй холбоотойгоор тэдгээрт оруулах өөрчлөлт шинэчлэлээс улбаалсан багшид тавигдах шинэ шаардлага хэрэгцээнүүд;
- Хүн амын өсөлтийн прогноз;
- Бүс нутгийн хөгжил
- Боловсролын зардлын нийт төсөв, түүнд эзлэх багшийн цалин хөлсний хувь хэмжээ;
- Багшийн кластерийн индикаторууд зэрэг болно.

Эндээс харахад багшийн ажлын норм, норматив болон сургалтын байгууллагын бүтэц, орон тооны асуудал нь эцсийн дүндээ хэдхэн тоогоор илэрхийлэгдэх боловч мөн чанартаа маш нарийн нийлмэл асуудал болох нь харагдаж байна. Тухайлбал, хөдөөгийн сургуулиудад ахлах ангийн сурагчдын сонгон суралцах боломж хязгаарлагдаж, өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй багшийн ажлын норм нормативийг мөрдөхөд цөөхөн хүүхэдтэй сургуульд мэргэжлийн багшийн далд дутагдал үүсгэдэг. Энэ нь улмаар багшийн ачаалал, хувь хүний хөгжил болон сурлагын чанарт сөрөгөөр нөлөөлж буй гол хүчин зүйл болж байгааг анхаарч, багшийн ажлын норм нормативын асуудлыг шийдвэрлэхдээ энд дурьдагдсан асуудлуудын харилцан хамааралд нь явч үзэх шаардлага байна. Жишээ нь хөдөөгийн цөөн хүүхэдтэй сургуульд нэг багш 2-3 хичээл зааж, бүх ангид зориулсан, бүх хичээлийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлж, дүгнэдэг бол хотын олон хүүхэдтэй сургуульд нэг багш нэг хичээлийг нэг ангид заахад норм нь гүйцдэг байх жишээтэй. Энд *багшийн ачаалал, хариуцлага, улмаар хөдөлмөрийн үнэлэмж, өөрийгөө хөгжүүлэх боломжид ямар их тэгш бус байдал байгааг харж болно*. Тэднээс ижил чанар нэхэх бараг боломжгүй нь харагдаж байна.

Мөн дээрх төлөвлөгөөний төсөлд тодорхойлсон *"Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын амжилтад ахиц гарч, хот, хөдөөгийн сурагчдын үнэлгээний гүйцэтгэлийн ялгаа багассан байна"* гэсэн үр дүнд хүрэхийн тулд энэ ялгаа үүсгэж буй гол хүчин зүйл болсон багшийн ачаалал, өөрийгөө хөгжүүлэх хязгаарагдмал нөхцөл, эдгээрийг нөхцөлдүүлсэн сургуулийн байршил, бүтэц, хэмжээ, хэв шинжийг тодорхойлдог сургуулийн зураглал, боловсролын үндэсний хэмжээний цахимжилтын асуудлыг оновчтой шийдвэрлэхгүйгээр энэ ялгааг арилгах бодит боломж үнэхээр хязгаарагдмал юм.

Түүнчлэн багшийн ажлын норм нормативыг шинэчлэн тогтоох зорилтын хүрээнд өгч буй энэхүү зөвлөмжтэй уялдуулан ЗГ-ын 2020-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд тусгагдсан дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх боломжтой. Үүнд.

- Багшийн хөдөлмөрийн онцлог, нөхцөлийг судалж, тэтгэвэр тогтоох насанд өөрчлөлт оруулах боломжтой эсэхийг тогтоож, "хөдөлмөрийн нөхцөл"-өөр тэтгэвэр тогтоох эсэх асуудлыг эцэслэн шийдвэрлэх (ЗГАХТ: Файл 2, Sheet 2-ийн L70),
- Багшийн хөдөлмөрийн үнэлэмжийг бодитой тооцох суурь судалгаа хийж, цалин хөлсний бүтцийг боловсруулж, үр дүнд суурилсан цалин хөлсийг олгох зохицуулалт хийх (ЗГАХТ: Файл 2, Sheet 2-ийн J74, L74)
- Багшийн ажлын гүйцэтгэлд суурилсан ур чадвар, улирлын үр дүнгийн урамшууллыг бий болгох (ЗГАХТ: Файл 2, Sheet 2-ийн E70)

Суурь судалгаанд үндэслэн цалин хөлсний бүтцийг боловсруулж, үр дүнд суурилсан цалин хөлсийг олгох зохицуулалт хийгдсэн байна. Багшийн бодит цалингийн хэмжээ улсын дүнджаас дээш болсон байх талаар

ЗГ-ын 2020-2024 оны арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд тусгагдсан дээрх хүрэх үр дүнгүүдтэй холбоотой цогц арга хэмжээг хэрэгжүүлэхдээ "багш" албан тушаалын ангилал, зэрэглэлийг дээшлүүлэх замаар үндсэн цалинг өндөр тогтоох эсвэл, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, мөнгөн урамшууллын хувь хэмжээг нэмэгдүүлэх арга замууд байж болно. Боломжтой л бол үндсэн цалинг нэмэгдүүлэхийг *гол стратеги* болгон баримтлах нь илүү оновчтой. Ийм стратеги баримталж байж л нийгэм, олон нийтийн анхааралд орж, чадварлаг элсэгчдийг багшийн мэргэжилд татах замаар боловсролын чанарт дорвитой ахиц гаргах хамгийн чухал боломжийг бүрдүүлж чадна. Харин нөгөө арга зам нь сайн ч, муу ч нэгэнт багшлахуйн кластерийн "багшаар ажиллах" үе шат руу орчихсон хүмүүсийн цалин хөлсийг өндөр байлгахад *"туслах" түвшиний стратеги* юм.

Түүнчлэн багшийн ажлын гүйцэтгэлд суурилсан ур чадварын үнэлгээг жил 1-2 удаа хийж, харин мөнгөн урамшууллыг улирлаар бөөнд нь олгохоор журамлавал илүү оновчтой. Ингэх нь багш урамшууллын хэдэн төгрөгийн төлөө бус, хүүхдүүдтэйгээ тулж ажиллах, өөрийнхөө мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд илүү төвлөрөх боломж олгоно. Хэрэв богино хугацаанд хэмжилт, үнэлгээ хийгээд байвал багш ажилдаа төвлөрч чадахгүй, бас менежер ч хүн бүр дээр тооцоо, бүртгэл гаргах гэж нэмэлт ачаалалтай болно.

Энд тооцох ёстой бас нэг чухал зүйл бол багшийн гүйцэтгэлийн үнэлгээ, цалин хөлс, урамшууллын бүртгэл, тооцоолол, тэдгээрийн олголт зэргийг цахимжуулах явдал юм.

ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Нийгмийн даатгалын шинэчлэл хийж, иргэн бүрд суурь тэтгэвэр олгох, хувийн даатгалын үйлчилгээнд хамрагдах боломж бүхий олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжинэ (ЗГҮАХ 2.5.1)", "Нийгмийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны үлдэгдлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ (ЗГҮАХ 2.5.2) ", "Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг инфляц, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ (ЗГҮАХ 2.5.5)" гэсэн зорилтууд нь багшийн насан туршийн амьжиргааны түвшинг хадгалах баталгааг нэмэгдүүлэх, тэтгэвэрт гарсны дараах багшийн амьдралд тус дэм болохын зэрэгцээ үр хүүхдүүддээ энэ хуримтлалаа өвлүүлэх, төгрөг үнэгүйдэж, түүний худалдан авах чадвар буурахаас сэргийлснээр багшийн амьжиргааны түвшин хадгалагдах тус тус ач холбогдолтой.

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн олимпиадаас медаль хүртсэн ерөнхий боловсролын сургуулийн суралцагч, бэлтгэсэн багшийг урамшуулах эрх зүйн орчин бүрдүүлж, хэрэгжүүлэх талаар

ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан энэ зорилт нь багш, сурагчийн нөр их хүчин чармайлт, онцгой амжилтыг үнэлж, урамшуулах үйл ажиллагааг институтчилснаар нарийн мэргэшсэн үндэсний чадварлаг мэргэжилтнүүд бэлтгэх, монголын багш нарын ур чадвар, боловсролын чанарыг олон улсад хүлээн зөвшөөрүүлэх ач холболдолтой. Энэ утгаар нь авч үзвэл багшийн хөдөлмөрийн үнэлэмж, ур чадвар (багшийн ажил)-ын өсөлтийг үнэлэх, урамшуулах гэсэн *ерөнхий нэг зорилтын доор хэрэгжүүлэх тодорхой нэг арга хэмжээ хэлбэрээр төлөвлөвөл илүү зохистой* санагдаж байна. ЗГ-ын арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд дурьдсанаар энэ арга хэмжээг зорилт болгон дэвшүүлэх нь хэр оновчтойд эргэлзэж байна.

Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулж, орон сууцжуулах хөтөлбөрийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн шинэ зохион байгуулалтаар өргөжүүлэн хэрэгжүүлнэ (ЗГҮАХ 3.7.8).

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн хүүхдийн цэцэрлэг, ЕБС-ийн байршил, хэмжээ, хэв шинжийг тооцсон шинэ зураглал (school mapping) хийж, энэ зураглалд үндэслэн дээрх сургалтын байгууллагуудад ажиллах багшийн хэрэгцээ болон тэдний орон сууцны хэрэгцээг тус тус тооцоолж, үндэсний хэмжээний орон сууцжуулах хөтөлбөрт "багш" гэсэн тусгайлсан зорилтод бүлгээр хамрагдаж, хувийн орон сууцтай болсон багшийн уг хөтөлбөрт эзлэх хувийг дорвитой нэмэгдүүлэх боломжтой.

Энэ зорилтыг хэрэгжүүлэхдээ энэхүү судалгааны ажлын хүрээнд багшлахуйн талаарх бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн холбогдох хэсгүүдэд тодорхойлогдсон зорилт, арга хэмжээ бүрд өгөгдсөн санал, зөвлөмжүүдтэй уялдуулж үзэх нь чухал. Тухайлбал, ЗГҮАХ-ийн 6.2.12 зорилт буюу Sheet 1-ийн D45 болон Мастер төлөвлөгөө хэрэгжсэнээр салбарын түвшинд хүрэх 5.6 үр дүнг тодорхойлсон Sheet 11-ийн C26 нүдэнд тус тус маш тодорхой зөвлөмжүүд өгөгдсөн болно.

Сум, орон нутагт ажиллахаар анх удаа очиж байгаа багш, эмч, төрийн албан хаагчдыг орон байраар түр хангах цогц арга хэмжээг төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд авч хэрэгжүүлнэ (ЗГҮАХ 6.2.12).

ЗГ-аас хэрэгжүүлэх орон сууцжуулах хөтөлбөрт багш нар хамрагдаж, хувийн орон сууцтай болохоос гадна дараах хувилбаруудтай байх бодлого баримтлах нь зүйтэй. Тухайлбал,

- a) Сургуулийн хэв шинж, хэмжээнээс хамаарч (ялангуяа сум дундын) томоохон сургуулиудыг хичээлийн болон дотуур байр, багш нарын орон сууц, болон бусад холбогдох байгууламжийн бүрдэлтэйгээр "комплекс буюу кампус" хэлбэрээр байгуулах тохиолдолд багшийн орон сууц сургуулийн өмч байхаар тооцох
- b) Сумын сургуулиудын тухайд, багш нарт зориулсан сургуулийн болон орон нутгийн өмчийн орон сууцтай байхаар тооцох

Дээр дурьдсан 2 тохиолдолд багш нарыг сэлгэн томилж ажиллуулах гол нөхцөл хангагдана. Багш нар өөрийн орон сууц, газар зэрэг *хувийн өмчөө дагаж, нэг сургуульд насаараа "хадагдаж" ажиллах нь сургуулийн хөгжил болон боловсролын чанарт дамаар сөрөг нөлөө үзүүлдэг.* Иймд багш нар тодорхой хугацаагаар сургуулиудад сэлгэн ажилладаг байх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай. Энэ тохиолдолд төр өөрийн өмчийн тохилог орон сууцуудтай байх хэрэгтэй. Шаардлагатай гэж үзвэл, холбогдох судалгааг хийж багш нар сэлгэн ажилладаг байхаар эрх зүйн зохицуулалт хийж болох юм. Боловсролын удирдлагын төвлөрлийг орон нутагт шилжүүлж сааруулсан олон улс оронд боловсролын яам зөвхөн хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн зохицуулалтаа авч үлдсэн байдаг нь цаанаа их учиртай байдаг. Энэ нь зөвхөн боловсролын үйлчилгээний чанарт төдийгүй, хөдөөд залуу багш нарыг ажиллуулах, тэд гэр бүл зохиох, цаашлаад хүн ам зүйн удмын асуудалд ч эерэгээр нөлөөлөх ач холбогдолтой.

Багш, сурагч, сургуулийн ажилтнуудын эрүүл мэндийн эрсдэлийг тодорхойлж, сурагчийн сургууль завсардалтын эрсдэлийг тооцоолно (ЗГҮАХ 1.1.15).

ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эрүүл мэндийн судалгаанд үндэслэн багш, суралцагчийн хичээл сургалтын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн зохицуулалт хийсэн байх чиглэлээр дэвшүүлсэн энэ зорилт нь зөвхөн халдварт өвчин төдийгүй бусад төрлийн гамшигийн үед боловсролын салбарын хүний нөөцөд учирч болох эрсдэлээс сэргийлсэн эрсдэлийн үеийн менежментийг бий болгож, төлөвшүүлэх гэсэн өргөн утгаар нь харж, ямар ч нөхцөлд боловсролын үйл ажиллагаа, хэвийн тасралтгүй, тогтвортой явагдах боломж, нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.

4.2.7. Багш ба ажиллах орчин нөхцөлийн өөрчлөлт

Яслийн үндэсний тогтолцоог сэргээж 1-2 нас, хүүхэд харах үйлчилгээнд 2-3 насны хүүхдийг хамруулж, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ (ЗГҮАХ 2.3.1).

ЗГҮАХ-ийн энэ зорилтыг хэрэгжүүлэхдээ хүүхдийн хөгжлийн өвөрмөц хэрэгцээнд нийцүүлэн боловсролын салбарын үйлчилгээнд шинэлэг бие даасан хэлбэрийг институтчилах бодлого баримтлавал оновчтой болов уу. Гэхдээ ийм бодлого нь алсдаа үр өгөөж, явц муутай, гэр бүл болон нийгэмд сөрөг үр дагавар авчиргах эрсдэл өндөртэй байж болох юм. Өмнөх үеийн яслийн тогтолцоо бол насанд хүрсэн хүн бүр ажил хөдөлмөр эрхэлдэг, нийгэм сэтгэл зүйн стресс багатай, байгалийн төдийгүй нийгмийн хүрээлэл орчин

эрүүл, өвчлөл бага байсан учраас энэ тогтолцоо ажиллах боломжтой байсан. Өнөөдрийн нийгэм тийм биш шүү. Уг нь хүүхэд төрүүлсэн эхчүүдийн нийгмийн даатгалыг нь төрөөс хариуцдаг бодлогоо үргэлжлүүлж, олгож буй тэтгэмжийн хэмжээг боломжоороо үе шаттай нэмэгдүүлээд явбал тэд хүүхдээ 3 нас хүртэл нь өөрсдөө асран хүмүүжүүлэх боломж бүрдэнэ. Тэгснээр хүүхдийн бие бялдар, оюун ухаан, хэл яриа зэрэг бүх талын цогц хөгжилд илүү тустай гэж бодож байна. Яслид бол олон хүүхэд байх учир асаргаа нь голчлох байхдаа. Учир нь эхчүүд 3 нас хүртэл нь зөвхөн өөрийнхөө л балчир хүүхэд болон бусад ах, эгчтэй нь ажиллах нь хүүхдүүдийн хөгжилд үнэхээр ач тустай төдийгүй, эцгийн хариуцлагыг өндөржүүлж, гэр бүлийн хөгжилд бас эерэг нөлөө үзүүлнэ. Харин нөгөө талд нь эрчүүд, эмэгтэйчүүдийг гэр бүл төлөвлөлтөд сургах, эцгүүдийг ажил хөдөлмөрөөр хангах, эхчүүдийн ажлын байрыг хадгалах, тэдний нийгмийн амьдралд боломжоороо оролцох сонирхол татахуйц олон төрлийн янз бүрийн арга хэлбэрийн үйл ажиллагааг бий болгох, мөн эцэг, эхэд зориулсан хүүхдээ хүмүүжүүлж, сургах, тэднийг дэмжихэд чиглэсэн олон талын агуулга бүхий зөвлөгөө, сургалтуудыг үнэ төлбөргүй явуулдаг болвол гэр бүлийн төдийгүй нийгмийн хөгжилд маш олон эерэг өөрчлөлт, хүүхдэд хандах шинэ хандлагыг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой байж болох юм.

Хүүхэд харах үйлчилгээ, яслид ажиллах хүний нөөцийг бэлтгэх талаар

ЗГ-ын арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд тусгагдсан энэ арга хэмжээг 3-5 настанд зориулсан үйлчилгээ гэж ойлгож байна. Цэцэрлэг хүрэлцээгүй байгаа тохиолдолд хэдэн жилийн өмнөөс бий болгосон энэ төрлийн үйлчилгээ улам чанаржуулахад анхаарч, дэмжин ажиллах нь чухал юм. Ясли болон хүүхэд харах үйлчилгээг СӨБ-ын асуудалд хамруулан авч үзэж институтчилэх бодлого баримтлан ирэх 5 жилд товлосон тоо (нийт 720 яслийн ажилтан, 420 хүүхэд харагч)-ны хүмүүсийг бэлтгэхдээ эдгээр асуудлыг салбар хоорондын зохицуулалттай бие даасан дэд тогтолцоо талаас нь хандаж, үйлчилгээнд тавигдах стандартууд, энэ салбарт ажиллах хүний нөөцийг бэлтгэх тусгайлсан сургалтын хөтөлбөрүүдтэй болж, чадварлаг хүний нөөцөөр тогтвортой, тасралтгүй хангаж байх нээлттэй тогтолцооны менежментийг бий болгох бодлого баримтлах нь зүйтэй.

СӨБ-д хамрагдах хүүхдийн насыг 3-5 болгож, 5 настай хүүхэд бүрийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана (ЗГҮАХ 2.3.2)

Энэ зорилтыг хэрэгжүүлэхэд БУМС-ийн өгөгдлийг ашиглан СӨБ ба бага боловсролын залгамж холбоог найдвартай хангах түвшинд зорилтод өрх бүрийн 5 настанг сургуульд бэлтгэх чиглэлээр тэдний оршин суугаа газар, хөгжлийн тусгай хэрэгцээг тооцсон сургалтын хөтөлбөрүүд боловсруулж, багш нарыг тусгайлсан модулуудаар бэлтгэн чадавхижуулж, тэдэнд хүрч ажиллах арга хэлбэрийг оновчлох хэрэгтэй.

Энэ зорилтыг салбарын дунд хугацааны төлөвлөгөөнд нарийвчлан задалж, хүрэх үр дүнгүүдийг харилцан уялдаа холбоотойгоор, хэмжиж, бодитоор хэрэгжүүлж болохоор тодорхой томъёолж, бие даасан төсөл, хөтөлбөрүүд хэлбэрээр багшлахуйн кластерийн холбогдох код бүхий агуулгын хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатай.

Ингэхдээ энэхүү судалгааны ажлын хүрээнд багшлахуйн талаарх бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн холбогдох хэсгүүдэд тодорхойлогдсон зорилт, арга хэмжээ бүрд өгөгдсөн санал, зөвлөмжүүдийг тусгах боломжтой.

- ***273 шинэ цэцэрлэг ашиглалтад оруулах (ЗГҮАХ 2.3.9.1);***
- ***200 шинэ сургууль ашиглалтад оруулах (ЗГҮАХ 2.3.9.1);***

Шинэ сургууль, цэцэрлэгүүд барьж, тэдгээрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх нь СӨБ болон БДБ-ын үйлчилгээний инклюдив ба үл алагчилах (equity) байдлыг хангах, нэг багшид ногдох хүүхдийн тоог норм нормативт дөхүүлэх, хүргэх арга хэмжээ нь багш мэргэжилтний хэрэгцээг тооцоолох, багш бэлтгэх сургуулиудын сургалтын хөтөлбөрийн төрөл, ангилал болон элсэгчдийн тоог төлөвлөх; багшийн ажлын ачааллын норм нормативийг мөрдөх

боломж олгох болон цалин хөлс, урамшууллын ангилал, төрлүүдийг тогтвортой байлгаж, багшийг үндсэн ажилд нь төвлөрүүлэх замаар сургалтын чанарыг дээшлүүлэх; багшийн ажлын орчин нөхцөлийг сайжруулах; сургууль, цэцэрлэгийн орчинд үүсч болох хүүхдийн болзошгүй аюул ослоос үүдэлтэй хариуцлагаас сэргийлэх зэрэг олон асуудалд дам нөлөөлөх чухал ач холбогдолтой.

Шинэ сургуулиуд барихдаа дараах 2 зүйлийн боломжийг тооцож үзэж болох юм. Үүнд:

- Ирэх 3-4 жилд сургуулийн шинэ зураглалын ТЭЗҮ боловсруулж амжихаас бусад үйл ажиллагааг эхлүүлж амжихгүй байх. Иймд шинээр барих сургуулиудын ихэнх нь төв суурин газар баригдах магадлал өндөртэй тул ийм газруудад баригдах сургуулийн хэмжээ, бүтэц, хэв шинжийн онцлогийг бүрэн тусгасан сургуулийн барилга, байгууламжийн стандартыг шинэчлэн боловсруулж мөрдүүлж эхлэх. Тухайлбал, боловсролын цахим шилжилтийн шаардлагыг хангасан хичээлийн болон дотуур байр, багшийн орон сууц, биеийн тамир, урлагийн байгууламж бүхий сургуулийн кампус, ахлах сургууль гэх мэт
- Сум дундын сургуулийн барилгын стандартыг боловсруулж турших

4.2.8. Түншлэл-Багшийн хөгжил

Багш, сурагч, сургуулийн ажилтнуудын эрүүл мэндийн эрсдэлийг тодорхойлж, сурагчийн сургууль завсардалтын эрсдэлийг тооцоолно (ЗГҮАХ 1.1.15).

Мөн ЗГ-ын арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд тусгагдсан "Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-6 төслийг хэрэгжилтийг дэмжих (МУ-ыг 2021-2025 хөгжүүлэх үндсэн чиглэл: Файл 2, Sheet7-ийн С30)" зорилт нь бүх нийтийн эрүүл мэндийн боловсрол, түүний дотор ЕБС-ийн сурагчдын эрүүл мэндийн сургалтын чанар, үр өгөөжийг нэмэгдүүлэх, багшийг мэргэшүүлэх, сургуульд эрүүл ахуйн стандартыг мөрдөх, үдийн хоолны аюулгүй байдлыг хангах, сургуулийн орчинд гарч болзошгүй аюул ослоос сэргийлэх, хүчирхийлэл, дээрэлхэх явдлаас үүдэлтэй сэтгэц, бие махбодийн өвчлөлөөс сэргийлэх, дархлаажилтыг явуулах, сургууль, цэцэрлэгт хөгжлийн тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн сурах орчныг бүрдүүлэх зэрэг олон талбарт хамтран ажиллах, түншлэх боломжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

2.6. Үндэсний бахархал, монгол өв соёлыг өвлүүлж, олон улсын стандарт шаардлагад нийцсэн дараах барилга, байгууламжийг барьж ашиглалтад оруулна: 2.6.1.1.чингэс хаан, хаад язгууртны музейн шинэ барилга, бусад түүхэн газар нутагт баригдаж байгаацогцолборууд, байгалийн түүхийн музейн шинэ барилга; гэх мэт 2.6.1.3; 2.6.1.4; 2.6.1.5; 2.6.1.6; 2.6.1.7;

Эдгээр зорилтууд нь нийгмийн салбар хоорондын тухайлбал, соёл, урлаг, шинжлэх ухаан, эрүүл мэндийн салбартай хамтран сургууль, багш нарын хөгжлийг дэмжсэн түншлэлийг хөгжүүлэх боломж олгож байна. Тухайлбал, Монголын нэгдмэл үнэт зүйлийн өвийг суралцагчдад өвлүүлэн эзэмшүүлж, эх орон, ард түмнээрээ бахархах, тэднийг хүндлэх сэтгэлийг тэтгэхэд одоо байгаа болон шинээр байгуулагдах түүх, дурсгалт газрын төрөл бүрийн музей, театр, номын сан, лаборатор зэрэг соёл урлаг, шинжлэх ухааны байгууллагуудын үзмэр, үзвэр, үйл ажиллагаатай уялдуулж, биет болон цахим хэлбэрийн хамтын ажиллагааг хөгжүүлэх нь багшид үйл ажиллагааны шинэ талбарт ажиллах боломж олгох ач холбогдолтой юм. .

Боловсролын салбарыг хувирган өөрчлөлтөд чухал нөлөө үзүүлэх ийм шинэ төрлийн түншлэл нь сургалтын байгууллагууд болон багшийн үйл ажиллагааны талбар, орон зайг үлэмж тэлэх, суралцахуй ба багшлахуйн арга зүйн шинэчлэлийг шаардсан, хамтын ажиллагаа, түншлэлийн соёлд суралцуулах, хүн амын бүх насныханы насан туршийн боловсролыг дэмжих, бүх нийтийн оролцоог хангах, үндэсний нэгдмэл үнэт зүйлээ өвлүүлэх, үндсэн хичээлүүд төдийгүй сургалтыг дэмжих үйл ажиллагааны үр өгөөжийг эрс

нэмэгдүүлэх энэ боломжийг бид бүрэн дүүрэн ашиглах нь чухал юм. Товчоор хэлбэл, сургууль, багш нар зөвхөн сургуулийн болон анги, лабораторын орчинд сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэж, туршилт явуулдаг явцуу хүрэнээс тэднийг чөлөөлж, байгаль, ахуй амьдрал, үйлдвэрлэл практикийн өргөн агуулга, баялаг хэрэглэгдэхүүнтэйгээр сургалтыг явуулах боломжийг олгож байна.

Энэ боломжийг бүрэн дүүрэн ашиглахын тулд БШУЯ-аас боловсролын цахимжилтийн зорилтыг амжилттай хэрэгжүүлэхийн зэрэгцээ бусад салбар, байгууллагуудтай хамтран ажиллах, түншлэх үйл ажиллагааны болон санхүүгийн, хяналт-шинжилгээ үнэлгээний болон хууль эрх зүйн тогтолцоондоо энэ шинэ хэлбэрийн үйл ажиллагааг бүрэн интеграцчилж, хөгжлийн тогтвортой байдлыг хангах оновчтой зохицуулалтыг хийх шаардлагатай.

4.3.Боловсролын салбарт хийгдсэн судалгааны магадлан шинжилгээний үр дүн

Бодлого, төлөвлөлтийн баримт бичигт хийгдсэн магадлан шинжилгээнээс энэхүү боловсролын салбарт хийгдсэн судалгааны тайлангийн магадлан шинжилгээ нь дараах онцлог ялгаатай болно. Үүнд:

- Нэгэнт хийгдэж дууссан судалгааны тайланд зөвлөмж бичих шаардлагагүй гэж үзсэн бөгөөд цөөн тохиолдолд холбогдох тодруулга, тэмдэглэл хийсэн.
- Хэдийгээр тухай судалгааны нэгж объектын томъёололд Багшлахуйн кластерийн индикатор шууд илэрхийлэгдсэн бол “шууд, эсвэл дам хамааралтай” гэсэн үндэслэлээр, харин шууд илэрхийлэгдээгүй бол “тооцвол зохино” гэсэн үндэслэлээр БК-ийн харгалзах кодыг оруулсан.

Судалгааны нэгж объектын томъёолол, агуулгын багтаамжаас хамаарч магадлан шинжилгээний үр дүн харилцан адилгүй байгааг дараах жишээ (санамсаргүй байдлаар сонгосон болно)-гээр харуулж болно.

Жишээ 1. Тодорхой нэгж асуудалд төвлөрсөн нэгж объект

<i>Судалгааны нэгж объект</i>	<i>Магадлан шинжилгээ</i>
3в. Боловсролын салбар дахь багш, ажилтны жендерийн зохистой харьцааг багш бэлтгэх сургалтаас эхлүүлэн мөрдөх (2. БСМТайлан-дэд салбар дамнах sheet-ийн E15 нүд)	{БК1.2.2}; {БК1.3}; Эрэгтэй элсэгчийг татах бодлого маш чухал байх

Энэ асуудал нь Багшлахуйн кластерийн “БК1.2.2. Элсэгчдийн тоо”, “БК1.3. Хүйс, жендерийн асуудлууд”-тай холбоотой, шууд хамааралтай асуудал гэж тодорхойлсон.

Жишээ 2. Тодорхой нэгж асуудалд төвлөрсөн, залгамж холбоо олонтой нэгж объект

<i>Судалгааны нэгж объект</i>	<i>Магадлан шинжилгээ</i>
1.4.2 Орон нутгийн дэмжлэг, холбогдох сургалтын тусламжтайгаар “сургууль бол мэргэжилтнүүдийн хамтран суралцах талбар юм” гэсэн зарчмыг түгээх, ТӨ-хх, ХД-хх (3. Бодлогын шинжилгээ-2019 sheet-ийн D21 нүд)	{БК4.1.1}; {БК4.1.2}; {БК4.1.4}; {БК4.1.5}; {БК4.1.6}; {БК4.1.7}; {БК4.2.2}; {БК4.2.3}; {БК4.2.4}; {БК4.2.5}; {БК4.2.6};

“Сургууль бол мэргэжилтнүүдийн хамтран суралцах талбар юм” гэсэн зарчим нь нэг талаас “тодорхой нэгж асуудал” мэт боловч Багшлахуйн кластерийн “БК4.1. Мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах тогтолцоо”, “БК4.2. Насан туршийн суралцахуйг дэмжих арга механизм” гэсэн дэд шалгуурыг бараг бүхлээр хамарсан олон индикаторын залгамж холбоонд авч үзэх (“тооцвол зохино”) асуудал юм.

Жишээ 3. Өргөн хүрээг хамарсан ерөнхий нэгж объект

<i>Судалгааны нэгж объект</i>	<i>Магадлан шинжилгээ</i>

1. Багшийн хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулан баталж, түүнд суурилсан багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, тэдний тасралтгүй хөгжлийг хангах, багшийн хангалтыг сайжруулах эрх зүйн нэгдсэн зохицуулалттай болж тогтвортой мөрдөх шаардлага байна. (2. БСМТайлан-дэд салбар дамнах sheet-ийн E12 нүд)	{БК2.1.1}; {БК2.1.2}; {БК2.1.3}; {БК2.1.4}; {БК2.4.1}; {БК2.4.2}; {БК2.4.3}; {БК2.5.1}; {БК2.5.3}; {БК3.2.5}; {БК3.2.7}; {БК4.1.1}; {БК4.1.2}; {БК4.1.3}; {БК4.1.4}; {БК4.1.5}; {БК4.1.6}; {БК4.2.1}; {БК4.2.2}; {БК4.2.3}; {БК4.2.4}; {БК4.2.5}; {БК4.2.6}; {БК4.5.1}; {БК4.5.2}; {БК4.5.3}; {БК4.5.4}; {БК4.6.1}; {БК4.6.2}; {БК4.6.3}; {БК4.6.9}; {БК4.7.1}; {БК4.7.3}; {БК4.7.5}; {БК4.7.6}; {БК5.1.2}; Кластерийн бараг бүх зүйлийг хамарсан маш том зөвлөмж байна.
---	--

Багш бэлтгэхээс эхлээд багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн асуудлыг багтаасан “Багшийн хөгжлийн үзэл баримтлал” боловсруулж батлах, тогтвортой мөрдөх нь Багшлахуйн кластерийг бараг бүхэлд нь хамарч байна (буюу судлаачийн зүгээс “тооцвол зохино” гэж үзсэн нийт 36 индикаторыг тодорхойлсон).

Жишээ 4. Өргөн хүрээг хамарсан ерөнхий нэгж объект

<i>Судалгааны нэгж объект</i>	<i>Магадлан шинжилгээ</i>
1.2.3 Боловсролын бүх түвшний багш, ажилтан, удирдах ажилтны мэдлэг, чадвар, хандлагыг системтэйгээр сайжруулах, ТӨ-х, ХУ-х (3. Бодлогын шинжилгээ-2019 sheet-ийн D18 нүд)	{БК4.1.1}; {БК4.1.2}; {БК4.1.3}; {БК4.1.4}; {БК4.1.5}; {БК4.1.6}; {БК4.1.7}; {БК4.2.1}; {БК4.2.2}; {БК4.2.3}; {БК4.2.4}; {БК4.2.5}; {БК4.2.6}; {БК4.3.1}; {БК4.3.2}; {БК4.3.3}; {БК4.3.4}; {БК4.3.5}; {БК4.3.6}; {БК4.3.7};

Боловсролын “бүх түвшин”-ий гэсэн нь энэхүү судалгааны объектын өргөн хүрээг хамарсан байгааг илтгэхийн зэрэгцээ “мэдлэг, чадвар, хандлага”-ыг тусгайлан томъёолоогүй нь Багшлахуйн кластерийн “БК4. Багшаар ажиллах” үе шатыг хамарсан гэж үзэх үндэслэл болсон (буюу судлаачийн зүгээс “тооцвол зохино” гэж үзсэн нийт 20 индикаторыг тодорхойлсон).

Иймээс бид өмнөх бүлэгт “... бидний судалгааны энэ үр дүн нь 2018-2020 онд хийгдсэн судалгаануудад Багшлахуйн кластерийн тухайн индикатораар тодорхойлогдох асуудал “бүрэн тусгагдсан” гэдгийг илэрхийлэхгүй бөгөөд харин цаашид боловсролын салбарын судалгаанд Багшлахуйтай холбоотой асуудлыг авч үзэхдээ энэхүү Багшлахуйн кластерийг судалгааны үндсэн дээр боловсронгуй болгож хэрэглэх шаардлагатайг илэрхийлнэ.” гэж үзсэн.

Бидний энэхүү судалгааны объект болсон судалгааны нийтлэг тал нь Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө (БСДХХТ буюу мастер төлөвлөгөө) боловсруулахад нотолгоо үндэслэл гаргахад оршиж байсан гэж үзэж болно. Гэвч Бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн магадлан шинжилгээ болон Судалгааны тайлангийн магадлан шинжилгээний зарим үр дүнгийн зөрөөтэй байдал (Хүснэгт 15)-аас харвал цаашид “дунд, урт хугацааны бодлого, төлөвлөлтийн нотолгоо, үндэслэл тодорхойлох” төрлийн судалгаа, түүнээс гарах зөвлөмжид тавигдах шаардлагыг анхаарч үзэх шаардлагатай байна.

Хүснэгт 15. “БК4.4. Ялгаатай зорилтод бүлгүүдэд багшлах мэдлэг, ур чадварт тавигдах шалгуур, индикаторууд”-ийн хувьд магадлан шинжилгээний дүнгийн харьцуулалт

БК-ийн индикатор	Бодлого, төлөвлөлтийн баримт бичиг	Судалгааны тайлан
------------------	------------------------------------	-------------------

	1. ЗГҮАХ-2020-2024	2. ЗГАХХ-2020-2024	3.ҮЧ-21-25-Зорилт-Хүрэх үр дүн	7. ҮЧ-21-25-Санхүүжилтгүй төсөл	11. МТ-21-30-Зорилт-Үр дүн	12. МТ-21-25-Хөтөлбөр-ҮА	Нийлбэр	1. БСМТайлан-дэд салбар	2. БСМТайлан-дэд салбар дамнах	3. Бодлогын шинжилгээ-2019	4. МТ-өмнө-СӨБ	5. МТ-өмнө-БДБ	6. МТ-өмнө-Дээд	7. МТ-үнэлгээ-Роберт	Нийлбэр
БК4.4.1. Ердийн хөтөлбөрөөр сургах	4	10	0	0	1	1	16	0	0	0	0	0	0	0	0
БК4.4.2. Мэргэжлийн чиг баримжаа эзэмшүүлэх хөтөлбөрөөр сургах	5	11	0	0	1	1	18	0	0	0	0	0	0	0	0
БК4.4.3. Гүнзгийрүүлэн сонгон суралцах хөтөлбөрөөр сургах	4	10	0	0	1	1	16	0	0	0	0	0	0	0	0
БК4.4.4. Хөгжлийн тусгай хэрэгцээтэй хүүхэдэд багшлах	4	13	0	1	2	1	21	0	0	1	0	1	0	0	2
БК4.4.5. Малчдын болон эцэг эх, гэр бүлээсээ хол амьдарч, суралцаж буй хүүхдэд багшлах	4	10	0	0	3	2	19	0	0	2	0	0	0	0	2
БК4.4.6. Шашны сургуулийн хүүхэдэд багшлах	4	5	0	0	1	1	11	0	0	0	0	1	0	0	1
БК4.4.7. Гадаадад амьдарч, суралцаж буй хүүхэд багшлах	3	5	0	0	1	1	10	0	0	1	0	0	0	0	1
БК4.4.8. Дүйцсэн хөтөлбөрөөр сургах г.м.	3	8	0	0	2	1	14	0	0	3	0	0	0	0	3

Мөн “БК4.3. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх мэдлэг, ур чадварын хангалт (багшийн стандарт)” дэд шалгуурын хувьд Бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн магадлан шинжилгээ болон Судалгааны тайлангийн магадлан шинжилгээний зарим үр дүнд зөрөөтэй байдал ажиглагдаж байна (эксэлийн файл 2 болон 3-ийг үзнэ үү).

Үүнээс гадна бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тодорхойлсон зорилго, зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь салбарын судалгааны үр дүн, бодит нотолгоонд суурилсан, хэрэгжихүйц эсэхийг, мөн хоорондоо уялдаатай эсэхийг иж бүрэн тооцдог байхад анхаарах шаардлагатай байна. Дашрамд дурьдахад БСДХХТ-нд үнэлгээ хийсэн Роберт Уэстийн тайланд мастер төлөвлөгөөний төсөлд тодорхойлсон бодлого, стратеги, үйл ажиллагааны үндэслэл болон тэдгээрийн хоорондох уялдаа холбоог нэлээд нарийн тодорхойлж, зохих зөвлөмжүүдийг өгсөн байсан.

ДҮГНЭЛТ, ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

Дүгнэлт

1. ЗГ, БСШУЯ-ны түвшний боловсролын салбарын хөгжлийн урт, дунд хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичигт багшлах үйлийн хөгжлийн асуудлууд хэрхэн туссан болон цаашид анхаарвал зохих асуудлыг илрүүлэхийн тулд боловсролын менежментэд харьцангуй шинэ тутам хэрэглэгдэж байгаа кластер арга хандлагын асуудлыг салбартаа анх удаа хөндөж, “Багшлахуйн кластер тогтолцоо”-ны нэгэн хувилбарыг боловсруулж, шинжилгээнийхээ шалгуур, индикаторууд болгон хэрэглэв. (Хавсралт 1)
2. Энэхүү судалгааны тоон шинжилгээнд баримт бичгийн тоо, Excel Sheet-ийн тоо, судалгааны “нэгж объект”, багшлахуйн кластерийн шалгуур, индикатор, агуулгын илэрц гэсэн үндсэн хэмжигдэхүүнүүдийг сонгож, тэдгээрийн хэмжилтээр нийт 5345 үзүүлэлтийг боловсруулж гаргав (Хүснэгт 16). Тоон шинжилгээний үр дүнгүүд болох эдгээр үзүүлэлтүүд нь энэхүү судалгааны аль ч түвшинд өгөгдсөн санал зөвлөмж, дүгнэлтийн нотолгоо болохын зэрэгцээ тус судалгааны агуулгад хамаарах бусад асуудалд үндэслэл, нотолгоо болгон ашиглах боломжтой.

Хүснэгт 16. Тоон шинжилгээний хэмжигдэхүүнүүд ба тэдгээрийн үзүүлэлтүүд

Хэмжигдэхүүн		ЗГ-ын хөтөлбөр, төлөвлөгөө	Судалгааны зөвлөмжүүд	Нийт
Баримт бичгийн тоо		5	6	11
Sheet-ний тоо		21	7	28
“Нэгж объект”-ын тоо		957	463	1420
Үүнээс	Шууд хамааралтай	120	125	245
	Дам хамааралтай	172	50	222
	Хамааралгүй	665	288	953
Шинжилгээ хийгдсэн “Нэгж объект”-ын тоо		208	173	381
Багшлахуйн кластерийн шалгуур, индикатор, агуулгын илэрц				
Үүнээс	Ерөнхий шалгуур	7		143
	Дэд шалгуур	33		
	Индикатор	103		
Агуулгын илэрцийн тоо (давхардсан тоогоор)		1147	804	1951

3. Багшлахуйн кластерийн үндсэн шалгуураар авч үзэхэд Бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн магадлан шинжилгээний үр дүн (илэрц) нь түүнийг боловсруулах нотолгоо, үндэслэлийг гаргах зорилгоор хийсэн судалгааны тайлангийн магадлан шинжилгээний үр дүн (илэрц)-тэй зохицож байх (Хүснэгт 17-ийн А) боловч дэд шалгуураар авч үзвэл зөрөөтэй (Хүснэгт 15, Хүснэгт 17-ийн Б) байдал ажиглагдаж байна.

Хүснэгт 17. Магадлан шинжилгээний дүнгийн харьцуулалт

А. Багшлахуйн кластерийн ерөнхий 7 шалгуураар

	Бодлого, төлөвлөлтийн баримт бичиг		Судалгааны тайлан	
БК0. Мэргэжлийн чиг баримжаа өгөх	9	0.8%	10	1.2%
БК1. Багш бэлтгэх сургуульд элсүүлэх	29	2.5%	45	5.6%
БК2. Багш бэлтгэх	98	8.5%	115	14.3%
БК3. Багшийг ажилд авах	47	4.1%	49	6.1%
БК4. Багшаар ажиллах	928	80.9%	575	71.5%
БК5. Тэтгэвэр тогтоож, ажлаас чөлөөлөх	22	1.9%	8	1.0%
БК6. Зөвлөгөө, туслалцаа авах	14	1.2%	2	0.2%

Нийт	1147	100%	804	100%
------	------	------	-----	------

Б. “БК4. Багшаар ажиллах”-ын 7 дэд шалгуураар

	Бодлого, төлөвлөлтийн баримт бичиг		Судалгааны тайлан	
БК4.1. Мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах тогтолцоо	145	15.6%	141	24.5%
БК4.2. Насан туршийн суралцахуйг дэмжих арга механизм	113	12.2%	92	16.0%
БК4.3. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх мэдлэг, ур чадварын хангалт (багшийн стандарт)	197	21.2%	79	13.7%
БК4.4. Ялгаатай зорилгод бүлгүүдэд багшлах мэдлэг, ур чадварт тавигдах шалгуур, индикаторууд	<u>125</u>	<u>13.5%</u>	<u>9</u>	<u>1.6%</u>
БК4.5. Багш бэлтгэх, БМТХ-ийг хангах үйл явцын төлөвлөлт, үнэлгээ ба баталгаажилт	<u>69</u>	<u>7.4%</u>	<u>90</u>	<u>15.7%</u>
БК4.6. Багшийг тогтоон барих, багшийн хангалт	181	19.5%	120	20.9%
БК4.7. Цалин хөлс, нийгмийн халамж хамгаалал, амьжиргааны түвшин	98	10.6%	44	7.7%
Нийт	928	100%	575	100%

Иймд цаашид нэг талаас, “дунд, урт хугацааны бодлого, төлөвлөлтийн нотолгоо, үндэслэл тодорхойлох” төрлийн судалгаа, түүнээс гарах зөвлөмжид тавигдах шаардлагыг анхаарч үзэх, нөгөө талаас бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тодорхойлсон зорилго, зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь салбарын судалгааны үр дүн, бодит нотолгоонд суурилсан, хэрэгжихүйц, мөн хоорондоо уялдаа холбоотой эсэхийг иж бүрэн тооцдог байхад анхаарах шаардлагатай байна.

Түүнчлэн Багшлахуйн кластерийн 3 үе шат, 4 төлөв байдал нь үргэлжлэх хугацаа, хамрах хүрээ, оролцох субъект, эрх зүйн зохицуулалт зэрэг олон шинжээр бие биеэс ялгагдах өөр өөр агуулгатай тул тэдгээрийн “харьцааны жин”-г судалгааны арга зүйн үндэслэлтэйгээр тодорхойлохгүйгээр энэхүү судалгааны үр дүнд гарсан илэрцийг “хангалттай/хангалтгүй” зэргээр хатуу дүгнэн үзэх боломжгүй юм. Гэвч “гараа сайн бол бариа сайн”, “эх нь булингартай бол сүүл нь булангартай” гэсэн ардын мэргэн үгээ бодоход “БК1. Багш бэлтгэх сургуульд элсүүлэх” төлөв, багшаар ажиллах (25-35 орчим жил)-тай харьцуулахад богино хугацаа (4 жил)-нд үргэлжилдэг ч “БК2. Багш бэлтгэх” үе шатны илэрцүүд цөөн байгаа тул эдгээрт хамаарах бодлого, төлөвлөлтийн асуудлыг анхаарч үзэх шаардлагатай байна.

4. Судалгааны үр дүнгээс харахад СӨБ ба БДБ-ын түвшин хоорондын хоорондын уялдаа холбоог хангах, сургалт төдийгүй боловсролын бусад үйл ажиллагааг цахимжуулах, монгол үндэсний нэгдмэл үнэт зүйлийг сургалтын хөтөлбөрт тусгах, байгууллагын болон багш, сурагчдын үнэлгээний тогтолцоог хооронд нь нийцүүлэх, багшийн хөгжилд илүү анхаарал хандуулах зэрэг давуу талууд байгааг тэмдэглэх нь зүйтэй.
5. Монгол Улсын Засгийн газар, БШУЯ-аас 2020 онд боловсруулан баталгаажуулсан боловсролын салбарын хөгжлийн урт, дунд хугацааны бодлого болон стратегийн төлөвлөгөөнүүд нь Монгол Улсын хөгжлийн “Алсын хараа-2030” батлагдсаны дараа хийгдэж байгаагаараа мөн 2018 оноос хойш хийгдсэн томоохон судалгаа, тэдгээрийн явцын болон үр дүнгийн тайлангийн олон түвшний олон талт хувь нийлүүлэгчдийн хэлэлцүүлэгээр дамжин нэг цаг хугацааны доор багц байдлаар хийгдсэн гэдгээрээ өмнөх жилүүдийн энэ төрлийн баримт бичгүүдээс ялгарах онцлогтой юм.

6. Энэ онцлог нь Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх зорилтуудыг тодорхойлох, салбар дамнасан үндсэн шийдлүүд бүхий суурь зохицуулалттай төлөвлөлт, хэрэгжилтийн менежмент, хяналт-шинжилгээ, үнэлгээний механизмыг ажиллуулах зэрэг давуу боломжуудыг салбарт олгож байна. Гэвч нэг талаас, боловсролын салбарт хийгдсэн судалгаануудын үр дүнгүүд нөгөө талаас, үндэсний хэмжээнд Үндэстэн бүхлээрээ ажиллах арга хандлага (Whole Institution approach)-ыг нэвтрүүлж буй хүчин чармайлтын таатай нөхцөлд боловсруулж батлуулсан, баглуулах гэж буй боловсролын салбарын хөгжлийн урт ба дунд хугацааны бодлого, төлөвлөгөөний чанар, нийц нь хангалттай сайн биш байна. Үүний шалтгааныг стратегийн төлөвлөлтийн арга зүйг мөн чанараар хэрэглээгүй явдал хэмээн үзэж болно. Энэ дүгнэлтийг дараах зарим баримтаар нотолж болно. Үүнд:

6.1.“Алсын хараа-2030” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого-д салбарынхаа тэргүүлэх чиглэл, бодлого, зорилт, үйл ажиллагааг бусад салбарынхтай холбож, боловсролын салбарыг өөрийн дотоод хөгжлийн механизмыг агуулсан суурь шийдлүүд бүхий иж бүрэн тэргүүлэх чиглэлүүдэд зангидаагүй байна. Товчоор хэлбэл, Боловсролын хөгжлийг илүү өргөн цар хүрээнд илүү алсад харах тал дээр учир дутагдалтай байна. Өөрөөр хэлбэл, салбартаа илүү төвлөрсөн, гадаад хүчин зүйлсийг сул тооцсон байна.

6.2.Боловсролын дунд хугацааны төлөвлөгөө (2020-2025)-д тэргүүлэх чиглэл ялгагдаагүй, зорилтыг Алсын хараа-2050-ын агуулгад бүрэн нийцүүлээгүй, хүрэх үр дүн, хөтөлбөр, үйл ажиллагаануудын эрэмбэ зарим тохиолдолд алдагдсан, агуулга нь бүрэн бус байна.

6.3.Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ (боловсролын салбар)-ний төлөвлөгөөний төсөл: (ЗГХЭГ-т хүргүүлсэн төсөл: 2020.09.28-ний төсөл) нь ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг боловсролын түвшингүүд ба үйл ажиллагааны агуулгаар багцалсан тул маш олон давхцалтай, ижил түвшинд хэрнээ зарим нь хэт жижгэрч, зарим нь хэт томорсон агуулгын томъёололтой байна.

6.4.Бүх баримт бичгийн хувьд зорилт, үйл ажиллагаа, хүрэх үр дүнгийн томъёоллууд ихэнхи тохиолдолд эрэмбэлэгдээгүй, тоочсон шинжтэй, агуулга нь энд тэнд тарсан давхцсан байна.

6.5.Бүх баримт бичгийн хувьд “Хүрэх үр дүн”-үүдийн дийлэнх тохиолдолд хэмжигдэж, үнэлэгдэх боломжгүй, хэрэгжих магадлал нь тооцогдоогүй, хүлээн зөвшөрөгдөхүйц, тодорхой утгатай, хугацаатай байх шаардлагууд тавигддаг. Хүрэх үр дүнг тодорхойлохын тулд суурь түвшинг (нөхцөл байдал) тодорхойлж, түүнийг ямар түвшинд хүргэхийг тооцоолж, тодорхойлдог. Жишээ нь Мастер төлөвлөгөөний хүрээнд маш олон судалгааны үр дүнгүүдэд тулгуурласан тооцоолол хийсэн байх. Гэтэл хүрэх үр дүнг суурь түвшнээс хэдэн пункт ахиулж ямар ахиц гаргахаар томъёолсон нэг ч үр дүн алга. Уг төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөлт, эрсдлүүдийг тодорхойлоогүй байна.

7. Судалгаанд хамруулан авч үзсэн боловсролын салбарын урт ба дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийг багшлахуйн кластерийн

индикаторуудыг ашиглан судлах явцад хийгдсэн магадлан шинжилгээний бүх санал, зөвлөмжүүдийг дараах 3 түвшинд эрэмбэлэн гаргасан болно. Тухайлбал,

- 7.1. Судалгаанд бэлтгэсэн нийт өгөгдлөөс шууд болон дам хамааралтай гэж сонгогдсон 465 нэгж объект (Алсын хараа 2050-ороогүй) бүрээр гаргасан дэлгэрэнгүй санал, зөвлөмжүүд (Файл 2 ба 3-ын Файл 2 ба 3-ын “Коммент” sheet-үүд)
- 7.2. Дараах 3 төрлөөр ангилсан санал зөвлөмжүүд (Судалгааны тайлангийн 4.1, 4.2, 4.3 дэд бүлгүүд) Үүнд:
 - “Алсын хараа 2020-2050: Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого”-ын хүрээнд
 - “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” төвтэй баримт бичгүүдийн хүрээнд
 - Боловсролын салбарт хийгдсэн судалгааны
- 7.3. Судалгааны ерөнхий санал, зөвлөмжүүд (Судалгааны тайлангийн Дүгнэлт, зөвлөмж хэсэг)

Ерөнхий зөвлөмж

Судалгааны үр дүнд үндэслэн дараах ерөнхий зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. Засгийн Газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс бусад баримт бичгүүд хэдийнээ батлагдчихсан тул энэхүү төлөвлөгөөний төслөө сайжруулахад хүчээ төвлөрүүлэн ажиллаж, ойрын жилүүдийн зорилт, үйл ажиллагааг цэгцэлж, хүрэх үр дүнгүүдийг зохих шаардлагын дагуу нарийвчилах шаардлагатай. Энэ төлөвлөгөө оновчтой, цэгцтэй сайн болсноор боловсролын салбарын бүх түвшний мэргэжлийн болон сургалтын байгууллагын, тухайн байгууллагын нэгжүүдийн түүнчлэн төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагчдын төлөвлөгөө дээрээсээ доошоо нэвт эрэмбэлэгдсэн, уялдаа холбоотой болж байж бидний үр ашигтай, үр өгөөжтэй, тогтвортой ажиллагаа хангагдах гол хүчин зүйл хангагдана.

Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, түүнийг даган гарсан заавар, журмын дагуу Монгол Улсын төрийн удирдлагын бүтэц, зохион байгуулалтын бүх түвшний байгууллага, байгууллагын нэгжүүд төрийн жинхэнэ албан хаагч нэг бүр нэгдсэн дизайн, шаардлагын дагуу ажлаа төлөвлөдөг болж байна. Ийм нөхцөлд СӨБ, БДБ-ын салбарт ажиллаж буй 40 гаруй мянган багш нар төрийн үйлчилгээний албан хаагчид хамаарах боловч тэдэнд зориулан “Багшийн ажлыг төлөвлөх, үнэлэх, дүгнэх үлгэрчилсэн журам”-ыг батлан мөрдүүлэх нь онцгой ач холбогдолтой. Ингэж байж багш нарыг боловсролын урт, дунд хугацааны бодлого, төлөвлөлтөд анхаарлыг нь хандуулж, хүчин чармайлтыг нь төвлөрүүлж “Дуугарвал дуу нэг, дугтарвал хүч нэг” болж чадна. Учир нь сайн төлөвлөгөө бүх ажлын 50 хувь, маш сайн төлөвлөгөө 99 хувь байдаг гэж үздэг.

2. Аливаа салбарт хөгжлийн стратегийг боловсруулах, хэрэгжүүлэхэд кластер арга хандлагыг хэрэглэхийг чухалчлах болсны зэрэгцээ барууны оронд боловсролын салбарын тогтвортой хөгжлийг эртнээс эхлэлтэй “хөгжлийн кластер хандлага”-аар тайлбарласан судалгаа нэлээд хийгдэх болсон байна. Мөн МХХТ-ийн давуу талыг ашиглан мэдээлэл боловсруулах, статистик шинжилгээнд кластер анализын арга өргөн нэвтэрсэн байна. Тиймээс үндэсний боловсролын кластер боловсруулах, дэд

кластерууд (багшлахуйн кластер гэх мэт)-ыг оновчтой сонгож тодорхойлох чиглэлээр онол, арга зүйн судалгааг эхлүүлэх нь зүйтэй юм.

3. Энэхүү судалгаанд өгөгдсөн хэд хэдэн түвшний санал зөвлөмжүүд тухайлбал, ЗГҮАХ-т суурилсан бүтэц, дизайн бүхий санал зөвлөмжүүд (Хавсралт 2 болон дэд бүлэг 4.2)-ийг анхааралдаа авч, илүү бүтээлчээр шуурхай ажиллаж, ЗГАХТ-г даруй сайжруулж батлуулах нь зүйтэй. Улмаар сайжруулан батлуулсан ЗГАХТ болон Мастер төлөвлөгөөний хөтөлбөр, үйл ажиллагааг нарийвчлах замаар Салбарын жил бүрийн төлөвлөгөөг чамбай боловсруулан хэрэгжүүлэх нь зүйтэй.
4. “Чадварлаг багш”, “Боловсролын салбар дахь цахим шилжилт” “Сургууль, цэцэрлэгийн шинэ зураглал”, “Нэгдмэл үнэт зүйл-Сургалтын хөтөлбөр”, Үндэсний түвшний мэргэжлийн байгууллагуудыг кластер”, “Салбар хоорондын түншлэл”, “Чанарын үнэлгээ” зэрэг харилцан уялдаа холбоотой, харьцангуй бие даасан даасан хөтөлбөрүүдийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу боловсруулж, эрэмбэ дараалалтай хэрэгжүүлэхийг санал болгож байна.
5. Дээрх хөтөлбөрүүдийг боловсруулахдаа боловсролын шатлал, түвшнөөр дизайнчилахаас илүү тухайн үйл явц (ажиллагаа)-ны үе шатуудаар дизайнчилж, оноор хугацаажуулж, хүрэх үр дүнгүүдийг тооцоололд суурилан хэмжигдэхүйц, хэрэгжихүйц, гэх мэт бусад шалгуурыг хангуулах зайлшгүй хэрэгцээ байна.
6. Бид судалгааныхаа зорилго, үр дүн, арга зүй, арга аргачлалыг хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлагад нь аль болох нийцүүлэх бодлого баримталж ажилласан болно. Тухайлбал энэхүү судалгааны ажлын үр дүн, арга аргачлал (эксэл файлын автоматжуулалт)-ыг дараах чиглэлээр ашиглаж болох юм. Үүнд:
 - Боловсролын салбарын судалгаагаар өгч буй зөвлөмж, санал болгож буй стратеги нь боловсролын кластер (кластер хандлагыг баримтлаагүй үед ч тухайн сонгож тодорхойлсон тогтолцооны хувьд)-ийн аль түвшний ямар ямар индикаторт шууд, эсвэл дам хамааралтай талаар тухайд судлаачийн үндэслэл, нотолгоог тодорхой байлгахад
 - Бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тодорхойлсон бодлого, зорилго, зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь кластерийн аль түвшний ямар ямар индикаторт шууд, эсвэл дам хамааралтай талаар, мөн тэдгээрийн хоорондох уялдаа холбоог тодорхой байлгахад
 - Багшлахуйн кластер нь урт хугацааг хамарсан, олон байгууллага, субъектын олон талт харилцаанд суурилсан аварга том тогтолцоо учраас кластерийг үр дүнтэй хөгжүүлэх, мэдээллийн технологийн ололтыг ашиглаж, ажлыг хөнгөвчлөх (вэб суурьтай апп) боломжийг тодорхойлоход зэрэг болно.
7. Боловсролын бүх түвшний байгууллагын ялангуяа БШУЯ-ны хүний нөөцийг хөгжлийн бодлого, стратегийн төлөвлөлтийн арга зүйд сургах тусгайлсан арга хэмжээ авах нь салбарыг бүхэлд нь шинэ чиглэлд хөтлөхөд ихээхэн ач холбогдолтойг онцлон тэмдэглэж байна.

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Багилахуйн хөгжлийн кластер тогтолцоо

БК0.	Мэргэжлийн чиг баримжаа өгөх	
	БК0.1.	<i>Багш болох хүсэл, эрмэлзэл</i>
	БК0.2.	<i>Өөрийгөө таньж, олох боломж</i>
	БК0.3.	<i>Авъяас, чадамж (ability)-аа нээх боломж</i>
	БК0.4.	<i>Багшийн мэргэжлээр элсэхэд тавигдах шаардлагууд</i>
	БК0.5.	<i>"Багш" мэргэжлийн ухуулга, сурталчилгаа</i>
БК1.	Багш бэлтгэх сургуульд элсүүлэх	
	БК1.1.	<i>Элсэлтийн шалгалт</i>
	БК1.1.1.	Журам, дүрэм
	БК1.1.2.	Гүйцэтгэх даалгаврууд
	БК1.1.3.	Шалгалт авах дэд бүтэц, технологи
	БК1.1.4.	Шалгалтын үр дүнгийн боловсруулалт, тайлагнал
	БК1.2.	<i>Мэргэжлийн ИДС-ийн элсэлт</i>
	БК1.2.1.	Босго оноо
	БК1.2.2.	Элсэгчдийн тоо
	БК1.3.	<i>Хүйс, жендерийн асуудлууд</i>
	БК1.4.	<i>Суралцах арга хэлбэрийн сонголт</i>
	БК1.4.1.	Мэргэжлийн хослол, ангилал, зэрэглэл
	БК1.4.2.	Суралцах хэлбэрүүд
	БК1.5.	<i>Тэтгэлэг, дэмжлэг</i>
	БК1.5.1.	Сургалтын төлбөр, хөнгөлөлт, урамшуулал, бусад дэмжлэг
	БК1.5.2.	Дотуур байр
	БК1.5.3.	Унааны зардал, бусад
	БК1.5.4.	Хөдөлмөрийн зах зээлтэй холбох зохицуулалт
БК2.	Багш бэлтгэх	
	БК2.1.	<i>Сургалтын хөтөлбөр, түүний магадлан итгэмжлэл</i>
	БК2.1.1.	Сургалтын хөтөлбөрүүдийн төрөл, ангилал, сонголт хийх, мэргэжил, мэргэшлээрээ хөрвөх боломж
	БК2.1.2.	Цэцэрлэг, ЕБС-д ажиллах “Монгол багш”-ийн загвар, стандарт, багшийн хөтөлбөрүүд, тэдгээрт тавигдах шаардлагууд
	БК2.1.3.	Сургалтын хөтөлбөрүүд ба сургалтын байгууллагын магадлан итгэмжлэл, аттестатчилал
	БК2.1.4.	Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, СӨБ, БДБ-ын салбарт хийгдэж буй сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний шинэчлэл, өөрчлөлтийг хурдтай мэдэрч тусгах механизм
	БК2.2.	<i>Багилах дадлага</i>
	БК2.2.1.	Боловсролын мэргэжлийн байгууллагууд болон цэцэрлэг, дунд сургуулийн багш, ажилтнуудтай ажиллах хамтын ажиллагаа, судалгаа
	БК2.2.2.	Эрх зүйн зохицуулалтууд
	БК2.3.	<i>ИДС-ийн профессор багш нарын хангалт, хөгжил</i>
	БК2.3.1.	Боловсролын зэрэг, эрдмийн цол хэргэм
	БК2.3.2.	Судалгааны чиглэлүүд ба бүтээлүүд
	БК2.3.3.	Хамтын ажиллагаа түншлэл

БК2.4.	ИДС-ийн магадан итгэмжлэл, хөгжил	
	БК2.4.1.	Сургуулийн магадлан итгэмжлэл, ил тод, шударга өрсөлдөөн,
	БК2.4.2.	Гадаад, дотоодын холбогдох байгууллагууд хоорондын оюутан болон профессор багш нарын солилцоо
	БК2.4.3.	Номын сан, лаборатори, тоног төхөөрөмж, сургалт, судалгааны цахимжилт, дотуур байр кампус
	БК2.4.4.	Багш бэлтгэх их дээд сургуулиудын байршил, төрөлжилт
БК2.5.	“Багш” мэргэжилтний хангалт	
	БК2.5.1.	Багш мэргэжлийн ангилал ба ЮНЕСКО-ангиллын стандарт, олон улсад хүлээн зөвшөөрөгдөх байдал
	БК2.5.2.	Цэцэрлэг, сургуулийн байршил, хэмжээ, хэв шинжийн зураглал
	БК2.5.3.	Сургалтын хөтөлбөрүүдийн давхцал, хийдэл, элсэгчдийн тоо, мэргэжил, мэргэшлийн харьцаа
БК3.	Багшийг ажилд авах	
	БК3.1.	Ажилд ороход тавигдах шаардлагуудыг судлах
	БК3.1.1.	Боловсролын зэрэг
	БК3.1.2.	Эзэмшсэн мэргэжил, мэргэшил
	БК3.1.3.	Хууль тогтоомжоор заасан бусад шаардлагууд
	БК3.2.	Багшаар ажиллах хөдөлмөрийн харилцааны эрх зүйн орчинг судлах
	БК3.2.1.	Албан тушаалын тодорхойлолт
	БК3.2.2.	Хөдөлмөрийн гэрээ
	БК3.2.3.	Ажлын норм, норматив
	БК3.2.4.	Эрх үүрэг, сахилга хариуцлага, мэргэжлийн ёс зүй, эгэх хариуцлага,
	БК3.2.5.	Багшлах эрх, мэргэжлийн зэрэг
	БК3.2.6.	Ажлын төлөвлөлт, үнэлгээ
	БК3.2.7.	Цалин хөлс, нийгмийн халамж, хамгаалал
	БК3.2.8.	Сургалтын байгууллагад мөрддөг сургалтын төлөвлөгөө, сургалтын хөтөлбөр
	БК3.3.	Хөдөлмөрийн зах зээлээс ажлын байр олох
	БК3.3.1.	Хөдөлмөрийн биржид бүртгүүлэх
	БК3.3.2.	Суралцаж байх хугацаандаа багшлах дадлага хийсэн сургуультайгаа холбогдох
	БК3.3.3.	Боловсролын салбарын ажилд урьсан арга хэмжээнүүдэд оролцох
	БК3.3.4.	Ажлын байр зарласан сургалтын байгууллагуудын ярилцлага, арга хэмжээнд оролцох, гэх мэт
	БК3.4.	Ажилд орох
	БК3.4.1.	Ажилд томилогдсон тухай шийдвэр гаргуулах
	БК3.4.2.	Хөдөлмөрийн гэрээ байгуулах
	БК3.4.3.	Ажлаа хүлээн авах
	БК3.4.4.	Хамт олонтойгоо танилцах
БК4.	Багшаар ажиллах	
	БК4.1.	Мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах тогтолцоо
	БК4.1.1.	Хөгжлийн бодлого, зарчмыг бүтээлчээр хэрэгжүүлэхэд зориулагдсан сонирхогч талууд, хувь нийлүүлэгчдийн оролцоо түншлэлд суурилсан байх
	БК4.1.2.	Үндэсний, орон нутгийн, сургалт байгууллагын, хувь хүний түвшинг бүхэлд нь хамарсан бүтэц, бүрэлдэхүүн бүхий байх

	БК4.1.3.	Нээлтэй эрэлт-нийлүүлэлтэд суурилсан байх
	БК4.1.4.	Санхүүжилтийн болон хяналт-шинжилгээ, үнэлгээний оновчтой тогтолцооны механизм бүхий эрх зүйн зохицуулалтуудтай байх
	БК4.1.5.	Багшийн ажил нь боловсролын шаглал, түвшин (СӨБ, БДБ, г.м.) хоорондын залгамж холбоо, нээлтэй шилжилтүүдийг хангахуйц байх
	БК4.1.6.	Хууль, эрх зүйн орчны зохицуулалт нь багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжсэн байх
	БК4.1.7.	Багшлахуйтай холбоотой суурь болон хавсрага судалгаа, инновацууд
БК4.2.	<i>Насан туршийн суралцахуйг дэмжих арга механизм</i>	
	БК4.2.1.	Багш бүрт өөрийн хэрэгцээгээ үндэслэсэн сонголт хийх боломж олгосон байх
	БК4.2.2.	Мэргэжлийн хөгжлөө тасралтгүй хангаж байх зарчим хэрэгждэг байх
	БК4.2.3.	Нээлтэй эрэлт-нийлүүлэлтийн зохистой хувь, харьцаа бүхий механизмтай байх
	БК4.2.4.	Боловсролын удирдлагын мэдээллийн систем (БУМС)-д суурилсан байх
	БК4.2.5.	Цахим шилжилтэд интеграцिलाгдсан байх, гэх мэт
	БК4.2.6.	Бүх түвшний бүх төрлийн хичээлийн судалгаанууд (4.5.3-зөөж авчирсан)
БК4.3.	<i>Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх мэдлэг, ур чадвар (багшийн стандарт)</i>	
	БК4.3.1.	Мэргэшлийн шинжлэх ухаан дахь шинэ мэдлэг
	БК4.3.2.	Дидактик, сурган хүмүүжүүлэх ухаан дахь шинэ мэдлэг
	БК4.3.3.	ТХЗ-ын төлөөх ТХБ-ын агуулга, үнэт зүйл, ТХБ-ын цөм агуулга (тогтвортой хөгжил, хүний эрх, жендэрийн тэгш байдал, дэлхийн иргэний боловсрол)
	БК4.3.4.	Монголын нэгдмэл үнэт зүйл (түүх, хэл, соёл, зан заншил, үндэсний өв уламжлал, эх оронч сэтгэлгээ, ...)
	БК4.3.5.	Монгол бичиг, эх хэл
	БК4.3.6.	Цахим бичиг үсгийн боловсрол, гэх мэт
	БК4.3.7.	Цахим платформ ба шинэ лаборатор, тоног төхөөрөмжийн ашиглалт
БК4.4.	<i>Ялгаатай зорилтод бүлгүүдэд багшлах мэдлэг, ур чадвар</i>	
	БК4.4.1.	Ердийн хөтөлбөрөөр сургах
	БК4.4.2.	Мэргэжлийн чиг баримжаа эзэмшүүлэх хөтөлбөрөөр сургах
	БК4.4.3.	Гүнзгийрүүлэн сонгон суралцах хөтөлбөрөөр сургах
	БК4.4.4.	Хөгжлийн тусгай хэрэгцээтэй хүүхдэд багшлах
	БК4.4.5.	Малчдын болон эцэг эх, гэр бүлээсээ хол амьдарч, суралцаж буй хүүхдэд багшлах
	БК4.4.6.	Бага насны хүүхдийн асрах, багшлах
	БК4.4.7.	Гадаадад амьдарч, суралцаж буй болон шашины сургуулийн хүүхдэд багшлах
	БК4.4.8.	Дүйцсэн хөтөлбөрөөр сургах г.м.
БК4.5.	<i>Багш бэлтгэх, БМТХ-ийг хангах үйлийн төлөвлөлт, үнэлгээ, баталгаажилт</i>	
	БК4.5.1.	Багшаар бэлтгэж, багшлах эрх олгох, тэдний тасралтгүй хөгжлийг үнэлж, мэргэжлийн зэрэг олгох, зохиогчийн эрх олгох гэрчилгээжилт ба баталгаажилт
	БК4.5.2.	Сургалтын хөтөлбөрийн менежментийн циклийн хүрээнд багшийн ажлын гүйцэтгэл ба болон ур чадварын өсөлтийг үнэлэх шалгуур индикаторууд, арга аргачлал: сургалтын байгууллага, багш, сурагчийн үнэлгээний нийцэл
	БК4.5.3.	Багшийн ажлын төлөвлөлт, үнэлгээ, дүгнэлт

	БК4.5.4.	Мэргэжлийн болон сургалтын байгууллагын хүний нөөцийн хөгжлийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, чанарын дотоод ба хөндлөнгийн баталгаажуулалт
БК4.6.	<i>Багийнг тогтоон барих, багийн хангамж</i>	
	БК4.6.1.	Багш мэргэжилтэн, удирдах ажилтны эрэлт, нийлүүлэлтийн тооцоолол ба төлөвлөлт: хэрэгцээний прогноз, дутагдал, илүүдэл
	БК4.6.2.	“Багш” мэргэжлийн нийгэмд эзлэх байр суурь, үнэлэмж, нэр хүнд
	БК4.6.3.	МХТехнологи
	БК4.6.4.	Боловсролын салбарын зохион байгуулалтын бүх түвшний засаглал ба удирдлага
	БК4.6.5.	Ажиллах ба амьдрах орчин нөхцөл
	БК4.6.6.	Ажлын ачаалал, норм нормативийн мөрдөлт
	БК4.6.7.	Цалин хөлс ба урамшуулал
	БК4.6.8.	Гамшигийн үеийн менежмент, сургалтын байгууллагын орчин дахь осол, гэмтэл
	БК4.6.9.	Мерит системд тулгурласан хүний нөөцийн тогтвортой хөгжлийн бодлого
	БК4.6.10.	Сургуулийн зураглал: байршил, бүтэц, хэмжээ, хэв шинж, төрөл
БК4.7.	<i>Цалин хөлс, нийгмийн халамж хамгаалал, амьжиргааны түвшин</i>	
	БК4.7.1.	Үндсэн цалин
	БК4.7.2.	Нэмэгдэл хөлс: ЗАН, кабинет хариуцах, анги даах
	БК4.7.3.	Нэмэгдлүүд: бүсийн болон, орон нутгийн, нэрэмжит, мэргэжлийн зэргийн, ур чадварын, г.м.
	БК4.7.4.	Урамшуулал, шагнал, тэтгэмж
	БК4.7.5.	Хөнгөлөлтүүд. орон сууц, эрүүл мэнд, г.м.
	БК4.7.6.	Тэтгэлэг, хөнгөлөлтүүд
БК5.	<i>Тэтгэвэр тогтоож, ажлаас чөлөөлөх</i>	
	БК5.1.	<i>Хууль, тогтоомжийн дагуу төрөөс олгох тэтгэвэр, тэтгэмж авах</i>
	БК5.1.1.	Тэтгэвэр, тэтгэмжээ тогтоолгох
	БК5.1.2.	Тэтгэвэр тэтгэмжээ хэмжээ
	БК5.1.3.	Тэтгэвэр тогтоолгох хөдөлмөрийн нөхцөл
	БК5.1.4.	Тэтгэвэр тогтоолгох нас
	БК5.2.	<i>Хууль, тогтоомжийн дагуу төрөөс үзүүлэх дэмжлэгийг судлах, эдлэх</i>
	БК5.2.1.	Нийтийн тээвэр
	БК5.2.2.	Амралт сувилал
	БК5.2.3.	Эмчилгээ: нүдний болор, өвдөг, шүд солих, г.м
	БК5.2.4.	Хөдөлмөр эрхлэлт
БК6.	<i>Зөвлөгөө, туслалцаа авах</i>	
	БК6.1.	<i>Шаардлагатай тохиолдолд цагийн багшаар ажиллах</i>
	БК6.2.	<i>Ажиллаж буй багш нарт зөвлөн туслах (mentor)</i>
	БК6.3.	<i>Сургалт, судалгаанд оролцох</i>
	БК6.4.	<i>Бүтээл тууривах, ном, гарын авлага бичих, редакторлах</i>
	БК6.5.	<i>Боловсролын чиглэлээр эвсэл холбоонд нэгдэн бусадтай хамтран ажиллах г.м.</i>

Хавсралт 2. ЗГҮАХ-ийн зорилтуудыг багшлахуйн хөгжлийг дэмжсэн агуулгаар бүтэцчилсэн бүдүүвч

2.3.8. “ЧАДВАРЛАГ БАГШ” арга хэмжээг хэрэгжүүлж, мэргэжлийн стандартыг нэвтрүүлэн, үнэлэмжийг хөдөлмөрийн бүтээмж, гүйцэтгэлд суурилсан тогтолцоонд шилжүүлнэ	
2.3.13. Боловсролын хүрээлэнгийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчилж, чадавхийг дээшлүүлнэ.	
Боловсролын стандарт, Сургалтын хөтөлбөр	2.3.4. Монголын түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, шударга ёсны үзэл, хандлага болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн агуулгаар баяжуулсан монгол хүний хүмүүжлийг дээдэлсэн, монгол хүний онцлогт тохирсон зан чанар, хүмүүжил, сургалтын хөтөлбөрийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр цэцэрлэг, сургуульд хэрэгжүүлнэ.
	4.2.9. Үндэсний стандартуудыг олон улсын түвшинд нийцүүлж шинэчилнэ.
	2.3.3. ЕБ-ийн сургалтын чанарыг дэлхийн жишигт нийцүүлэх зорилгоор олон улсын PISA үнэлгээнд хамруулж, үндэсний чанарын үнэлгээний тогтолцоог бэхжүүлнэ.
	2.3.16. Олон улсад өрсөлдөх чадвартай боловсролын хөтөлбөрийг бий болгох эрх зүйн шинэтгэл хийж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
	2.3.11. Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн урлаг, биеийн тамирын хичээлийн агуулга, хөтөлбөрийг сайжруулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангана.
	4.2.7. Бүх нийтэд хүний эрх, жендэрийн боловсрол олгох үндэсний тогтолцоог хөгжүүлж, жендэрийн тэгш байдлыг хангах бодлого баримтална.
Цахимжилт	1.1.12. Цахим сургалтын платформ бий болгож, цахим агуулга хөгжүүлж, бэлтгэнэ. Зурагт болон интернэтгүй өрх, хүн амыг цахим сургалтад хамрагдах боломжийг бий болгохын тулд тохирсон сургалтын хэлбэр, хувилбаруудыг судалж, бэлтгэнэ.
	1.1.13. Цахим сургалтын тогтолцоог бий болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
	2.3.12. Цахим сургалтын платформыг хөгжүүлж, цахим сургалтын хөтөлбөрийг боловсруулан, цахим агуулга, цахим хичээл боловсруулан бүх насны иргэдэд насан туршдаа суралцахуйг дэмжих боломжийг бүрдүүлнэ.
	4.1.7. Бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ.

Ажлын үнэлгээ	<p>4.2.5. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.</p>
Цалин хөлс, урамшуулал, нийгмийн халамж, хамгаалал	<p>2.5.4. Хөдөлмөрийн зах зээлийг орчин үеийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн шинэчилж, бүтээмж, үр дүнд суурилсан цалин хөлс, ажлын үнэлгээний систем нэвтрүүлж, зайнаас болон цагаар ажиллах уян хатан зохицуулалт бий болгон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.</p> <p>2.5.1. Нийгмийн даатгалын шинэчлэл хийж, иргэн бүрд суурь тэтгэвэр олгох, хувийн даатгалын үйлчилгээнд хамрагдах боломж бүхий олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжинэ</p> <p>2.5.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны үлдэгдлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.</p> <p>2.5.5. Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг инфляц, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ.</p> <p>3.7.8. Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулж, орон сууцжуулах хөтөлбөрийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн шинэ зохион байгуулалтаар өргөжүүлэн хэрэгжүүлнэ.</p> <p>6.2.12. Сум, орон нутагт ажиллахаар анх удаа очиж байгаа багш, эмч, төрийн албан хаагчдыг орон байраар түр хангах цогц арга хэмжээг төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд авч хэрэгжүүлнэ.</p> <p>1.1.15. Багш, сурагч, сургуулийн ажилтнуудын эрүүл мэндийн эрсдэлийг тодорхойлж, сурагчийн сургууль завсардалтын эрсдэлийг тооцоолно.</p>
Ажилын шинэ орчин, ачаалал	<p>2.3.1. Яслийн үндэсний тогтолцоог сэргээж 1-2, хүүхэд харах үйлчилгээнд 2-3 насны хүүхдийг хамруулж, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.</p> <p>2.3.2. СӨБ-д хамрагдах хүүхдийн насыг 3-5 болгож, 5 настай хүүхэд бүрийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана.</p> <p>2.3.9.1. 273 цэцэрлэг ашиглалтад оруулах;</p> <p>2.3.9.2. 200 шинэ сургууль ашиглалтад оруулах; ашиглалтад оруулах;</p>
Түншлэл	<p>2.6.16 Үндэсний бахархал, монгол өв соёлыг өвлүүлж, олон улсын стандарт шаардлагад нийцсэн дараах барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулна: 2.6.1.1 Чингис хаан” хаад, язгууртны музейн шинэ барилга, бусад түүхэн газар нутагт баригдаж байгаа цогцолборууд; Байгалийн түүхийн музейн шинэ барилга; гэх мэт 2.6.1.3; 2.6.1.4; 2.6.1.5; 2.6.1.6; 2.6.1.7;</p>

НОМ ЗҮЙ

- Abdurashidovna, T. S. (2020). Factors affecting the Quality of Education and the Importance of the Education Cluster to Address them. *European Journal of Research and Reflection in Educational Sciences*, 8(4), 151-156.
- Aitbayeva, G. D., Zhubanova, M. K., Kulgildinova, T. A., Tusupbekova, G. M., & Uaisova, G. I. (2016). Formation of Education Clusters as a Way to Improve Education. *International Journal of Environmental & Science Education*, 11(9), 3053-3064.
- Blashfield, R. K., & Aldenderfer, M. S. (1988). The Methods and Problems of Cluster Analysis. J. R. Nesselroade, & R. B. Cattell (Хянд.)-Д, *Handbook of Multivariate Experimental Psychology* (Second хян., хууд. 966). New York, London: Plenum Press.
- Distefano, C., & Mindrila, D. (2013). Cluster Analysis. Т. Тео (Хян.)-Д, *Handbook of Quantitative Methods for Educational Research* (хууд. 404). Rotterdam, Boston, Taipei: Sense Publishers.
- Gaag, A. V., Medentsev, A. A., Demchenko, A. R., Kasatkina, N. E., Kostyukova, T. A., Malkova, I. Y., & Kharina, N. V. (2019). Educational Agro- Industrial Cluster as an Efficient Form for Advanced Multilevel Agricultural Education Aimed at Innovative Agrarian Practices. *Journal of Environmental Treatment Techniques*, 7(4), 823-827.
- Gryshova, I., Zamlynskyi, V., & Shestakovska, T. (2017). Implementing Cluster Forms into National Education Development Strategy. *Science and Education*(5), 57-62.
- Jita, L. C., & Mokhele, M. L. (2014). When teacher clusters work: selected experiences of South. *South African Journal of Education*, 2(34).
- Li, W., & Wang, Y. (2015). Research on the Performance Evaluation Model of Higher Education Teachers Based on the Improved Grey Clustering Analysis Method. *International Journal of Emerging Technologies in Learning*, 10(8).
- Mukhamedov, G. I., Khodjamkulov, U. N., Shofkorov, A. M., & Makhmudov, K. S. (2020). Pedagogical Education Cluster: Content and Form. *International Scientific Journal Theoretical & Applied Science*, 81(1), 250-257.
- БСШУСЯ, БХ, & ЮНЕСКО-үндэсний комисс. (2019). *Монгол улсын боловсролын суурь мэдээллийн тайлан*. Гоо дизайн ХХК.
- БШУЯ. (2020). *Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө: 2021-2030 (БСШУ-ны сайдын 2020 оны 10-р сарын ??? тоот тушаал)*.
- МУЗГ. (2020). *Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого-УИХ-д өргөн барьсан төслийн хувилбар*.
- МУЗГ. (2020). *Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” (ЗГХЭГ-т хүргүүлсэн төсөл: 2020.09.28)*.
- УИХ. (2020). *Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай (УИХ-ын 2020 оны 52-р тогтоол)*.
<https://www.legalinfo.mn/law/details/15406?lawid=15406>-ээс Гаргасан
- УИХ. (2020). *Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай (УИХ-ын 2020 оны 23-р тогтоол)*.
<https://www.legalinfo.mn/law/details/15584?lawid=15584>-ээс Гаргасан

УИХ. (2020). *Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр* (УИХ-ын 2020 оны 24-р тогтоол).

<https://www.legalinfo.mn/annex/details/11219?lawid=15586>-ээс Гаргасан

ЮНЕСКО. (2019). *Монгол улсын боловсролын бодлогын тойм шинжилгээ: Насан туршийн суралцахуйн тогтолцоог бүрдүүлэх нь*. Улаанбаатар.